

ЭДИЙН ЗАСГИЙН ГЭМТ ХЭРЭГТ ОНОГДУУЛАХ
ЯЛЫН ХЭМЖЭЭГ ИХЭСГЭХ НЬ
ANALYSIS IN THE LEGAL REGULATION OF CRIMINAL LIABILITY
(THE TYPE OF PUNISHMENT AND PENAL MEASURES)
FOR ECONOMIC CRIMES

Цагдаагийн хошууч Б.Батзаяа
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЭПЭЗТ-ийн ахлах багш,
(bbatzaya5181@gmail.com)

Batzaya.B (Police Major)
Senior Teacher, Criminal Procedure
Law Department, School of Police,
University of Internal Affairs

Хураангуй: Ямарваа нийгэмд хүмүүсийн нэг хэсгийг эрх мэдэл, эд баялгаар тэтгээд нөгөөг нь доройтуулан эрхшээх хүч үйлчилж байдаг бөгөөд ашиг сонирхлыг хэтрүүлсэн дүрэм журам тогтоож энэхүү хүчийг хазаарлан бүгдийг тэнш байлгах нь хуулийн зорилго юм. Гэмт хэрэгт оногдуулах ялыг зөвхөн хуулиар тогтоох бөгөөд тэрхүү хуулийг бүтээх эрх мэдэл зөвхөн гэрээний үндсэн дээр байгуулагдсан нийгмийн төлөөлөгч болох хууль тогтоогчид хадгалагддаг. Харин нийгэм хувьсан өөрчлөгдөж зах зээлийн нийгэмд Монгол улс 1992 онд шилжсэн тэр үеэс эдийн засгийн гэмт хэрэг биежэн бүтцэд орж эхэлсэн бөгөөд өнөөдөр бүхэл бүтэн улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хэмжээд хүрчээ. Эдийн засгийн гэмт хэрэг нь улс төрийн хүрээнд үүрлэх нь улсын хөгжлийн бодлогыг алдагдуулж, тууштай бодлого хэрэгжилтийг зогсоож, хөгжилд хүрэх замд том саад болж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, урьдчилан сэргийлэх оногдуулах хариуцлагын механизм чангатгах зайлшгүй шаардлага бий болоод байна.

Монгол Улс Үндсэн хуулиндаа хүмүүнлэг иргэнийардчилсан нийгмийг цогцлоон бүтээхийг удирдлага болгосон хэдий ч гэмт хэргийг тогтоон барихад ялангуяа улс үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн гэмт хэрэгт ялын хатуу бодлого нь гарцаагүй чухал. Энэхүү өгүүлэлд эдийн засгийн гэмт хэргийн талаар ойлголт, Монгол Улсад үйлдэгдсэн эдийн засгийн гэмт хэрэгт оногдуулах эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал болон Монгол Улс болон ОХУ-ын Эрүүгийн хууль тогтоомжид тусгагдсан зохицуулалтыг харьцуулж, ялын бодлогыг нэмэгдүүлэх талаар судлаачийн байр суурийн талаар товч тусгасан болно.

Abstract: Aim of law is to strengthen the equity for all after limiting the power and regulate it through adopting rules and procedures for over-interest due to some people have been maintained by the power and properties; others have weakened and frightened from the power in every society. The punishments of criminal cases are only determined by the law and the power to create the law held by the lawmakers, who are the social representatives that are founded on the basis of treaties and contracts.

In Mongolia, where aims to create civic and humanitarian democratic society that indicated in the constitution but it needs punishment harsh policy for crimes that threat to the national

security in order to detection of the crimes. In the research, I specified about the understanding of economic crimes, the present situation of legal regulation for economic crimes in Mongolia and brief status of the researchers, who want to improve the punishment policy for making regulatory comparisons in the Criminal Codes between of Mongolia and Russia.

Түлхүүр үг: Эдийн засгийн гэмт хэрэг, мөнгө угаах, татвараас зайлсхийх, үнэт цаас
Key words: Economic crimes, Money laundering, Tax evasion and Securities market

Эдийн засгийн гэмт хэргийн тухай ойлголт. Эдийн засгийн гэмт хэрэг бол эрүүгийн гэмт хэргийн нэгэн төрөл ойлголт бөгөөд энэ төрлийн гэмт хэрэг нь зөвхөн гэмт хэргийн хохирогчид мөнгөн хохирол учруулаад зогсохгүй тухайн үндэстний эдийн засагт ноцтой гарз учруулж байдаг гэмт хэрэг юм.

Эдийн засгийн гэмт хэргийн тодорхой төрлүүд болох улсын мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдвэрлэх, санхүүгийн залилан, мөнгө угаах, компьютер, мэдээллийн гэмт хэрэг зэрэг нь аливаа үндэстний аюулгүй байдал, засаглалын асуудлын хэмжээнд нөлөөлж чадахуйц ноцтой хэргүүд байдаг. Эдийн засгийн гэмт хэргийг дотор нь цагаан захтны болон цэнхэр захтны гэмт хэрэг гэж 2 ангилдаг байна. ' Цагаан захтны гэмт хэргийг нийгмийн дээд зиндаанд хамаарах, өндөр зэрэглэлийн албан тушаал, эрх мэдэл бүхий цагаан захтай цамц өмссөн баян чинээлэг хүмүүс үйлддэг бөгөөд энэ нэр томъёог 1939 онд АНУ-ын социологич Эдвин Сюдэрланд гаргаж ирсэн байна. Эдийн засгийн гэмт хэргийн нөгөө хэсэг нь цэнхэр захтны гэмт хэрэг буюу гудамжны гэмт хэргүүд юм¹.

Цагаан захтны гэмт хэрэг. Цагаан захтны гэмт хэрэгт залилан, татвараас зайлсхийх, авлига, хээл хахууль өгөх, өмч хөрөнгө ашиглан шамшигдуулах, компьютерийн гэмт хэрэг, зохиогчийн эрхийг хууль бусаар ашиглах, мөнгө угаах, таних тэмдэг болон лого хулгайлах, баримт бичиг хууль бусаар хуулбарлах, хөрөнгийн зах зээл, үнэт цаасны залилан, дотоод мэдээллийг худалдах, зах зээлийг төөрөгдүүлэх гэх зэрэг гэмт хэргүүд хамаардаг. Өнөөдөр дээрх төрлийн гэмт хэргийг үйлдэж буй этгээдүүд нь материаллаг болон санхүүгийн асар их нөөцтэй болж, гэмт хэргийн хүрээлэл нь мэдлэг боловсролтой, гадаад дотоодод сүлжээ сайтай, үйл ажиллагаандаа мэргэжлийн хуульчдыг татан оролцуулсан, сайн өмгөөлөгчдөөр хамгаалуулсан, тэр тусмаа хууль хяналтын байгууллагад өөрсдийн төлөөлөлтэй болсон, зарим тохиолдолд жлс төрийнхний хүчтэй лобби орсон шинжтэй болсон ба эдгээр нь бүхэл бүтэн үе давхарга болон эхэлж байна.

Эдийн засгийн гэмт хэрэг нь пирамид хэлбэрт орсон нь ажиглагдаж байна. Тодруулбал бохир бизнес хийдэг иргэд аж ахуйн нэгжүүд болон тэднээс авлигаа бэлнээр авдаг доод шатны албан тушаалын алба хаагчид нэг хэсэг. Дунд шатанд нь тендер шалгаруулагсад буюу төрийн мөнгөөр захиалга хийх эрхээр хангагдсан төсөв захирагчид, элдэв зөвшөөрөл олгох эрх бүхий дарга нар болон " мөнгө угаадаг томоохон аж ахуйн нэгжүүд", дээд хэсэгт нь доод дунд шатныхныг зохих газарт нь томилон байршуулж тэднээр дамжуулан өөрсдийн ашиг сонирхлыг хэрэгжүүлдээг эрх мэдэлтнүүд байна.

Эдийн засгийн гэмт хэрэг нь өөрөө эдийн засгийн гажуудлыг үүсгэж, эдийн засгийн салбарт сөргөөр нөлөөлж, үүгээр төрд итгэх итгэлийг алдагдуулж, улс төрийн асуудал болдог. Нөгөөтэйгүүр уг гэмт явдлын дүнд бий болсон эдийн засгийн таагүй орчин нь гадаадын хөрөнгө оруулалтыг үргээж манай орны дэвшил хөгжил гадаад харилцаанд сөргөөр нөлөөлж, гадаад харилцаанд хохирол учруулдаг сөрөг явдал юм.

¹ Д.Эрдэнэсүрэн. Эдийн засгийн гэмт хэрэг. УБ. 2017.

Далд эдийн засаг буюу теневая экономика, shadow economy, underground economy гэх үг нь 1930-иад оны үеэс эрчимтэйгээр нэвтэрч эхэлсэн байна. Өөрөөр хэлбэл АНУ-ын зах зээл дээр Италийн Сицили арлаас мафийн сүлжээ ноёрхож эхэлсэн тэр үеэс бий болсон байна. Далд эдийн засгийн салбараар томоохон судалгааны бүтээлүүд мөн энэ үеэс бий болж эхэлсэн байна. Харин 1970-иад ны үед эдийн засагчид тусгайлан эл сэдвийг тусган авч хөндсөн байдаг. Тухайлбал АНУ-ын эрдэмтэн, эдийн засаг Г.Гутмани далд эдийн засгийн үйл ажиллагааг эрчимтэйгээр судалсан байх юм.

Далд эдийн засаг гэдэг нь төрийн хяналтад үл хамаарах эдийн засгийн үйл ажиллагааны төрөл болно. Өөрөөр хэлбэл эдийн засгийн зүй бус, хууль тогтоомжоор хориглосон, тооцож үл болох бараа үйлчилгээний нийлүүлэлтийг далд эдийн засаг гэнэ. Орлогоо нуун дарагдуулсан, эсвэл татварын хараа хяналтаас зайлсхийсэн үйлдвэр худалдаа эрхлэгчид нь далд эдийн засгийг бий болгодог байна².

Эдийн засгийн гэмт хэрэг ба Монгол Улсын эрх зүйн зохицуулалт.

Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуулийн 7 дугаар хэсэгт эдийн засгийн гэмт хэргийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг болон аж ахуйн эсрэг гэмт хэрэг хэмээн хуульчилж, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт 13, аж ахуйн эсрэг гэмт хэрэгт 25, нийт 38 гэмт хэргийг хамруулсан байна.

Шинэчлэн нарийуулсан 2015 оны Эрүүгийн хуулийг 2017 оны 7 сарын 1-ны өдрөөс эхлэн даган мөрдөж байгаа бөгөөд 2002 оны Эрүүгийн хуулийг шинэчлэх нэг шаардлагабол орчин үеийн нийгмийн харилцаанд гарч байгаа шинэ төрлийн гэмт хэргийг хуульчлах явдал байсан. 2015 оны Эрүүгийн хуулийн 18 дугаар бүлэгт "Эдийн засгийн гэмт хэрэг" гэсэн бүлгийг шинээр оруулсан байна³.

Эдийн засгийн гэмт хэрэг⁴ /18-р бүлэг/

- 18.1 Зах зээл дэх монополь, давамгайл байдлаа хууль бусаар ашиглах,
- 18.2 Валют, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид нөлөөлөх, 18.3 Татвар төлөхөөс зайлсхийх,
- 18.4 Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загварын гэрчилгээ эзэмшигчийн эрхийг зөрчих,
- 18.5 Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх,
- 18.6 Мөнгө угаах,
- 18.7 Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх ашиглах, 18.8 Үнэт цаасны зах зээлийн дотоод мэдээллийг хууль бусаар ашиглаж, арилжаанд оролцох,
- 18.9 Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах,
- 18.10 Зориуд, зохиомлоор дампуурах,
- 18.11 Хууль бусаар дампууруулах,
- 18.12 Хууль бусаар ниймгийн халамж үйлчилгээ авах,
- 18.13 Банк хууль бусаар байгуулах, банкны төлбөрийн чадвар алдагдуулах,
- 18.14 Нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх
- 18.15, Хууль бусаар даатгалын нөхөн төлбөр авах,
- 18.16 Барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгчийн эрхийг зөрчих,
- 18.17 Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчих,

²Гэмт хэргийг танихуй. Крис Матрес.

³ Эдийн засгийн гэмт хэрэг ба Монгол улсын эрх зүйн зохицуулалт. УБ., 2017он.

⁴ Монгол Улсын Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл.

• 18.18 Үндэсний төлбөрийн системд холбогдох үйл ажиллагаа хууль бусаар эрхлэх
Оросын холбооны улсын эрүүгийн хуульд эдийн засгийн гэмт хэргийг хуульчилсан байдал

ОХУ-д 1996 онд батлагдсан бөгөөд түүнээс хойш 30 орчим удаа нэмэлт өөрчлөлт орсон, ерөнхий болон тусгай 12 бүлэг, 34 дэд бүлэг нийт 360 зүйл ангиас бүрдсэн Эрүүгийн хууль үйлчилдэг байна.

Орчин цагийн Эрүүгийн эрх зүйн түүхэн уламжлал хөгжлийн хувьд манай улсын эрүүгийн хуулийн агуулга, бүтэц, шинж чанар нь хуучин ЗХУ-ын Эрүүгийн хуулиас улбаалан түүнтэй ихээхэн ижил төстэй хөгжиж ирсэн ба зарим нэг онцлогийг эс тооцвол гэмт хэргийн шинжийг тодорхойлж ирсэн хандлага нь хоёр улсын хууль адил зүйл ихтэй. ОХУ-ын Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт Эдийн засгийн хүрээний гэмт хэргүүдийг тодорхойлсон бөгөөд дотроо Өмчийн эсрэг, Эдийн засгийн хүрээний болон Аж ахуй бизнесийн байгууллагын эрх ашгийн гэмт хэрэг гэсэн 3 бүлэгт хуваан хуульчилсан байна. Эдгээр 3 бүлэгт 50 гаруй гэмт хэрэг тусгагдсан байна.

Хүснэгт №1

Монгол Улс	ОХУ
Татвар төлөхөөс зайлсхийх 1. Татвар төлөгч нь хүн, хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан татвар төлөхөөс зайлсхийх зорилгоор их хэмжээний татвар ногдох орлого, эд хөрөнгө, бараа үйлчилгээг зориуд худал тодорхойлсон, нуусан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.	Татварын тайлан болон холбогдох баримт бичигт худал мэдээлэл оруулах замаар татвараас зайлхийсэн бол гэмт хэрэгт тооцох, мөн хувь хүний төлөөгүй татварын хэмжээ сүүлийн 3 жилийн хугацаанд 600.000 рубль бол их хэмжээтэй, мөн 3 жилийн дүнгээр 3.0 сая рубль төлөөгүй бол онц их хэмжээтэй байх, харин аж ахуйн нэгжийн тухайд дээрх хэмжээ нь 2.0 сая рубль бол их хэмжээ, 10.0 саяаас их бол онц их хэмжээ гэж тооцохоор заасан байна.
Мөнгө угаах НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 сарын 15ны өдөр баталсан үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцид заасан агуулгаар гэмт хэргийн шинжийг тодорхойлсон. УИХ-аас 2006 оны 7сарын 8-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг баталж, 2008 оны 2дугаар сарын 1ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулиар шинээр гэмт хэрэг болгон хуульчилсан.	Мөнгө угаах гэмт хэргийн шинжийг ОХУ-ын Эрүүгийн хуулийн 174 дүгээр зүйл болон 174.1 дүгээр зүйлүүдэд тодорхойлохдоо субъектийн шинжээр буюу бусдын гэмт хэргийн замаар олж авсан мөнгөн хөрөнгө, эд зүйлийг хууль ёсны болгох(угаах), гэмэн хоёр тусдаа гэмт хэрэг болгон хуульчилсан байна ⁵ .

Монгол Улс дахь эдийн засгийн гэмт хэргийн нөхцөл байдал.

⁵ Эдийн засгийн гэмт хэрэг ба Монгол улсын эрх зүйн зохицуулалт. УБ.,2017он.

Дэлхий дахинаа “Их долоо” гэж нэрлэгдсэн улсууд 1989 онд ФАТФ буюу Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага /Financial Action Task Force/-ыг байгуулсан.

Парист төвтэй уг байгууллага дэлхийн улс орнууд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй хэрхэн тэмцэж байгааг судалж, зөвлөмж өгч ажилладаг. Тэд улс орнуудын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогыг 49 шалгуур, үзүүлэлтээр дүгнэдэг ажээ. Үүнийг бид ФАТФ-ын зөвлөмж гэж нэрлэдэг. Тус байгууллагаас өгсөн зөвлөмжийг улс болгон биелүүлэх үүрэг хүлээдэг. Хэрвээ ФАТФ-аас өгсөн зөвлөмжийг биелүүлж чадахгүй, эсвэл биелүүлэхээс татгалзвал тухайн улс орныг “эрсдэлтэй”, эсвэл “өндөр эрсдэлтэй” гэж дүгнэдэг.

Энэ нь тухайн улстай санхүүгийн хувьд харилцаа тогтоохгүй байсан нь дээр. Яагаад гэвэл энэ улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх стратегиа боловсронгуй болгоогүй учраас бохир мөнгө шилжүүлэх магадлалтай байна гэсэн санамж юм. Энэ байгууллагаас гаргасан зөвлөмжийг дэлхийн бүх банк, санхүүгийн байгууллага, санхүү, гааль, хилийн зохицуулагч байгууллага дагадаг бөгөөд тус байгууллагаас зарласан жагсаалтад орсон улс орнуудтай холбоотой банк, санхүү, бизнес, зээлийн харилцаанд холбогдох хориг арга хэмжээг авдаг.

Иймээс ФАТФ-ын хар жагсаалтад багтана гэдэг бол эдийн засгийн хувьд аль ч улсад хохиролтой учраас ФАТФ-аас өгсөн зөвлөмжийг биелүүлэхээс аргагүйд хүрдэг байна. Зөвлөмжийг биелүүлснээр тухайн улс эргээд бохир мөнгөний урсгалаас санхүүгийн системээ хамгаалж, дархлаатай болдог. Тус байгууллагаас анх 2007 онд Монголд шалгалт явуулжээ. Тэгэхэд бид ФАТФ-ын 49 шаардлагаас 15-д нь муу, 21-д нь дунд үнэлгээ авчээ. Өөрөөр хэлбэл, 49 зөвлөмжийн 36-г нь хангалтгүй биелүүлсэн байна хэмээн дүгнэжээ.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) 2019 оны аравдугаар сарын 18-ны өдөр Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу “саарал” жагсаалтад оруулсан.

Тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний дүнд Монгол Улс бусад улс орнуудтай харьцуулахад хамгийн богино хугацаанд буюу нэг жилийн дотор “саарал” жагсаалтаас гарч чадсан улс болсон. Энэ нь улс төрийн өндөр түвшний дэмжлэг, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сайн байсны үр дүн гэж шинжээчид дүгнэдэг.

Монгол Улсыг 2020 оны аравдугаар сарын 1-ний өдөр Европын Холбооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалт буюу “хар” жагсаалтад оруулсан. ФАТФ-аас Монгол Улсыг саарал жагсаалтаас гаргасан болон төрийн байгууллагуудын Европын комисстой хамтран ажилласны үр дүнд 2021 оны нэгдүгээр сарын 18-ны өдөр 2015/849 тоот тогтоол гаргаж, Монгол Улсыг Европын холбооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтаас хассан.

Монгол Улс цаашид хар, саарал жагсаалтад орохгүйн тулд ФАТФ-аас гаргасан олон улсын стандарт, зөвлөмжүүдийг дагаж мөрдөх, хууль эрх зүйн орчноо тогтмол шинэчлэх, хэрэгжилтийг хангах шаардлагатай юм.

Хөгжлийн банк ба мөнгө угаах гэмт хэрэг.

Монгол Улсын Засгийн газар 2010 оны 7 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Хөгжлийн банкиг байгуулахаар шийдвэрлэсэн. Үүний дараагаар Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталж, Хөгжлийн банкиг Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг

санхүүжүүлэх зорилго бүхий үйл ажиллагааг эрхлэх тусгайлсан чиг үүрэгтэй, ашгийн төлөө, төрийн өмчит хуулийн этгээд байхаар уг хуульд зааж өгсөн.


Хөгжлийн банкны үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэс бүрэлдэн тогтсон Монгол Улсын Хөгжлийн банк /МУХБ/ 2011 оны 05 дугаар сарын 12-ны өдөр албан ёсоор нээлтээ хийж үйл ажиллагаагаа эхлүүлсэн байдаг.

Хөгжлийн банкнаас олгосон зээлийг эргэн төлөөгүй, "Чанаргүй" гэсэн ангилалд орж, улмаар шүүхээр нэхэмжилсэн компаниудыг 2022 оны 1 сарын 22-ны өдөр зарласан. Монгол Улсын Хөгжлийн банкны олгосон нийт зээлийн 55.3 хувь нь чанаргүй зээлийн ангилалд оржээ. 2014-2019 онд ийнхүү зээл аваад төлөөгүй 26 компанийг Хөгжлийн банк шүүхэд өгч, 841 тэрбум төгрөгийн нэхэмжлэл гаргасан байна.

2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар нийт 159,389,484,088 /Нэг зуун тавин есөн тэрбум гурван зуун наян есөн сая дөрвөн зуун наян дөрвөн мянга наян найм/ төгрөгтэй тэнцэх хэмжээний зээлийн эргэн төлөлт хийгдээд байна.

Зээлийн ангиллаар авч үзвэл хэвийн зээлдэгчийн ангилал дахь зээлийн эргэн төлөлт 28,156,373,362 төгрөг, анхаарал хандуулах ангиллын зээлийн эргэн төлөлт 62,319,000,692 төгрөг, чанаргүй зээлийн ангиллын зээлийн эргэн төлөлт 35,760,039,067 төгрөг тус тус төлөгдөөд байна. Мөн хэвийн зээлдэгчээс 2 зээлдэгч бүрэн төлөлт хийж, нийт 7 зээлдэгчийн 33,154,070,965 төгрөгийн зээлийн эргэн төлөлт бүрэн төлөгдөж, гүйлгээний данс хаагдсан.

График №1



Дүгнэлт. Хүн бүр эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй. Энэ эрхийг төр хангах учиртай атал өнөөдөр Монгол улсын эрүүл мэнд, боловсролын салбар төдийгүй улсын дэд бүтэц тодруулбал цахилгаан, эрчим хүч, зам тээвэр түгжрэл элгээрээ хэвтэхэд ойрхон байна. Ард иргэд туйлдаж, залуус гадагшаа дүрвэж, Монгол улсын эдийн засаг хүндэвтэр байдалтай сэхээний тасагт хэвтэж байна.

Улсдаа хоёргүй сэтгэээр зүтгэж байгаа иргэдийн төлж буй татвар цагаан захтны халаасанд, үлдсэн нь салхинд хийсэж байгааг бид бүгд харж байна. Цаашлаад ямарваа нэг улсын хараат болохвий гэх айдас байгааг нуугаад юун. Иймд бид хариуцлагыг нэжэж, тооцож, шийдвэрлэхийг шаардаж, далд эдийн засгийг устгаж, ирээдүйд хөгжингүй улс болох зорилгыг бид тавих ёстой юм

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Тухайлбал:

1. Төрийн улс төрийн албанд хөрөнгө оруулгын мэдээллийг ил тод нээлттэй байлгах

2. Авлига албан тушаалын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тооцохгүй байх
3. Монгол улс эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг бүх улс оронтой байгуулж гэмт хэрэгт холбогдсон иргэнийг татаж авах ажлыг шуурхай гүйцэтгэх
4. Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх тэмцлийг хэлбэрдсэн байдлаас гаргуулж, олон нийтийн анхаарлыг хандуулах
5. Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагад онц бүрэн эрх олгох
6. Улсад онц их хэмжээний хохирол учруулсан хэрэгт хялбаршуулсан журмаар шийдвэрлэхгүй байх
7. Өршөөлийн тухай хуульд эдийн засгийн гэмт хэргийг хамруулахгүй байх

Ашигласан материал

1. Д.Эрдэнэсүрэн. Эдийн засгийн гэмт хэрэг. Уб. 2017.
2. Эдийн засгийн гэмт хэрэг ба Монгол Улсын эрх зүйн зохицуулалт. Уб. 2017.
3. Монгол Улсын Эрүүгийн хууль.
4. Монгол Улсын хөгжлийн банк албан ёсны сайт.

МОНГОЛ УЛСАД ХАР ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ НЭВТЭРСЭН НЬ
DRUG USAGE SPREAD IN MONGOLIA

Г.Өлзийбуян
ДХИС-ийн магистрант,
цагдаагийн хошууч
/ulziicontact@gmail.com/

G. Ulziibuyan
University of Internal Affairs
police major
/ulziicontact@gmail.com/

Товчлол: Хүн хөгжлийнхөө эхэн буюу ан ав хийхээс өмнө /Юваль Ной Хараригийн томьёолсноор “Танин мэдэхүйн хувьсгал”⁶/ үед айдас түгшүүрээс түр зуур ангижрах, “сүнстэй харьцах”, “хүч чадал” олох зэрэг зан үйлдээ ч хүнсний гол хэрэглээ болсон ургамал, үр жимс, тариа, буудайг ашиглан “мансуурч” байсан байж болох юм. Гэвч үүнийг өнөөдрийн бидэнд олдсон археологийн болон бусад олдвороос илрүүлэх бараг боломжгүй учир таамаглахаас өөр аргагүй. Харин Перугийн уугуул овог болох Инкачууд өргөл болгох хүнээ кокайны навчаар мансууруулдаг байсан нь цаг хугацааны хувьд анхдагч биологийн дээж болон хадгалагдаж байна.

Эфирийн тос /ихэнх эфирийн тос бактери, вирусийн эсрэг, ариутгах, тайвшруулах, эрч хүч өгөх нийтлэг шинж чанарыг агуулдаг/ агуулсан ургамал /бамбайн үндэс, өндөр зоосон цэцэг, далийн ягаан цэцэг гэх мэт/-ын найрлага, тайвшруулах үйлчилгээ, түүний хүнд үзүүлэх нөлөөллийг таньж мэдсэн мэдлэг дээр уламжлан утах⁷, үнэртэх хэлбэрээр төв мэдрэлийг тайвшруулах, бөөрний өвдөлтийг намдаах, мэдрэлийн үйл ажиллагааны хямралыг эмчлэхэд хэрэглэдэг байжээ.⁸

Энэтхэгийн иогч, циркийн гэж хэлж болохуйц үзүүлбэр үзүүлэгч нар нь дасгал сургуулилтын үед өвчнөө тэсэж гарах, даван туулах зорилгоор энэ төрлийн бодисыг хэрэглэж байсан баримт байна.

Химийн шинжлэх ухааны үсрэнгүй хөгжлийн үр дүн, олон удаагийн дайн, байлдааны явцад хүн төрөлхтөн унтуулдаг, мэдрэл алдуулдаг⁹ бодисыг нээн, хүнд нөлөөлөх нөлөөллийг танин мэдэж, ашиглаж эхэлсэн ч мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарал, донтолтын хор нөлөөг тун хожуу мэдэрч, өнөөдрийг хүртэлх хугацаанд бүхий л чадлаараа хяналтдаа байлгахыг зорьж байгаа болон Монгол Улсад хэрхэн нэвтэрсэн талаар энэхүү өгүүлэлд товч дурдсан болно.

Abbreviation: At the beginning of human development, before hunting / according to Yuval Noi Harari's "Cognitive Revolution", plants and fruits were the main food used for rituals such as temporary relief from anxiety, "contact with spirits", and "finding strength". , may have been "intoxicated" using grain and wheat.

⁶ Юваль Ной Харари. Sapiens Хүн төрөлхтний товч түүх. Уб. 2017.

⁷ Эфирийн тосны эмчилгээний хэд хэдэн арга байдгийн хамгийн эртний уламжлалтай нь, халаасан эфирийн тосны уурыг үнэртэх арга юм. (Aromatherapy)

⁸ Пүрэв Т. Монголын уламжлалт анагаах ухаан. Уб. 2001.

⁹ Орчин үеийн мэдээ алдуулалтыг 1846 онд анх хийсэн өгөөд үүнээс өмнө цөөн хэдэн хагалгааг өвдөлт намдаахгүйгээр эсвэл опиум эсвэл согтууруулах ундаа хэрэглэсний дараа хийдэг байжээ.

But it can only be guessed because it is almost impossible to detect it from the archaeological and other finds we have today.

But the Incas, a native tribe of Peru, intoxicated their sacrificers with cocaine leaves, which has been preserved as a primitive biological sample in time.

Essential oils (most essential oils share the common properties of antibacterial, antiviral, antiseptic, soothing, and energizing) and their composition, calming properties, and effects on humans. It was used to relax the central nervous system, relieve kidney pain, and treat nervous disorders by smoking and smelling it.

There is evidence that Indian yogis and circus performers used this type of substance in order to survive and overcome illness during exercise.

As a result of the rapid development of chemical science, during many wars and battles, humans discovered sleeping and nerve-numbing substances, recognized their effects on people, and began to use them, but felt the effects of dependence and addiction to narcotic drugs and psychoactive substances very late, until today. I intend to keep it under control with all my might.

Түлхүүр үг. Мансуурал, таамаглал, биологийн дээж, эфирийн тос, мэдээгүйжүүлэлт, сэтгэцийн тогтворгүй байдал, донтогч, түүхийн таамаглал, танин мэдэхүй, нүүдэлчин соёл, түүхийн эх сурвалж, намуу цэцэг, мансууруулах ургамал, мансууруулах эм, мансууруулах бодис, газар тариалан, үйл явдлын уялдаа, эрх зүйн хэрэгцээ, экосистем,

Key word. Addiction, speculation, biological samples, essential oils, anesthesia, mental instability, addicts, historical speculation, cognition, nomadic culture, historical sources, poppy, narcotic plant, narcotic drug, narcotics, agriculture, nexus of events, legal needs, ecosystems,

Үндсэн хэсэг. Хүн химийн бодисыг тогтмол хэрэглэснээр түүнээсээ хамааралтай болох, өөрөөр хэлбэл донтох, донтох өвчтэй болох нь өнгөн талаасаа тухайн хүний эрх, эрх чөлөөний асуудал, төрөөс зохицуулалт хийх шаардлагагүй мэт боловч бодит байдлаараа тухайн донтогч нь донтсон үедээ бусад дагалдах эрсдэлт зан үйлийг үйлдэж байдаг, улмаар нийгэмд болон өөртөө олон сөрөг үр дагавар учруулдаг нь анхаарах ёстой асуудал юм.¹⁰

Монгол Улсад үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу хориглосон мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын агууламжтай ургамал, бэлдмэл, бодисыг энгийн ярианд “хар тамхи” гэж хэлж нэршсэн.

Анагаахын шинжлэх ухаанд “мансууруулах сэтгэцэд нөлөөт бодис” гэдэг нь тухайн бодисыг хэрэглэсэн хүн болон амьд организмын уураг тархи буюу төв мэдрэлийн системд дарангуйлал үүсгэн үйлчилж, мансуурал гэж нэрлэх сэтгэцийн тогтворгүй байдлыг үүсгэх чадвартай эм бэлдмэл бодисуудыг хэлнэ.

Нийгмийн шинжлэх ухаанд аливаа мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл, бодисыг хэрэглэсэн этгээдийг зан үйлийн болон ёс суртахууны зөрчил рүү түлхэн, гэмт хэрэг үйлдэх нөхцөл бололцоог бий болгож, улмаар нийгэмд хор хохирол учруулах чадвар бүхий бодис, түүнийг агуулсан эм бэлдмэлийг хэлнэ гэж тус тус тодорхойлсон байдаг.

Монгол Улсаар аялж байсан Марко Поло /1260-1299 он/, Н.Я.Бичурин /гэлэн Иакинф /1821 он/, Н.М.Пржевальский /1870-1873 он/, Жеймс Гилмор /1870 он/, П.К.Козлов /1899-1901, 1907-1909 он/, Эдгард фон Хартман /1919-1920 он/, И.М.Майский 1919-1920/, Хеннинг Хаслунд Кристенсен /1927-1930 он/ нар өөрсдийн аялалын тэмдэглэлдээ Монгол орон,

¹⁰ Хууль зүйн үндэсний хүрээлэн. Монгол Улс дахь донтох өвчнөөр өвчлөгчдөд хамаарах эрх зүйн зохицуулалт, нөхцөл байдал. УБ. 2013.

Монголчуудын талаар тодорхой дурдсан боловч Монгол хүн хар тамхи тариалсан, зарж борлуулсан, хар тамхи хэрэглэж байсантай таарч байгаагүй талаараа тэмдэглэн үлдээжээ.

Германы эрдэмтэн, доктор Аль Ивановскийн 1890-д оны орчимд Монгол орноор аялаад Германы Лейпциг хотноо хэвлүүлсэн “Монгол улс, угсаатны зүйн зураглал”¹¹ номдоо “гаансаар тамхи татах нь Монгол орон даяар түгээмэл бөгөөд харин хар тамхины хэрэглээ цаашид нэлээн тархах шинжтэй байна. Зажилдаг тамхийг голдуу эмэгтэйчүүд хэрэглэдэг гэхдээ энэ зуршил нэг их тархаагүй” гэжээ.

Судлахад Н.Я.Бичурин /гэлэн Иакинф/ Санктпетербург хотын Карл Кайны хэвлэлийн газарт 1828 онд хэвлүүлсэн “Монголын тухай тэмдэглэл” номдоо Монголчуудыг “бие биедээ нөхөрсгөөр ханддаг, найрсаг, даарах, норох, өлсөхийг ажирдаггүй, бүдүүлэг, догшин авиргүй, таргаа исгэж архи хийдэг, сониуч, зальжин, хөгшдөө хүндэлдэг, хятдуудаас болгоомжилдог” гэсэн бол Н.М.Пржевальский Санктпетербург хотод 1875 онд хэвлүүлсэн “Монгол орон ба Тангудын газар нутаг” номдоо “Монголчууд бие эрүүл чийрэг, явган явах дургүй, Монгол эрэгтэй хамрын тамхи бүхий хөөрөг өвөртлөн явдаг, зуны улиралд айраг их ууна, махыг, ялангуяа хонины махыг хамгийн сайн мах гэж үзэж хэмжээлшгүй ихээр иднэ, мал сүрэг нь аятай, тарган байвал өөр юу ч хэрэггүй, хэрээс хэтэрсэн сониуч зантай, угаас хятадуудад дургүй, эхнэр, нөхөр бараг тэгш эрхтэй” гэсэн байна.

Ахмад түүхч Г.Навааннамжилын дурдсанчлан, Чин улсын Бүрэн засагч (1861-1875), Бадаргуулт төр (1875-1908)-ийн үеэс Монгол газар нүүдлийн хятад тариачид ирэх нь нэмэгдэж, “Манжийн улс төрийн эрх буурч хятадууд эзэрхэж, нүүдэлчин, тариачин хятадаар Монгол орныг дүүргэж, газрыг эзлүүлэхээр өдий төдий иргэдийг шурган оруулж, атрыг хагалбарлуулан, бэлчээрийг хомстгох явдал сар, жилээр гүнзгийрч ирсэн байна”¹²

Манжийн чин улсын дотоод хямрал, гадаад дарамт шахалт нэмэгдэхийн хэрээр Монгол дахь хятадын нөлөө ихсэж, “шинэчлэлийн бодлого” нэрийн дор Монгол улс руу чиглэсэн хятад иргэдийн урсгал хяналтгүй болж, газар тариалан эрхлэх, алт ухах, ан гөрөө хийх нь нэн их, дур зоргоороо болж, Монгол хятад хүмүүсийн харилцаа өргөжиж, хар тамхины төрлийн ургамал тариалж, хэрэглэх болсон талаар Ж.Баатар “Ил ба далд түрэмгийлэл”¹³ номдоо тодорхой дурдсан байна.

Монголчууд монгол хятадаар хольж ярих, хятад хувцас өмсөх, эмэгтэйчүүд хятад хүнтэй гэрлэх, хятадын бараа, таваарт дасаж, дууч эмс, ший янгууны газар Монгол эмэгтэйчүүд ажиллаж, Нийслэл хүрээнд 70 гаруй мянга, Хиагтад 3 мянга, Улиастай, Ховдод тус бүр 2.5 мянга хятад иргэд оршин сууж суурин газар амьдарч байгаа хүн амын 65 хувийг эзлэх болсон талаар Майский¹⁴ тэмдэглэсэн байдаг.

“Шинэчлэлийн бодлого”-ыг үе шаттайгаар хэрэгжүүлснээр Монголчуудын амьдралын хэв маягт өөрчлөлт орж суурин амьдралын сөрөг тал болсон архидан согтуурах, мансуурах, мал дамлан зарах, мөрийтэй тоглох, гал түймрийн зэрэг гэмт хэрэг бүртгэгдэж эхэлсэн байна.

1915 оны Хиагтын “Гурван улсын гэрээ”¹⁵ нь Монгол нутгийг зорих хятад иргэдийн тоо дахин өсөн нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын тэмцэл хөдөлгөөнөөс дүрвэн зугтсан 13000 шахам хятад худалдаачид, тариачид, энгийн

¹¹ Аль Ивановский. Монгол улс, угсаатны зүйн зураглал. Герман улс. 1892

¹² Галсангийн Навааннамжилын бүтээлийн дээжис. Эрхэлсэн Чулуун Ч.УБ. 2011. 118 дахь тал.

¹³ Баатар Ж. Ил ба далд түрэмгийлэл. УБ. 2021.

¹⁴ Майский И.М. “Современная Монголия” Эрхүү. 1921. /орчуулгын бүтээл/

¹⁵ Энэ гэрээгээр Монгол Хятадын эзэн эрхийн дор орших автономит улс байхаар тогтжээ

иргэд эргэн ирж урьдын ажлаа сэргээн үргэлжлүүлэх болсон нь арилжаа, худалдааны хувьд төдийгүй Монгол дахь хятадын газар тариалангийн сэргэлтэд нөлөөлжээ.

Монгол, хятад ураглан суухыг хориглоод зогсохгүй нэгэнт орж ирээд суурьшсан хятадуудаас хууль журамд нийцүүлэн хөөж гаргах арга хэмжээ шат дараатай авч байжээ. Тухайлбал, 1913 оны хавар Нийслэл Хүрээний баруун дамнуурчинд оршин сууж байсан цагаач хятадуудыг хөөн зайлуулах арга хэмжээг Дотоод яамнаас зохион байгуулахдаа Түшээт хан, Сайн ноён хан аймгуудын чуулган дарга, Эрдэнэшанзавын яамтай хамтарсан шалгалтаар 2600 хятадыг тус улсаас хөөн буцаажээ. 1916 онд дээрх шийдвэрийг үндэслэн Хүрээний таван хэсэг газар монголчуудтай холилдон сууж байсан 99 тооны иргэдийн орон байр, хашааг эвдлэн, тэднийг хөөж, тусгай газарт суурьшуулсан баримт байна.

Судлаачийн хувьд дэлхий ертөнцөд өрнөж байсан тухайн үеийн үйл явдлуудын цар хүрээнээс шалтгаалан Монгол Улсад нөлөөлж байсан нөлөөллийг харгалзан доорх цаг хугацааны үечлэл гаргаж болох байна

1838 он хүртэл хугацаанд: Түүхийн эх сурвалж, археологийн олдвор, эд өлгийн зүйл, уламжлал, үлгэр домогт хар тамхи, мансуурах, мансуурч байсан талаар тодорхой мэдээлэл одоогийн байдлаар байхгүй. Гэвч энэ нь мансуурч байгаагүй, энэ төрлийн ургамал, бэлдмэлийг мэддэггүй байсан гэж үзэж болохгүй. Миний таамаглаж байгаагаар ардын уламжлалт эмчилгээнд ургамлын тайвшруулах шинж чанарыг эртнээс таньж, ашиглаж байсныг үгүйсгэх аргагүй. Гэвч цаг хугацааг тодорхойлох боломжгүй байна.

Бидэнд одоогийн байдлаар мэдэгдэж байгаа Эртний Хятадын Хань¹⁶ улсын түшмэл Сыма Цянийн бичсэн "Ши цзи" /Түүхэн тэмдэглэл/-д¹⁷ дурдагдсан Хүннү гүрний хуулиас эхлэн олон хууль, цааз, цаазын бичиг гарч үйлчилж байжээ.

Дээрх хууль, цаазын бичгүүдэд Монголчуудын ахуй амьдрал, аж байдлын холбогдолтойгоос гадна тооллогоор хүний тоо дарагдуулах, хувиараа ламд шавь орох, цэргийн албан хаагч хувиараа сахил хүртэх, удаан хугацаагаар холдсон төрөл садан урагтаа буцаж орохыг үл зөвшөөрөх, цэрэг хөдөлгөхгүй байх, хориглосон бараагаар наймаа хийх /булга, хүн орхоодой гэх мэт/, зөвшөөрөлгүй зэвсэг авах, нутаг, хил зөвшөөрөлгүй давах, хил давж гадаад улс руу оргох, галзуурсан хүнийг харгалзах, түймэр тавих, булш ухах, гадуур явалдах, мал харваж алах, лам, шавь нар хийдээс дур мэдэн гарах зэрэг гэмт хэрэг бүртгэгдэж, шийтгэгдэж байсан талаар архивд хадгалагдан үлджээ.

Төв Азийн өндөрлөгт суурьшсан Монголчуудын өвөг дээдэс МЭӨ 2600 орчим жилийн тэртээгээс Ся улсын¹⁸ “Шар эзэн хаан”-тай тэмцэлдсэн Хуньюй¹⁹ аймгаас анхлан түүхийн тавцанд гарч, Хятадын анхны түүхэн угсаа болох Шань-Ин²⁰ улсын түүхэн эх сурвалжид тэмдэглэгдэн үлдсэн цаг хугацаанаас эхлэн төр, улсаа байгуулан харьяат ардаа засаглаж байснаас 1831 /Төр гэрэлтийн 10-р/ он хүртэл хугацааны хууль цаазыг бичиг, эх сурвалжийг судалдаг эрдэмтэн, судлаачдын бүтээлд Монголчуудын хар тамхины тариалалт, боловсруулалт, хэрэглээ, худалдааны талаар тодорхой мэдээ, сэлт байхгүй.

Монгол Улсад анх хар тамхи болон мансууруулах бодис хэрэглэх, борлуулах явдлыг хориглосон хууль цаазын бичиг, ял, шийтгэл оногдуулсан түүхийн эх сурвалжийг доктор, профессор Л.Эрдэнэбаяр, Мансуурлын эсрэг үндэсний төвийн тэргүүн Л.Азбаяр, доктор,

¹⁶ Хань улс (хятадаар: 朝; МЭӨ 202 - МЭ 220) бол Хятадад оршин тогтнож байсан улс юм.

¹⁷ <https://mn.wikipedia.org/wiki/Модунь-Шаньюй>. 2022.09.14

¹⁸ МЭӨ 2070-1675 оны хооронд Хатан голын сав газар оршин тогтнож байсан Хятадын анхны төрт улс юм.

¹⁹ (хят. 匈奴, *Xiōngnú*) нь НТӨ 209 – НТ 93 онд оршиж байсан монголын газар нутагт оршиж байсан нүүдэлчдийн холбоот улс юм.

²⁰ Шан улс нь МЭӨ 1600-1046 оны орчимд оршин тогтнож байсан эртний Хятадын төрт улс юм.

профессор Ж.Болдбаатар, Б.Болдбаатар нарын судалгаа, эрдэм шинжилгээний материал, гарын авлага, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Цагдаагийн ерөнхий газар зэрэг чиг үүргийн байгууллагуудаас санаачлан зохион байгуулсан хэлэлцүүлэг, хуралд тавигдсан илтгэл, өгүүллэгүүдээс судлахад Төр гэрэлтийн 10-р²¹ /1831/ онд тухайн үед “Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын яам²²”-ны /Манж чин улсын төр засаг/ сан хөмрөгийн баримтад дурдагдсан “цавчих, хөвчдөн алах, цөлөх ялыг зэрэг бууруулах дураар зоос цутгахыг цаазлах, хар тамхи худалдсан хүмүүсийг яллах тухай хуульчилсан шийдвэрийг зарласан бичиг захидлын дагаврууд”-д²³ тэмдэглэсэн байна.

1838-1910 онуудад: Хятад иргэд өөрсдөө тариалж, өөрсдөө хэрэглэж байсан. Гэвч тухайн үеийн ихэс, дээдсийн санааг зовинуулах, хууль цаазаар хориглох хэмжээнд хүртлээ нөхцөл байдал муудаагүй байсан. Дээрх хугацаанд Монгол нутгаар хятад иргэд онцгой хяналттай, богино хугацаагаар, тодорхой маршрутаар зорчдог байсан тул хар тамхины хэрэглээ Монголчуудад байхгүй байжээ. Хар тамхи гэх зүйлийг Монголчууд хятадуудаар дамжуулан мэддэг байсан.

Харин Бадаргуулт төрийн 33-р²⁴ /1907/ оны орчимд албат Чанбай Хэшэри Ижэнь нь зарлигаар Илийн хил хязгаарыг²⁵ байцаан шийтгэж, Монгол журганаас²⁶ Монголын тухайд хэрэгжүүлсэн арван дөрвөн зүйлийн хяналт шалгалтыг гүйцэтгэх явцдаа Тэкэс гол²⁷ орчимд нутаглаж байсан Уйгар айл жижиглэн худалдаа эрхлэхийн зэрэгцээ хар тамхи зарж байсан²⁸ талаар аяллын тэмдэглэлдээ бичсэн байна.

Бадаргуулт төрийн 4-р (1879) оны 10 сарын 23-нд Хан уулын чуулган даргын тамгыг хамаарсан дэд чуулганы дарга Халхын Очирбат Түшээт хан Насанцогтын өргөсөн бичигт, *“Ивэн, Бургалтайн зэрэг газар иргэд дураар Монгол засаг хошууны нутаг газрыг эзэлж, газар хагалж...тариа, хар тамхи тарьж, Монгол эмс охидтой хольцолдон зууралдаж суусан нь даанч зүрх их, цаазалсныг зөрчин явжээ...”*²⁹

1911-1923 онуудад: Хятадууд тариалж, мөн гаднаас оруулж ирж Монголчуудад хэрэглүүлэх болсон. Манжийн төр дэх хятадуудын оролцоо нэмэгдсэн, Монголд хандах хятадын хандлага өөрчлөгдсөнтэй холбогдуулан Монголчуудад гаднын соёлын болон эдийн засгийн нөлөөлөл их болсон. Хятад дахь хар тамхины хэрэглээний тэлэлт нөлөөлсөн.

Мансууруулах үйлчилгээтэй ургамал, намуу цэцгийг зориуд тариалан боловсруулж хэрэглэж байсан.

Мөн Эхийн гол буюу Баянхонгор аймгийн Шинэ Жинст сумын нутагт орших Эхийн голын баян бүрдэд хятадууд намуу цэцгийг тариалан түүнээс хар тамхи гарган авч байсан тухай түүх байдаг³⁰.

²¹ Төр гэрэлт (1782–1850; 68 насалсан) – 1820–1850 онд төр барьсан Чин улсын наймдугаар хаан, манж хүн байв.

²² 1765 онд Харчины ноён Хутурингаа Халхын Хүрээнд томилогдож ирж, Түшээт хан аймгийн туслагч жанжин Санжайдоржийн гарт төвлөрөөд байсан эрх мэдлийг “Зарлигаар зарсан Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайд” хэмээх албан тушаалын хувьд шилжүүлж авхад, Манжийн хаан хэрэг шийтгэх “захирлага тамга” олгосноор Хүрээний сайдын газар байгуулагджээ.

²³ Хар тамхитай тэмцэх газрын архив ХНЗ.1987-2011 оны хууль эрх зүйн акт. УБ. 2013. 1 дэх тал

²⁴ Бадаргуулт төр (1871–1908; 37 насалсан) – 1875–1908 онд өргөмжлөгдсөн манж Чин улсын арван нэгдүгээр хаан байв.

²⁵ Шинжаан (албан ёсоор *Шинжаан Уйгурын өөртөө засах бүс нутаг*)

²⁶ Хязгаар мужийг захирах ерөнхий газар

²⁷ Текес (Хятадаар: 特克斯河 - Текэсыхэ) нь Казахстан (дээд талын) болон Шинжаан-Уйгурын өөртөө засах орны (БНХАУ) (урсгалын доод талын) гол юм.

²⁸ Монгол нутгаар зорчсон тэмдэглэл /1688-1911/. Орчуулсан Гэрлээ Б. УБ. 2021. 215 дахь тал.

²⁹ МУУТА, X-M1, ХН-1, Б-5726, нуг-4

³⁰ <https://mn.wikipedia.org/wiki/> намуу цэцэг. 2022.09.27

Монгол Улс 1911 онд тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан /Монголын төр засаг/-ны дараа хар тамхины аюулыг таслан зогсоох талаар арга хэмжээ авч эхэлсний илрэл нь 1912 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Богд хаанаас гаргасан зарлиг юм.

Үүнд “...Хар тамхи хэмээгч бодис хамаг хорттой бузар юм мөн хэмээх тул үүнээс урагш манай монгол нутагт тэрхүү хар тамхи хэмээгчийг элдэв хүн татаж хэрэглэх ба худалдааны нүүс, дотор газраас худалдан өгөх, манай улсад тарианд тарих явдлыг нэгэн адил чангалан цаазалсугай. Хэрэв зөрчих аваас монгол хүн бол хүнд цээрийг үзүүлэн шийтгэж, иргэн хүн болбоос худалдааны албан газар хураан авч, түлж сүйтгээд уг иргэнийг шууд үлдэн хөөж дахин монгол газар ирж худалдаа хийхгүй болгосугай ...” гэж дурджээ.

Олноо өргөгдсөний 6 дугаар /1916/ оны 12 дугаар сарын 30-нд Богд хааны зарлигаар “Нийслэл хүрээний тойрон газруудыг цагдан сэргийлэх дүрэм хэмжээ тогтоохуй нь”-ын арван хоёрдугаар зүйлд “Цагдан сэргийлэгчид нийслэл хүрээний газар аливаа хүн буудаллан цуглах ба будаа идэх, цай уух зэрэг олон хөлийн газруудыг цагдан харгалзаж, тогтоосон дүрмийн ёсоор дагаж явахыг хичээмүй. Хэрэв тэдний цуглагчид дотор зөрчилдөх, хэрэлдэн шуугилдах ба мөрийцөн наадах, архи уух, хар тамхи татах, мөн дэмий ёс бусчлан үг хэлэлцэх зэрэг муу самуун, гэм гаргах дор хүрэх аваас ятган ухуулж, дарангуйлан зогсоосугай.

Хэрэв дагахгүй зөрчвөөс харьяат албаны газар хүргүүлж уламжлан учрыг гаргаж дээд яамнаа мэдүүлж залхаан шийтгүүлбээс зохимуй”³¹ гэжээ.

Үүнээс үзэхэд 1916 оны 12 дугаар сарын 30-нд Шүүн таслан хэргийг бүгд захиран шийтгэх яамнаас Богд эзэн гэгээнд айлтгаж, толилуулсан дагуу Нийслэл хүрээнд цагдан сэргийлэх албаны газар байгуулж, харьяалах газар нутгийг хуваарилан, гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлж, хүний нөөцийн тоо, зэрэг дэвийг тогтоон, албаны хувцас өмсөх, зэвсэг хэрэглэх эрхийг олгосон байна. Энэ цаг хугацаанаас эхлэн Монгол төрийн цагдаагийн байгууллага Хар тамхитай тэмцэх үүргийг хүлээх болсон байна.

Энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдал хүндэрч, ялангуяа Монгол Улсад амьдарч байсан Гуулин улсын /Солонгос/ 5 иргэн Алтанбулаг орчим хар тамхи тариалж байсныг илрүүлсэн, 1914 онд хятадын иргэн Цеу Там, Мие Баочан нар нийт 532 гаруй жин /315 орчим кг/ хар тамхи хоёр тэмээнд ачиж тээж ирсэн гэх зэргээр олноо өргөгдсөн Монгол Улсын үед буюу 1911-1924 онд холбогдох хар тамхитай холбогдох 50 гаруй баримт манай архивын сан хөмрөгт хадгалагдаж байна.

Хууль журмыг сахин хэрэгжүүлэх үүргийг тухайн үеийн Богдын Засгийн Газрын тагнуул, дотоод аюулгүй байдал хариуцсан байгууллагууд болох Дотоод яамны “Нийслэл Хүрээ, Маймаа хотын иргэдийн хэргийг хамааран шийтгэх түшмэл”-ийн газар болон Цэргийн яамны харьяа Цагдан сэргийлэх газар³² хүлээж, 1921 оны зургаадугаар сарын 21-нд “Хар тамхийг цаазалсан тухай бичиг”-т “Монгол хүн хар тамхи худалдан авах буюу татахыг цаазлан зогсоох бөгөөд гадаадын хүн хязгаарт тээн оруулж ирвэл худалдаалахгүй болгон шийтгэсүгэй” гэжээ. Энэ тухай зарлан ухуулах, ард иргэдэд мэдүүлэхийн тулд ухуулах хуудсыг Хүрээ, Маймаа хотуудад наахыг даалгах зэргээр хар тамхитай тэмцсээр ирсэн түүхтэй.³³

³¹ Хүрэлбаатар Т, Чулуунбат Д нар. Монголын цагдаагийн байгууллагын түүхийн зарим баримт бичгүүд. УБ. 2011. 6, 11 дэх тал.

³² 1917 оны 02 дугаар сарын 20-нд Богд хааны зарлигаар байгуулагдав.

³³ МУУТА, Х-М1, ХН-1, А-8-1-382.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын ивээл дор 2019 онд зохион байгуулсан “Богд хаан-150 Түүх, өв соёл” олон улсын эрдэм шинжилгээний хуралд Монгол Улсын Боловсролын их сургуулийн Түүхийн тэнхим, доктор (Ph.D), профессор Ц.Гантулга “Богд хаант Монгол Улсын Засгийн газар хар тамхины эсрэг тэмцсэн нь”³⁴ сэдэвт илтгэлдээ Богд хаант /Олноо өргөгдсөний/ Монгол Улсын засгийн газраас энэ талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар маш тодорхой дурдсан байна.

Монголчууд өөрийн төр улсыг сэргээн байгуулж, урьд цагийн хар сүүдэр болсон хар тамхины хороос иргэдээ хамгаалсан, тэмцсэн талаар маш дэлгэрэнгүй, тодорхой эх сурвалжтай дурдсан энэ илтгэл судлаач миний хувьд “алт”-аар үнэлэгдэх бүтээл билээ.

1923-1962 онуудад: Хэдийгээр гадаадын худалдаа, хятад иргэдийг Монгол нутгаас гаргасан, хэрэгцээт барааг зөвхөн Зөвлөлт Орос Улс /тухайн үеийн/-аас нийлүүлж бусад улс орнуудын хувьд “хаалттай” болсон боловч 1911-1923 онуудад явуулсан бодлогын хор уршгаар Монгол улсад мансуурагч, зарим нэг донтогч бий болсон байна. Мансуурах зуршлыг Монголчууд хадгалан үлдсэн.

Мансууруулах үйлчилгээтэй ургамал, намуу цэцгийг зориуд тариалан боловсруулж хэрэглэж байснаас гадна мэдээ алдуулах үйлчилгээтэй эм тариа хэрэглээ цагдаагийн байгууллагад бүртгэгджээ.

Энэ хугацаанд хар тамхитай тэмцэх ажил сул, нэгдсэн бодлогогүй байснаас шалтгаалан “хэрэглэгч” бий болсон.

1963-1990 онуудад: Сургуулийн сурагч, ТМС-д суралцагчдын дунд гутлын цавуу үнэрлэн мансуурах явдал цөөн тоотойгоор бүртгэгдэж, насанд хүрээгүй хүмүүсээс энэ төрлийн өвчнөөс буюу хорын донгоос шалтгаалсан нас баралт 1988 онд анх бүртгэгдэж эхэлсэн. Гадаадын /СЭВ-ийн орнууд/ иргэдээр дамжуулан Монгол нутагт ургадаг мансууруулах төрлийн ургамлыг таньж, боловсруулж, хэрэглэж сурсан.

Мөн сурагчдын дотор “Омог бүлэг”, “Тусгай нөхөд”, “Отрядынхан”, “Улаан хамгаалагч”, “Квантуны арми”, Холимог бүлэг”, Дүүжлүүр” зэрэг нэртэй бүлэг бөөгнөрөл буй болж, гэмт хэрэг, зөрчил үйлдэх нь ихэссэн байна.

1991-2010 онуудад: Гадаад худалдааг иргэд явуулах /ганзагын наймаа/ болсноос шалтгаалж гадаад орны бүлэглэлд элсэж, НҮБ-аас жил бүр гаргадаг 2010 оны илтгэлд Монгол Улс дамжин өнгөрүүлэгч орон гэж тэмдэглэгдсэн, Эм тарианд донтогчид бий болсон. 1992 онд шинээр бүртгэгдсэн гэмт хэрэгт холбогдож болзошгүй 1734 хүүхдийн дотор мансуурах сонирхолтой 78 хүүхэд бүртгэгдэж³⁵ байжээ. Энэ хугацаанд “тэнэмэл” гэх хүүхдүүд бий болж, тэдэнд тавих хяналт суларсан. 1991-1992 онуудад Улаанбаатар хотод 2, Дорноговь аймгийн Хөвсгөл суманд 1, гадаадын 1 иргэн морфин, промедол эмийг тариагаар худалдан авч өөртөө тарьсан үйлдэлдээ эрүүгийн хариуцлагад татагдан ял эдэлж байсан.

Тус улсын хувьд хар тамхи хэрэглэдэг хүмүүсийн бүртгэлийг гарган, хяналт тавьж эхэлж байгаа бөгөөд Олон улсын цагдаагийн байгууллага “Интерпол”-ын хурлын мэдээнд манай улс Ази, Европ тивийг холбосон хар тамхи дамжин өнгөрөх нэг гол зам болон сонирхогдож байна гэжээ³⁶.

Иргэдийн дунд мэдээ алдуулагч эм тариа, гутлын цавуу /уколёт/ будаг шингэлэгч, мансууруулах төрлийн ургамлыг хэрэглэж эхэлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан удирдамж төлөвлөгөөний дагуу 2001 онд “Мансуурал” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулан хар тамхи мансууруулах бодис

³⁴ Гантулга Ц. “Богд хаант Монгол Улсын Засгийн газар хар тамхины эсрэг тэмцсэн нь. Уб. 2019.

³⁵ Пүрэв Б. Монгол Улсын Засгийн газрын дэргэдэх цагдаагийн байгууллага. Товч түүх. Уб. 2016. 174 дэх тал.

³⁶ Хар тамхитай тэмцэх газрын архив ХНЗ.1987-2011 оны хууль эрх зүйн акт. Уб. 2013. 125-127 дахь тал

хэрэглэдэг 136, хэрэглэдэг байж болзошгүй 40 хүнийг бүртгэлд авч, 14472 ампул морфин, фентазоцин зэрэг эм тариаг устгасан байна.

Монгол Улсын Байгаль орчны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 1995 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 139/А/148 дугаар “Жагсаалт батлах тухай /Монгол оронд ургадаг мансууруулах бодис бүхий ургамлын жагсаалт/ тушаалын хавсралтад заасан Мансуурагч намуу /*Paraver somni ferum*/ Газрын дундад тэнгисээс гаралтай, Таримал олс /*Connabis sativa*/ Энэтхэгээс гаралтай, Хогийн олс /*Cannabis ruderalis*/³⁷-нь зөвхөн үрээр үржиж, атаршсан талбай даган ургадаг бөгөөд Монгол Улсад газар тариалан эрхэлж байсан хятад голдуу иргэд үрээр тариалсан нь салхиар тоос хүртээдгээс шалтгаалан тариалангийн бүс нутагт тархан ургасан, завсрын унаган ургамал ангилалд багтаж байна.³⁸

Ургамалын тархац-нөөцийн судалгаанаас харахад экосистемийн цөлжилт, талхагдлын явц идэвхжиж байгаа өнөө үед хуурай, гандуу нөхцөлд сайн ургадаг *Cannabis*-олс төрлийн ургамлууд өөрийн тархцаа тэлж, талхлагдсан экосистемд зонхилох байр суурь эзлэх болсон байна.

2011-2016 онуудад: Хэрэглэгч, донтогчид бүх төрлийн хар тамхи, мансууруулах бодис хэрэглэж эхэлсэн, хар тамхитай тэмцэх цагдаагийн байгууллагын нэгж байгуулагдсан, зохион байгуулалттайгаар, тодорхой бодлогоор энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж эхэлсэн. Монгол улсын иргэд зохион байгуулалттай гэмт хэрэгт хамтран оролцож олон улсад бүртгэгдэж байсан бүхий л аргаар хар тамхийг зөөвөрлөх болсон. Химийн гаралтай буюу нийлэгжүүлсэн бодис, мансууруулагч, сэргээгч, тайвшруулагч, хий зүйл харагдуулах үйлчилгээтэй бодис цагдаагийн байгууллагад хураагдаж эхэлсэн.

2016-с хойш: Энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдал хүндэрсэн, олон улсын тайланд “хэрэглэгч орон” болсон тухай дурдагдсан. Бүх шугамаар хар тамхи нэвтрүүлэх болсон.

Иргэдийн дунд энэ төрлийн эм бодисын хэрэглээ тэлж, гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдийн нас нь залуужиж, хураагдсан бодисын хэмжээ нэмэгдэж, гэмт хэргийн гадаад, дотоод нөхцөл байдал хүндэрч байгаагаас шалтгаалан Цагдаагийн ерөнхий газрын харьяа Хар тамхитай тэмцэх газрыг шинээр байгуулсан.

Гадаадын 8 орноос хар тамхи, мансууруулах бодисыг шуудан илгээмж, ачаа тээвэр, агаарын, төмөр замаар нэвтрүүлж байсантай холбогдуулан энэ төрлийн бодисыг илрүүлэх, тандагч багажийн ашиглалт нэмэгдэж, алба хаагчдын мэдлэг, чадвар дээшилсэн.

Иргэдийн дунд энэ төрлийн эм бодисын хэрэглээ тэлж, гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдийн нас нь залуужиж, хураагдсан бодисын хэмжээ нэмэгдэж, гэмт хэргийн гадаад, дотоод нөхцөл байдал хүндэрч байгаагаас шалтгаалан төр засгийн зүгээс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг нэгжийг байгуулж, хариуцсан нэгжийг тухайн цаг үеийн нөхцөл байдалд тохируулан байнга өргөтгөж, бие даасан байдалтайгаар, бодлого хэрэгжүүлсэн, нэгдмэл байгууллага болгон ажиллуулж байна.

Дүгнэлт.

Нэг. Монголчууд энэ олон жилийн хугацаанд /1981 он хүртэл/ хугацаанд хар тамхи хэрэглэж байгаагүй, хар тамхинд донтож, улс хэмжээнд сэрэмжилбэл зохих аюул болон дэлгэрээгүй вэ?

- Монголчуудад нүүдэлчин амьдралд тохирсон шимийн буюу нэрмэл архи, айргийн хэрэглээ хангалттай байсан, хатуу архины хэрэглээг урд, хойд хөршөөс авчээ.

³⁷ Төрийн мэдээлэл сэтгүүл УБ. 1995. №11.

³⁸ Өлзийхутаг Н. БНМАУ-ын ургамлын аймаг ургамалжилтын судалгаа. Тэргүүн боть. УБ. 1979. 25 дахь тал.

- Нүүдэлчин ахуй хамтын хөдөлмөрт үндэслэдэг учир хувь хүний хүмүүжилд гэр бүлийн гишүүдийн оролцоо өндөр, өв соёлыг хөдөлмөртэй хослуулсан үлдээх хүмүүжлийн өвөрмөгц аргатай байсан,

- Түүхэн үйл явцаас шалтгаалан урд зүгийн орон, ялангуяа Хятадыг аюул гэж үзэж, түүнд уусаж, нэгдэх, нөлөөнд автах аас эмээх нь хар тамхи хэрэглэхгүй байх нөхцөл болсон гэж судлаачийн хувьд дүгнэж байна.

Хоёр. Хятад улстай харьцуулахад хар тамхи Монголчуудын дунд гэнэт бий болж, хэрэглээ нь өнөөдрийн хэмжээнд хүрсэнгүй. Хэрэглээнд аажим нэвтрэх байдлаар хэрэглэгч, мансуурагч, донтогч бий болжээ. Энэ бүгдээс дүгнэлт хийхэд утаат, электрон тамхины хэрэглээнд хязгаарлалт, хяналт тавьж өсвөр үеэ хар тамхины хэрэглээнээс хол байлгаж чадна гэж үзэж байна.

Гурав. Хар тамхитай тэмцэх газрыг байгуулснаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх нь зөвхөн нэг газрын үүрэг мэтээр бусад алба хаагчдад ойлгогдож, энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож байгаа этгээдүүдийн мансууруулах төрлийн ургамлыг таних, түүж боловсруулах, хэрэглэх байдал /мэдлэгийн түвшин/ цагдаагийн алба хаагчдаас илүү байгаа нь хар тамхитай тэмцэх газраас хийсэн судалгаагаар харагдаж байна.

Гэтэл Монгол оронд мансууруулах болон донтуулах үйлчилгээтэй бодис бүхий ургамал болох намуу, зэрлэг олс, зээргэнэ, лантанз зэрэг 9 овог, 11 төрөлд хамаарах 18 зүйл ургамал нь манай улсын 14 аймгийн 49 сумын нутаг дэвсгэрт 15,000 орчим га талбайд ургадаг болох нь судалгаагаар тогтоогджээ.

Зөвхөн 2022 онд Хар тамхитай тэмцэх газраас зохион явуулсан шалгалтаар Тээврийн цагдаагийн албаны 2, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын 2, орон нутаг дахь цагдаагийн газрын 2 алба хаагч энэ төрлийн бодис агуулсан эм бэлдмэлийг өвчний учир /санамсаргүйгээр/ сүүлийн 3 жилийн жилийн хугацаанд тогтмол хэрэглэж байсан нь тогтоогдсон байна.

Дөрөв. Хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх нь Хар тамхитай тэмцэх газрын үндсэн үүрэг боловч ард иргэдтэй хамгийн ойр ажилладаг эргүүлийн офицер, цагдаа, хэсгийн байцаагч зэрэг хэв журмын алба хаагчдыг иргэдэд үнэн зөв мэдээллийг өгөх, гэмт хэрэг, сэжигтэй этгээд, байр байгууламж, ач холбогдолтой мэдээ, мэдээллийн томоохон эх сурвалж гэж үзэж, Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдад хар тамхитай тэмцэх, энэ төрлийн гэмт хэргийг шалгах ажиллагааны арга зүй сэдэвт сургалтыг 2021 онд нийт 45 удаа, 1995 алба хаагчийг оролцуулан зохион байгуулсан.

Гэвч хүний нөөцийн шилжилт, хөдөлгөөнөөс шалтгаалан хэв журмын алба хаагчдын дунд энэ төрлийн гэмт хэргийн ойлголт, мөрдөн шалгах арга ажиллагаа, иргэдэд урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл хүргэх чадваргүй байна гэж үзэж байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хэв журмын алба хаагчдаас энэ төрлийн гэмт хэрэгт өртөж хохирч болзошгүй /зорилтот/ бүлэг рүү чиглэсэн, тэдний нас, сэтгэхүйн онцлогт тохирсон урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээний аргачлал, гарын авлага, сургалтын материал, сургагч багшийг бэлтгэх, ялангуяа түүхэн уламжлалд суурилсан гэр бүлийн хүрээллийн шинэлэг аргыг боловсруулах;

2. Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, машинт болон явган эргүүл, шөнийн эргүүл, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн анги байгууллагын хэв журам хамгаалах нэгжийн алба хаагчдын мэдлэгийг сайжруулах, чадавхыг нэмэгдүүлэх замаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд оролцох оролцоог нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох;

Эх сурвалжийн жагсаалт.

1. Азбаяр Л. Хар тамхи мансууруулах бодисыг зүй бусаар хэрэглэх, хууль бус эргэлттэй тэмцэхтэй холбоотой эрх зүйн асуудлууд. УБ. 2004.
2. Аль Ивановский. Монгол улс, угсаатны зүйн зураглал. Герман улс. 1892.
3. Баатар Ж. Ил ба далд түрэмгийлэл. УБ. 2021.
4. Батсүх З. Эрүүгийн цагдаагийн албаны түүхэн замнал. УБ. 2005.
5. Бичурин Н.Я. “Монголын тухай тэмдэглэл” Санктпетербург. 1828.
6. Болдбаатар Б, Мөнхболд Ж. Мансууруулах, сэтгэгдэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг ажиллагаа. УБ. 2012.
7. Болдбаатар Ж. Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ. УБ. 2004.
8. “Галсангийн Навааннамжилын бүтээлийн дээжис”. Эрхэлсэн Чулуун Ч.УБ. 2011.
9. Гантулга Ц. “Богд хаант Монгол Улсын Засгийн газар хар тамхины эсрэг тэмцсэн нь. УБ. 2019.
10. Гэрэлбадрах Ж. Монголын нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх. /НТӨШ-ХІХ зуун/ УБ. 2006.
11. Майский И.М. “Современная Монголия” Эрхүү. 1921. /орчуулгын бүтээл/
12. Монгол нутгаар зорчсон тэмдэглэл /1688-1911/. Орчуулсан Гэрлээ Б. УБ. 2021.
13. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг /Алсын хараа-2050/-ийн танилцуулга. УБ. 2022.
14. МУУТА, Х-М1, ХН-1, А-8-1-382.
15. МУУТА, Х-М1, ХН-1, Б-5726, нуг-4
16. Өлзийхутаг Н. БНМАУ-ын ургамлын аймаг ургамалжилтын судалгаа. Тэргүүн боть. УБ. 1979.
17. Пржевальский Н.М. Монгол орон ба Тангудын газар нутаг. Санктпетербург. 1875.
18. Пүрэв Б. Монгол Улсын Засгийн газрын дэргэдэх цагдаагийн байгууллага. Товч түүх. УБ. 2016.
19. Пүрэв Т. Монголын уламжлалт анагаах ухаан. УБ. 2001.
20. Төрийн мэдээлэл сэтгүүл УБ. 1995. №11.
21. Хар тамхитай тэмцэх газрын архив ХНЗ.1987-2011 оны хууль эрх зүйн акт. УБ. 2013.
22. Хууль зүйн үндэсний хүрээлэн. Монгол Улс дахь донтох өвчнөөр өвчлөгчдөд хамаарах эрх зүйн зохицуулалт, нөхцөл байдал. УБ. 2013.
23. Хүрэлбаатар Т, Чулуунбат Д. Монголын цагдаагийн байгууллагын түүхийн зарим баримт бичгүүд. УБ. 2011.
24. Эрдэнэбаяр Л. Мансуурах дон судлал. УБ. 2001.2004.
25. Юваль Ной Харари. Sapiens Хүн төрөлхтний товч түүх. УБ. 2017.
26. legalinfo.mn
27. mongoltoli.mn
28. wikipedia.org

**МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭЖ БУЙ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДЛЫГ ШИНЖИХ НЬ**
AN ANALYSIS OF THE CURRENT STATE OF ACTIVITIES
TO FIGHT CATTLE THEFT

Ш.Ержан

ДХИС-ийн магистрант,

цагдаагийн хошууч

Sh. Erjan

Graduate student,

University of Law Enforcement,

Police major

Хураангуй. Цар тахалтай холбоотой хорио цээр тогтоосны улмаас Монгол Улсын эдийн засагт тэр хэмжээгээр нөлөөлж, олон аж ахуйн нэгж, байгууллага, компаниуд үйл ажиллагаагаа зогсоосон нь ажилгүйдэл тэр хэмжээгээр өсөхөд нөлөөлсөн байдаг. Үүнтэй холбоотойгоор ажилгүйдэл, ядуурал нэмэгдсэн нь мал хулгайлах гэмт хэрэг гарахад нөлөөлөх нэг сөрөг нэг хүчин зүйл болсон гэж би үздэг.

Энэхүү өгүүлэлд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэж буй үйл ажиллагааны өнөөгийн байдал, ашиглаж буй арга хэлбэр, эрх зүйн зохицуулалт болон үр нөлөөг дээшлүүлэх зарим арга замын талаар бичсэн болно.

Summary. Due to the quarantine imposed due to the pandemic, the economy of Mongolia has been affected to such an extent that many enterprises, organizations and companies have stopped their activities, which has contributed to the increase in unemployment. In this regard, I believe that the increase in unemployment and poverty has become one of the negative factors affecting the occurrence of livestock theft.

This article describes the current state of operations of the regional police organization in combating livestock theft, the methods used, legal regulations, and some ways to improve effectiveness.

Түлхүүр үг. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, мал хулгайлах гэмт хэрэг, нутгийн захиргааны байгууллага, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, хяналтын пост

Key word. Territorial police organization, livestock theft, local administrative organization, territorial police organization, control post

Удиртгал. Хүний нийгэм анх бий болсон түүхэн тэр цаг үеэс нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт явдал нэгэн зэрэг үүссэн гэж эрдэмтэн судлаачид үздэг. ОХУ-ын эрдэмтэн, доктор Н.Ф.Кузнецова “Гэмт явдал гэдэг нь түүхэн явцад өөрчлөгдөж байдаг эрүүгийн эрхийн шинж чанартай нийгмийн үзэгдэл бөгөөд тодорхой цаг үеийн дотор тухайн улсад гарч байгаа харьцангуй олон гэмт хэргүүдийн нийлбэр цогцос юм”³⁹ хэмээн тодорхойлсон байдаг.

³⁹ Н.Ф.Кузнецова. Претупление и преступность. М. 1992. Стр 175

Гэмт явдал нь тодорхой шалтгаанаар нөхцөлдсөн эдийн засаг, улс төр, үзэл суртал, нийгмийн сэтгэл зүй, удирдлага, зохион багуулалт зэрэг бусад нийгмийн үзэгдлүүдтэй харилцан холбоотой зүй тогтолт үзэгдэл юм.⁴⁰

Улс орны хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн дэг журам хангах ажлын хүрээнд тулгамдаж байгаа олон асуудлын нэг нь мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх явдал юм.

Монгол түмэн эцэг өвгөдөөс өвлөн ирсэн эрдэнэт мал сүргээ үеийн үед өсгөн үржүүлж, хайрлан хамгаалсаар ирсэн түүхэн баялаг уламжлалтай билээ. Тиймээс ч Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна”⁴¹ гэж онцлон заасан.

Тиймээс мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр дүнтэй арга зүйг боловсруулж нэвтрүүлэх, түүнд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг нь шийдвэрлэж өгсөнөөр гэмт хэрэг буурах боломжтой гэж үзэж байна.

Оршил хэсэг. Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан бусдын өмчлөх эрхэнд нууц, далд аргаар халддаг хулгайлах гэмт хэрэг нь халдлагын зүйлээрээ өөр өөр төрөлд хуваагддаг бөгөөд эдгээрийн дотроос нүүдэлчний удамт соёл иргэншилтэй байсан манай орны хувьд түгээмэл үйлдэгддэг нь мал хулгайлах гэмт хэрэг юм.

Манай улсын түүхийн аль ч үе шатанд мал хулгайлах явдлыг гэмт хэрэгт тооцон оноох ял шийтгэлийг хуульчилж байсан нь, гэмт этгээдээс энэ төрлийн гэмт хэргийг үйлдэх явдлыг таслан зогсоох, цээрлүүлэх улмаар ард иргэдийг малаа хулгайд алдахаас урьдчилан сэргийлсэн арга хэмжээ болж байсан байна. Тухайлбал:

Хүннү улсын үед бусдын эд хөрөнгийг хулгайлбал хулгайчийн гэр орныг хурааж, хөнгөн хэрэгтнийг бэрээдэх, хүндийг цаазаар авч байжээ Түрэгийн хуулиар бослого тэмцэл гаргагсад, төрд тэрслэгчид чөдөртэй мориноос өөр зүйл хулгайлбал түүний өртгийг 10 нуглан төлүүлдэг байжээ.

Киданы үеийн хуульд хэн нэг өөр хүний эзэмшил газар дээр илэрхий дээрэм үйлдвэл түүнд үг дуугуй албал зохино гэсэн хатуу ял зааж байсан. Мөн хулгай хийвэл толгойг нь авдаг хэрэв хулгайч эцэгтэй байвал гавлыг үхэн үхтэл нь хүзүүнд нь зүүдэг байжээ.

Их Монгол Улсын үед үйлчилж байсан “Их засаг” хуулинд эд хөрөнгө, адуу мал хулгайлах явдлыг жигшин үзэж, хатуу шийтгэлийг хэрэг үйлдсэн хүн төдийгүй гэр бүлийн гишүүдэд, боолын эздэд давхар оноож байсан нь хамтын хариуцлагыг дээшлүүлэх, хулгайчийг нийтээр жигшүүлэх түүнчлэн урьдчилан сэргийлэх ач холбогдолыг агуулж байжээ.

Монгол оронд 1921 онд ялсан ардын хувьсгалын жилүүдэд хэдийгээр өмчийн хэлбэр янз бүрээр өөрчлөгдөж байсан ч мал сүргийг гэмт халдалгаас хамгаалах тууштай дэс дараалалтай бодлого боловсронгуй болж, мал хулгайлах, ашиглан шамшигдуулах гэмт хэргийн субъектэд оногдуулах ял шийтгэл хатуу чанд байсныг зөвхөн нэг хуулиар жишээ болгон тодорхойлж болох юм.

Мал хулгайлах гэмт хэргийн нийгмийн хор аюул жил өнгөрөх тусам өсөн нэмэгдэж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны ажлын арга хэлбэрийг өөрчлөхийг зүй ёсоор шаардаж байна.

“Монгол Улсад гарч байгаа малын хулгайн гэмт хэргийг бүрэн дүүрэн, шуурхай илрүүлэх явдал нь малын хулгайн гэмт хэрэгтэй хийх тэмцлийг хүчтэй болгож урьдчилан

⁴⁰ Батжав Л. Гэмт явдал, түүний шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх асуудал. УБ.2002. 23 дахь тал

⁴¹ Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль

сэргийлэх замаар хэргийн гаралтыг багасгахад гол арга нь байх ёстой”⁴² хэдий ч уг хэргийг бүрэн дүүрэн шуурхай илрүүлж урьдчилан сэргийлэхэд “Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгдэн гарч буй аргыг бүхий л талаар судлаж тогтоох нь хулгайн энэ хэлбэрээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэхэд чухал ач холбогдолтой”⁴³ болох юм.

Гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, шалгаж шийдвэрлэх, урьдчилан сэргийлэхэд тухайн гэмт хэрэг үйлдэгдэн гарч буй аргыг судлаж мэдэх, энэ талын мэдлэгтэй байх нь онолын болон практикын чухал ач холбогдолтой байдаг.

Монгол улсын 1992 оны шинэ Үндсэн хуульд Эрүүгийн хуулийг нийцүүлэх зорилгоор 1993 оны 06-р сарын 07-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тухайлбал: 123-р зүйлд “Бусдын эд хөрөнгийг хулгайлж ашиглан шамшигдуулах гэмт хэргийг өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр тодорхойлон авч онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн тохиолдолд зохион байгуулалттай бүлэг этгээд, онц аюултай гэмт этгээд эсвэл их хэмжээтэй хулгайлсныг хамруулах”-аар заасан байдаг

Түүнчлэн алдуул малтай холбоотой эрх зүйн маргаан их явагдсаар ирсэн байдаг. Иргэд алдуул малтай хэрхэн харьцах талаар Иргэний хуулийн 117 дугаар зүйлд: “Алдуул мал олсон этгээд нь энэ тухай орон нутгийн захиргааны буюу цагдаагийн байгууллагад мэдэгдэж малын эзнийг тогтоох хүртэл өөрийн эзэмшилд байлган маллах буюу орон нутгийн захиргааны буюу цагдаагийн байгууллагад шилжүүлэх үүрэгтэй.”⁴⁴ гэж заажээ.

Иргэдийн эзэмшилд маллагдаж байгаа тэрхүү алдуул малыг үнэхээр алдуул мал юм уу, эсхүл хулгайлж авчирчихаад алдуул мал хэлбэрээр адгуулж, маллаж байна уу гэдгийг нутгийн захиргааны байгууллага болон хэсгийн төлөөлөгч заавал тогтоох хэрэгтэй бөгөөд ард иргэдийн хяналт, оролцоо ч үүнд чухал байна. Зарим малын хулгайчид гэмт үйлдлээ нууж, ял хариуцлагаас мултрах зайлсхийх, хөнгөн ял шийтгүүлэхийн тулд хулгайлсан малаа алдуул мал ашигласан болгож мэлздэг учир аль нь болохыг ялган тогтоох хэрэгтэй болдог.

Хүний малыг хол нутгаас хулгайлчихаад өөрийн сүрэгт ижилсүүлж эсхүл өөрийн амьдарч буй газрынхаа ойр орчмоор бэлчээрийг нь солин хариулж маллах явдал сүүлийн үед ихсэх хандлагатай байна. Малаа эрж яваа эзнийг нь ирж сураглахад өөр газар байсан мэтээр хэлж, эрлийг нь төөрөлдүүлж чулуу хөөлгөх буюу эзэнд нь танигдуулахгүйн тулд хулгайлсан малаа шинээр имнэж тамгалах, хуучин им тамгыг нь арилган өөрчлөх, хатуу ширүүн эдэлж нурууг нь авах, олойртуулах, дэл сүүлийг нь хяргаж тайрах, шөрөг хийж эхийгээ хөхдөг мал гэсэн ойлголт, сэтгэгдэл төрүүлдэг байна.

Хэрвээ эзэн нь малаа таньсан юм уу ямар нэгэн байдлаар хулгайлсан этгээдийг мэдсэн тохиолдолд нэн түрүүнд цагдаагийн байгууллагад хандах бус хохирлоо нөхөн төлүүлэх арга саамыг хайж, өөрийн хулгайд алдсан малыг бодит тоогоор нь бус ихэсгэсэн байдлаар нэхэж, энэ хүсэлтийг минь биелүүлбэл үйлдсэн гэмт хэргийг чинь хууль хяналтын байгууллагад мэдээлэхгүй гэсэн байдлаар доогуур тохиролцох аргыг хэрэглэж гэмт этгээдийг өөгшүүлсэн харьцаа, хандлагыг бий болгож байна.

Энэ тохиолдолд гэмт этгээд өөрийгөө Цагдаагийн байгууллагад баригдуулахгүй тулд хохирогчид хүссэн, шаардсан малыг нь өгөхөөр тохирч өөр хэн нэгний малыг хулгайлж дамжуулна. Энэ мэтчилэн нэг иргэнд учируулсан хохирлыг барагдуулахын тулд нөгөөгийн малыг хулгайлан дамжуулсан гэмт этгээдийн үйлдэл цааш аалзны тор лугаа адил давтан

¹ “Төрийн мэдээлэл” сэтгүүл, 1992 он, ¹

⁴² Д.Дашдэмбэрэл.”Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн эрх зүй, криминологийн зарим асуудал” Уб. 1989. 56 дахь тал

⁴³ Т.Мөнхдалай. Мал хулгайлах гэмт хэргийн криминологийн шинж ба урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох нь. Уб. 2001. 55 дахь тал

⁴⁴ Төрийн мэдээлэл. 2002. №7. Иргэний хууль

үргэлжилж, хэзээ ч, хэний ч, хэдэн ч малыг хулгайлах нь тодорхойгүй атлаа ийм гэмт хэрэг үйлдэх санаа бодлыг цаг ямагт төрүүлдэг сэтгэл зүйн байдалтай болдог байна. Ингэж хохирогчийн шахаанд орж түүний шаардсан тоо, хэмжээгээр тохиролцох явдлыг практикт “доогуурчлах” хэмээн нэрлэдэг ба энэ нь мал хулгайлах гэмт хэрэг нуугдмал байдлаар үйлдэгдэн гарч, гэмт этгээдэд ял завшуулж, бусдыг хохироож байна.

Мөн түүнчлэн аймаг сумдад зохион байгуулж буй “Бүсийн, Даншигийн, Улсын, Тэмдэглэлт ойн” гэх мэт тодотголтой их хурд хурдан морины уралдааныг далимдуулан гэмт этгээдүүд хулгайлан авсан адууныхаа хөхөл, дэл, сүүлийг нь боон, нөмрөг, нэмнээ тохон хурдны адуу мэт харагдуулан тээврийн хэрэгслээр зөөж тээвэрлэдэг арга ч сүүлийн үед гарч ирж байна. Энэ мэтчилэн үйлдэгдэж буй мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд шударга иргэдийн хүч, туслалцааг авч ажиллах шаардлагатай.

Өнөөдөр мал хулгайлах гэмт хэрэг өвөрмөц аргаар үйлдэгдэж байна. Тухайлбал:

- хээр задгай бэлчээрт хариулга маллагаагүй байх үед хулгайлах;
- машин техник ашиглан хөдөө орон нутагт очиж хээрийн бэлчээрт эзэнгүй байгаа мал сүргээс шилж алан махыг авах;
- хашсан, хотлуулсан малаас нь шөнийн цагаар ганц нэгээр нь хулгайлан авч, зайтай газар нядлах;
- хулгайлсан малаа эзгүй, нууцлаг, зөвхөн өөрсдийн мэдэх газарт аваачин нууж, тохиромжтой цаг хугацааг хүлээн аажмаар махлах зарах;
- малыг нутаг дамжуулан солилцох зохион байгуулалттай хулгайн бүлэг бэлчээрт байгаа малыг хоцроох, бусдаас нь салгах өндөр үр ашигтай, үнэ хүрэх малыг малыг хулгайлах;
- мал хулгайлан хил давуулан дамжуулан, борлуулах, солилцох гэх мэтийн аргуудыг нэрлэж болох юм.

Сүүлийн жилүүдэд мал хулгайлах гэмт хэргийн тоон үзүүлэлт тогтвортойгоор буурсан нь харагдаж байгаа ч нөгөө талаас үйлдэгдэн гарсан гэмт хэргийн талаархи мэдээ, мэдээллийг төр захиргаа, хууль хяналтын байгууллагад шуурхай мэдээлэх явдал хангалтгүй, энэ талаар иргэдээс Цагдаагийн байгууллагад ирүүлсэн гомдол, мэдээлэл нь хугацаа алдаж, ул мөр арилж баларснаар мал хулгайлах гэмт хэргийг халуун мөрөөр нь шуурхай бүрэн дүүрэн илрүүлэх ажиллагааны үр дүн хангалтгүй болж бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтэд нөлөөлсөн байж болох үндэслэлтэй.

Сумын төвөөсөө хол амьдардаг иргэд өөрт буй мэдээ, мэдээллийг цагдаад даруй, шуурхай дамжуулах боломжгүй байдаг. Гар утасны сүлжээ бүх сумдад тавигдаж харилцаа холбоо хөгжсөн өнөө үед гэмт хэргийн талаархи мэдээ, мэдээллийг тухайн иргэн багийн даргадаа, багийн дарга нь орон нутгийн цагдаагийн байгууллагадаа дамжуулах гэсэн мэдээллийн шатчилсан сүлжээг бий болгон биелэлт, үр дүнг нь тооцон ажиллах нь мал хулгайлах гэмт хэргийг халуун мөрөөр нь шуурхай, мөрдөж илрүүлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд ашиг тустай ажил болно гэж бодож байна.

Мал хулгайлах гэмт хэрэг улирлын чанартай үйлдэгддэг байсан нь өнөөдөр улирал, цаг хугацаа, орон зайнаас төдийлөн хамаарахгүй болов.

Улс орны нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, хөдөөнөөс хот руу чиглэсэн иргэдийн шилжилт хөдөлгөөн, хүн амын ядуурал, ажилгүйдэл, хот хөдөөгийн ялгаа, амьжиргааны тэгш бус байдал, мал махны зах зээл дэх эрэлт хэрэгцээ, малчдын өөрсдийн хайнга, малаа хариуцлага маллагаагүй байлгадаг, хариуцлагагүй, сонор сэрэмжгүй байдал зэрэг нь уг гэмт хэрэг үйлдэгдэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

Малын хулгайчид гэмт үйлдлээ хийхээр урьдчилан бэлтгэхдээ хулгайлах малаа сонгон олж, хариулга маллагаагүй байдаг цаг үеийг мэдэж, өглөө бэлчээрлэдэг, орой хотондоо ирдэг цаг, хээр эзэнгүй хонодог үе, эзэд нь хол ойр, хонуут өнжүүтээр явсан, малаа эргэдэг, харж хамгаалдаг, хашаа саравчны байдал, хөөж туух зам, алж нядлах болон машин унаагаа зогсоож очих газар орныг судалж товлосон байдаг.

Малчид өөрсдийн сонор сэрэмжгүй, хариуцлагагүйгээсээ болж хулгайд малаа алдсан тэр даруйд цагдаад мэдэгдээгүйн улмаас уг гэмт хэргийн ул мөр баларч, илрүүлэлтийн түвшин бууран, гэмт этгээд ял завшаад зогсохгүй, дахин давтан мал хулгайлж, улмаар уг гэмт хэргийг дагнан үйлддэг бүлэг үүсэх үндэс суурь болж байна.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.1.3-т “малаа байнгын хариулга, манаатай байлгаж хулгайд алдахгүй байх бусад арга хэмжээг орон нутгийн болон улирлын онцлог, боломжид тохируулан авах үүрэгтэй”⁴⁵ гэж заасан боловч иргэд үүнийг төдийлөн анхаарч, үүргээ биелүүлдэггүй нь хүндрэл бэрхшээлийг бий болгож байна. Түүнчлэн уг хуулийн 16.5.2-д: “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үүрэг гүйцэтгэж байгаа эргүүл, жижүүр, харуулыг урамшуулах” тухай заасан боловч энэ заалт хэрэгжихгүй байгаа нь мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр дүнд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж үзэж байна.

Урьд өмнө мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, хорихоос суллагдсан, хорих ял нь тэнссэн этгээдэд тавих захиргааны хяналт нь ганцхан цагдаагийн байгууллагын үүрэг мэтээр ойлгодог явдлыг өөрчлөн уг хяналтыг төр, хууль, олон нийтийн байгууллага, түүний албан тушаалтан, иргэдийн хүч туслалцаанд түшиглэн явуулах, ялангуяа урамшууллын арга хэлбэрийг өргөн ашиглах нь зохих үр дүнгээ өгөх болно.

Төр засгаас сүүлийн жилүүдэд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бие даасан хууль батлан гаргаж, төв, орон нутгийн хууль хяналт, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн байгууллагуудын хүчээр зарим ажил хийж байгаа боловч төдийлөн ахиц гарахгүй, ялангуяа төвийн бүсэд сүүлийн жилүүдэд дэд бүтэц эрчимтэй хөгжиж, хүн амын тоо эрс нэмэгдэж байгаатай уялдан махны асар их эрэлт хэрэгцээ үүсч, малын хулгай газар авах нөхцөл бүрэлджээ.

Байгаль цаг уурын өөрчлөлт, ган зуднаас болж зарим малчдын мал нь цөөрч, хот нь харлан малгүй болсон зэрэг нь малчин өрхүүд төвлөрсөн суурин, аймгийн төв, хот руу шилжин суурьших явдал тасрахгүй байгаа бөгөөд энэ нь тодорхой эрхэлсэн ажилгүй, нутаг орноо сайн мэдэх хүмүүсээс мал хулгайлах гэмт хэрэг үйлдэх, хамтран оролцох явдалд нөлөөлөх нь түгээмэл байна.

Хүчит шонхор, Нарантуул, Хархорин, Эмээлт, Налайх захууд болон бусад төв суурин газарт мал, махны ченж нэртэй гэмт хэргийн захиалагч, зохион байгуулагчийн гараар дамжуулан мал, мах зарж борлуулдаг байдлыг таслан зогсоох, малчдаас шууд хэрэглэгч рүү чиглэсэн эрүүл ахуйн шаардлага нөхцөлийг хангасан төвлөрсөн цэгээс дэлгүүр, худалдаа, үйлчилгээний төвүүдэд мах, махан бүтээгдэхүүнийг түгээх, зарж борлуулах шийдвэрийг эрх бүхий байгууллагаас гаргуулан мөрдөж ажиллахын зэрэгцээ мах, малын гаралтай түүхий эдийн гарал, үүслийн гэрчилгээнд тавих хяналт шалгалтыг мэргэжлийн хяналт болон бусад эрх бүхий байгууллага, иргэдийн оролцоотой зохион байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулан ажиллах шаардлагатай байна.

Малчид, мал бүхий иргэдийн өмчлөл, эзэмшилд байгаа малынх нь им тамга, бусад таних тэмдгийн талаар цагдаагийн болон орон нутгийн төр захиргааны байгууллага

⁴⁵ Төрийн мэдээлэл. 2004. №23. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль

тусгайлан нэгдсэн бүртгэл хөтлөх нь нэн чухал юм. Учир нь алдагдсан малыг олох явцдаа хэсгийн төлөөлөгч болон хэсгийн байцаагч нь энэхүү бүртгэлийг ашиглах нь тус нэмэр болох юм.

Мөн хөдөө малын дэргэд өсөөгүй, малын зүс, им тамга, тэмдэг сайн мэдэхгүй хэсгийн байцаагч, төлөөлөгч нь тухайн хариуцсан орон нутагтаа мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг төдийлөн сайн зохион байгуулж чадахгүй байгаа явдал ажиглагдаж байна.

Дүгнэлт. Манай улсад мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр олон ажил, арга хэмжээнүүдийн үйл ажиллагаандаа ашигласаар ирсэн боловч тухайн ашигласан аргуудынхаа үр дүнг тооцож, ач холбогдлоор нь эрэмблэх ажил өнөөг хүртэл хийгдээгүй байгаа нь тулгамдсан асуудал болжээ.

Малыг ихэвчлэн бэлчээр дээрээс нь тууж машинд ачих, жижиг оврын автомашинтай бол газар дээр нь нядалж, эвдээд аваад явж байна. Малын хулгайн гэмт хэргийн гол үйлдлийн арга нь бэлчээрээс шөнө оройн цагаар хариулга муутай малыг авч, хулгайлдаг нь харагдаж байна.

Мал хулгайлах гэмт хэргийг ихэвчлэн 15-40 орчим насны хүмүүс үйлддэг нь судалгаанаас харагдаж байх бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгт ихэвчлэн малчид, малтай байж байгаад, малгүй болчихсон, эсхүл өр зээлд орчихсон хүмүүс гэмт хэрэгт холбогдож байгаа нь анхаарал татаж байна. Түүнчлэн холбогдогчдын нэлээдгүй хэсэг нь дахин давтаж гэмт хэрэг үйлдэж байгаа төдийгүй зохион байгуулалттайгаар бүлэглэж үйлдэхээс гадна махны ченжүүдтэй хамтарч гэмт хэрэг үйлдэж байгаа нь тулгамдсан асуудал болоод байна.

Санал. Мал хулгайлах гэмт хэрэгтэй ажлын үр нөлөөг дээшлүүлэх, арга зүйг сайжруулах чиглэлээр дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Алдуул мал болон малын им тамганы нэгдсэн сүлжээ бий болгох замаар мэдээ, мэдээллийг шуурхай дамжуулах шаталсан сүлжээ бий болгон хэрэгжүүлж, үр дүнг тооцох хариуцлагын тогтолцоог бий болгох;

2. Иргэн, аж ахуй нэгж, байгууллага төв суурин газарт худалдаалах зорилгоор бэлтгэн нийлүүлж байгаа мал, мах, малын гаралтай бүтээгдэхүүнд Мал эмнэлгийн байгууллагаас мал эмнэлгийн гэрчилгээг авч цахим санд бүртгүүлсний үндсэн дээр тээвэрлэх;

3. Тээврийн хэрэгслийн жолооч мал, мах, малын гаралтай бүтээгдэхүүнийг тээвэрлэхдээ мал эмнэлгийн гэрчилгээтэй эсэхийг шалгасны үндсэн дээр тээвэрлэх үүрэгтэй болохыг сурталчилан таниулах;

4. Малын хулгайн нуугдмал хэргийг илрүүлэхийн тулд “мал хулгайлсан гэмт хэргийг үл мэдээлсэн, нуун дарагдуулсан, гэмт хэрэг үйлдэж олсон мал гэдгийг мэдсээр байж урьдчилан амлалгүйгээр авсан, борлуулсан тохиолдолд та өөрөө эрүүгийн хариуцлага хүлээх болно шүү” гэдгийг иргэдэд тайлбарлан ойлгуулах, зөвлөмж гаргах, хуулийн хэрэгжилтийг бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

5. Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тасаг, хэсгийн алба хаагчдын мэргэшүүлэх, чадваржуулах сургалтыг тасралтгүй зохион байгуулж явуулах

6. Мал сүргээ гэмт халдлагаас хамгаалах чиглэлээр иргэдийн үүсгэл санаачлагаар бий болсон эвсэл, холбоо, хөдөлгөөний үйл ажиллагааг төр, хууль хяналт, олон нийтийн байгууллагаас бүхий л талаар дэмжин урамшуулж байх

7. Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдлээд суллагдаж, захиргааны хяналт тогтоогдсон этгээдэд тавих хяналтыг цагдаагийн байгууллага дангаараа бус олон нийтийн болон аж ахуйн нэгж, байгууллага, түүний албан тушаалтан, иргэдийн оролцоонд түшиглэсэн хамтын ажиллагаагаар явуулах.

Ашигласан материалын жагсаалт.

Монгол Улсын хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Монгол Улсын Эрүүгийн хууль
3. Иргэний хууль
4. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль.

Ном, сурах бичиг, гарын авлага:

1. Д.Дашдэмбэрэл. Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн эрх зүй, криминологийн зарим асуудал. УБ. 1989
2. Т.Мөнхдалай. Мал хулгайлах гэмт хэргийн криминологийн шинж ба урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох нь. УБ. 2001
3. Л.Батжав. Гэмт явдал, түүний шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх асуудал. УБ.2002
4. Н.Ф.Кузнецова. Претупление и преступность. М. 1992

Сэтгүүл:

1. Төрийн мэдээлэл. 1992. №1.
2. Төрийн мэдээлэл. 2002. №7.
3. Төрийн мэдээлэл. 2004. №23

ГЭМТ ХЭРГИЙН ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА БА
ЗАРИМ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГТ ИЛРЭХ ГАЖУУДАЛ
LEGAL REGULATION OF CRIMINAL PROCEEDINGS AND
ITS DIFFERENCES IN CERTAIN CRIME

Б. Баярболд

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн
багш, цагдаагийн ахлах дэслэгч,
хууль зүйн магистр*

Bayarbold B.

*Police School at University of Internal Affairs,
Department of Criminal Law and Criminology,
lecturer police senior lieutenant, /master of law/*

Хураангуй: Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрүүгийн хуульд заагдсан зарим нэг төрлийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны онцлог ба гажуудал ба тулгамдаж буй асуудлын талаар тодорхой жишээн дээр тайлбарлав.

Abstract: The specifics and distortions of the statute of limitations for certain types of crimes under the current criminal law in Mongolia are explained with specific examples.

Түлхүүр үг: Хөөн хэлэлцэх хугацаа, хулгайлах, залилах гэмт хэрэг, хохирлын хэмжээ

Keywords: statute of limitations, crime of theft, fraud, amount of damage

Оршил. Эрүүгийн хуулийн зорилго нь хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэгддэг. Энэ ч утгаараа эрүүгийн хариуцлага нь хүний эрхийг хамгийн ихээр хязгаарладаг хариуцлагын хэлбэр билээ. Хүн бүр тэгш эрхтэй ч Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрхийг хуулиар хязгаарлах нь зүйн хэрэг.

Нөгөөтээгүүр хүний эрх, эрх чөлөөг хамгийн ихээр хязгаарладгийнхаа хувьд Эрүүгийн хууль эрх зүйн хэм хэмжээний хийдэлтэй байвал нийгэмд сөрөг үр дагавар үүсгэж, хүний эрхийг хязгаарлах гол хэрэглүүр болж хувирахыг ч үгүйсгэх аргагүй.⁴⁶

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх болсноос хойш дөрвөн жил орчим болж байна. Хэдийгээр энэ хугацаанд хуулийг нэг мөр ойлгон хэрэглэх, хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн ажлууд хийгдэж байгаа ч практикт хэрэгжүүлэхэд

⁴⁶ Г.Халиунаа, Б.Ариунжаргал (2019), Эрүүгийн хуулийн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны асуудал хүний эрхийг зөрчих нь, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, №1, 54-61 дэх тал.

хүндрэлтэй, эрх зүйн хийдэл бүхий зохицуулалт цөөнгүй байна. Тэдгээрийн нэг нь Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан “Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа”-ны талаарх зохицуулалт юм.

Тухайлбал эрүүгийн хуулинд заагдсан зарим төрлийн гэмт хэргүүдийн хувьд тэдгээрийн нийгэмд учруулах хор хөнөөл нь хөөн хэлэлцэх хугацаатайгаа дүйцэхгүй байгаа нь шударга ёсны зарчим, тэгш эрхийн зарчимд харшилж байна.

Энэ нь гэм буруутай этгээдүүдийн эрхийг зөрчих, цаашилбал гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн эрх ашгийг ноцтой зөрчхөд хүрээд байгаа бөгөөд ямар тохиолдолд тухайн хуулийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой заалт, гажуудлууд илэрч гараад байгаа талаар энэхүү өгүүллээр гарган ирэхийг эрмэлзэв.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дахь хэсэгт заагдсан хөөн хэлэлцэх хугацааны зарим нэг гажуудлыг мөн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 1 болон 2.2 дахь хэсэгт заагдсан гэмт хэрэг дээр тус тус жишээ болгон гаргаж ирж, хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой заалтуудыг нэн шуурхай өөрчилж, хүний эрхийг хамгаалахад энэхүү өгүүллийн гол зорилго оршино.

Үндсэн хэсэг. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга батлагдан үйлчилж эхэлснээс хойш, өндөр хохиролтой залилах, авлига, албан тушаалын хэргүүд хөөн хэлэлцэх хугацаа дууссанаар хэрэгсэхгүй болсон тохиолдлууд цөөнгүй гараад байна Албан тушаалтнуудын холбогдсон хэргүүдийг удаан хугацаанд шалгаж, шүүхийн шатнаас мөрдөн байцаалтад буцаах байдал газар авсан энэ гажууд үзэгдэл нь нийгэмд чамгүй маргааныг дагуулаад байгаа билээ.

Эрүүгийн эрх зүйд эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа, шүүхийн таслан шийтгэх тогтоол биелүүлж болохгүй хугацаа гэсэн хоёр ойлголт байдаг. Энд дурдагдах эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа гэсэн ойлголт нь манай улсад 1926 оны Шүүх цаазын бичигт хүртэл "ял үл хэлэлцэх асуудал" гэж тусгагдаж байсан. Мөн үе үеийн эрүүгийн хуулиудад хуульчлагдаж байжээ.

Эх газрын эрүүгийн эрх зүйн системд эрүүгийн хэрэгт татаж болохгүй хугацаа нь хэрэгтнийг олж илчлэх хүртэл тоолдог хугацаа бөгөөд хөөн хэлэлцэх хугацаа дуусахаас өмнө хэрэгтэн баригдвал хугацаа тоолохыг зогсоож хариуцлагад татна. Мөн эрүүгийн хариуцлагад татна гэдэг нь гэмтнийг яллагдагчаар татаж тогтоол танилцуулснаар эхэлдэг. Яллагдагчаар нэгэнт татсан бол хэргийг заавал хянан шийдвэрлэж дуусгах зарчимтай.

Харин манай эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг “...гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл” тоолохоор заасан нь зарчмын зөрүүтэй байна 2002 оны Эрүүгийн хууль үйлчилж байх үед эрүүгийн хэргийг шалгаж эхэлснээр хөөн хэлэлцэх хугацааг зогсоодог байсан. Харин одоогийн хуулиар хэргийг шалгаж байх явцад ч хөөн хэлэлцэх хугацаа тоологдсоор байгаа юм. Аливаа гэмт хэрэг, зөрчлийг шүүхийн шатнаас мөрдөн байцаалтад буцаадаггүй байх нь шударга шүүхийн гол үзүүлэлт байх ёстой. Харин манай улсын гэмт хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны хамгийн том дутагдал буюу хүний эрх, хууль ёсыг доголдуулж байгаа үйлдэл бол хэргийг шүүхийн шатнаас мөрдөн байцаалтад буцаах явдал юм. Энэ нь нэг талаас шүүгч тухайн хэргийг шийдэж чадахгүй ур чадвар дутагдаж байгаа, нөгөө талаас авлига хээл хахууль авч зориудаар хэргийн хянан шийдвэрлэх хугацааг удаашруулж байх хардлагыг төрүүлж байгаа юм.

Жишээ нь АНУ-д эрүүгийн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь хэрэг хянан шийдвэрлэх аль үе шат эхлэхийг тодорхойлдог. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны

зорилго нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн шуурхай гүйцэтгэх, мөн нотлох баримт хуучирсан, эрүүгийн хариуцлагын ач холбогдол алдагдсан тохиолдолд ялаас хэлтрүүлэх явдал гэж үздэг⁴⁷. Хөөн хэлэлцэх хугацаа Холбооны 8 дугаар кодын 3282-т “Холбооны Улсад үйлдэгдэж буй гэмт хэргийн хөөн хэлэлцэх үндсэн хугацаа 5 жил байна. Гэвч энэ хугацаа нь зарим гэмт хэргийн хувьд урт эсвэл богино байх боломжтой” гэж заажээ. Цаазаар авах ялтай болон терроризм, хүүхэд хулгайлах гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолдоггүй. Урлагийн томоохон бүтээлийн хулгай 20 жил, галдан шатаах, санхүүгийн луйвар, албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох, сүлжээний болон цахим шуудангийн луйврын гэх мэт төрлийн гэмт хэрэгт 10 жил, дипломат ажилтнуудад халдах дайрах, конгрессын гишүүнд халдах, ерөнхийлөгч болон түүний ажилтнуудад халдах дайрах хэрэг, хүний амь нас хохироогоогүй терроризмын шинжтэй гэмт хэргүүдэд 8 жил, шашны эд зүйлд халдах, үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэргүүд луйврын зарим хэргүүдэд 7 жил, татвар, итгэмжлэл, хөрөнгийн зах зээлийн гэмт хэргүүдэд 6 жил, онцлон зааснаас бусад гэмт хэрэгт 5 жил, төрийн байгууллагын нэр, тэмдэг буруугаар ашиглах гэмт хэрэгт 3 жил, шүүхийг үл хүндэтгэх гэмт хэрэгт 1 жил хөөн хэлэлцэх хугацааг тус тус тоолдог байна.

ХБНГУ-д мансууруулах бодис болон алах хядах ажиллагаа, дайны гэмт хэрэгт 10 жил байсныг 30 жилээс доошгүй болгож, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хугацаа хөөн хэлэлцэхгүй байхаар тогтоосон байх жишээтэй. Сүүлчийн хууль хүчин төгөлдөр болохын өмнө хөөн хэлэлцэх хугацаа нь дууссанаас бусад тохиолдолд уг хугацааг энэ хуулийнхаа дагуу тоолж шийдвэрлэгдэхээр хатуу тогтоосон байна. Олон улсын жишээнээс харахад хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн нийгмийн хор аюулаас хамааруулан ялгамжтай тогтоодог болох нь харагдаж байна. Мөн тухайн гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, ял сонсгосноор хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож цааш ердийн журмаар хэргийг шалгаж шийдвэрлэдэг болох нь олон улсын практикаас харагдаж байна.

Манай улсын хувьд 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Эрүүгийн хуульд анх “...гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн хүчин төгөлдөр болох хүртэл” хэмээн зааж өгч байсан нь олон нийтийн дунд маргааныг дагуулж байсан ба үүнээс үүдэж их хэмжээний хохиролтой, томоохон хэргүүдийн хөөн хэлэлцэх хугацаа дуусч, гэм буруутай этгээдүүд ялаас мултарч байсан удаатай.

Харин 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн өөрчлөлтөөр “...Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно...” хэмээн зааж өсгөн нь цагаа олсон өөрчлөлт болсон юм. Хөөн хэлэлцэх хугацаа нь нэг талаасаа хүний эрхийг, ялангуяа гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх, түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх, гэм буруугаа ухаарах хугацааг олгох боловч хохирол өндөртэй, олон хохирогчтой хэргийн хөөн хэлэлцэх хугацааны ард зөвхөн хохирогч нарын эрх маш ноцтойгоор хөндөгдөж байдаг.

Үүний нэг жишээг Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайлах” гэмт хэрэг, мөн хуулийн 17.3 дугаар зүйлд заасан “Залилах” гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа болон нийгэмд учруулах хор хөнөөлийг харьцуулъя.

17.1 дүгээр зүйл Хулгайлах	17.3 дугаар зүйл Залилах
1. Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл	1. Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг

⁴⁷ Statute of Limitation in Federal Criminal Cases: An Overview, 2017, Charles Doyle, Senior Specialist in American Public Law

хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2.Энэ гэмт хэргийг:	
2.1.хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч;	2.1.албан тушаалын байдлаа ашиглаж;
2.2.түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж;	2.2.бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
2.3.ноцтой хохирол учруулж, их хэмжээний эд хөрөнгийг хулгайлж;	
2.4.учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	
3.Энэ гэмт хэргийг:	
3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон;	3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон;
3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	3.2.олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн;
	3.3.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй.	

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хулгайлах гэмт хэргийн 1 дүгээр зүйлд хохирлын доод хэмжээг зааж өгсөн байх бөгөөд бага хэмжээний хохирол⁴⁸ учруулсан тохиолдолд гэм буруутай этгээдэд эрүүгийн хуулиар бус, харин зөрчлийн хуулиар хариуцлага тооцдог байхад залилах гэмт хэргийн үед хохирлын доод хэмжээг зааж өгөөгүй нь тухайн гэмт хэргийн нийгэмд учруулах хор уршиг, гэм буруутай этгээдийн залилах гэмт сэдэл нь ямар аюултай болох талаар тусгайлан заасан байна.

Гэвч дээрх хоёр төрлийн гэмт хэргийн 1 дүгээр зүйлд заасан үйлдлийн улмаас нийгэмд учруулах хохирол, хор уршиг ижил төстэй байсан ч хөөн хэлэлцэх хугацааны хувьд ялгагдах, мөн түүнчлэн тус тусын хэрэгт учруулсан хохирол, хор уршигтай нь хөөн хэлэлцэх хугацаа нь дүйцэхгүй байх нөхцөл байдал бүрдээд байна.

Залилах гэмт хэргийн 2.2 дахь хэсэгт зааснаар хохирлын хэмжээг зааж өгсөн байгаа нь зүйн хэрэг боловч зөвхөн "...бусдад ноцтой⁴⁹, эсхүл их хэмжээний хохирол⁵⁰ учруулж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ..." хэмээн заасан нь учруулсан хохирлоос хамаарч, оногдуулах ял болон хөөн хэлэлцэх хугацаа нь өөрчлөгдөж байгаа нь зүй ёсны хэрэг боловч нөгөө талаас зарим нэг хийдлүүдийг гаргаж гаргаж ирж байна. Ялангуяа зөвхөн их хэмжээний хохирол хэмээн зааж өгсөн нь алдаатай байна. Үүнийг тодорхой жишээнд тулгуурлан авч үзье.

Тохиолдол 1:

Иргэн А нь 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдөр БНСУ-ийн Виз гаргаж өгнө хэмээн Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт иргэн Б-ээс нийт 40 сая төгрөгийг хуурч мэхлэн, бодит байдлыг нуух замаар авч залилсан.

Эрүүгийн хуульд 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр тус хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.5 дахь заалтад "энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн." хэмээн зааж өгсөн байна. Үүнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйл 1 дэх хэсэг шууд хамааралтай байна.

Уг тохиолдолд гарч байгаа 40 сая төгрөг нь их хэмжээний хохиролд тооцогдохгүй ба харин эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 4.2 дахь хэсэгт заасан "үлэмж хэмжээний хохирол" бөгөөд үүнд арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш буюу тавин мянган нэгж хүртлэх мөнгөн дүнг ойлгоно.

Харин тухайн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь 3 жил бөгөөд учирсан нийт хохирлын хэмжээ нь 40 сая төгрөг болж байна. Гэтэл тухайн хэрэгт оногдуулах торгуулийн ялын дээд хэмжээ нь 15 сая төгрөг хэмээн заасан байна. Мэдээж ийм хохиролтой хэрэгт тийм хэмжээний ял шийтгэл оноохгүй нь зүй ёсны хэрэг. Гэвч хорих ял оноохоор бол энэ тохиолдолд ялын дээд хэмжээ нь 3 жил байгаа нь учруулсан хохирлын хэмжээтэй дүйцэхгүй байна.

⁴⁸ ЭХЕА-ийн 2.5 дугаар зүйлийн 4 дахь хэсгийн 4.3-т зааснаар "бага хэмжээний хохирол" гэж гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс доош хэмжээг ойлгоно.

⁴⁹ ЭХЕА-ийн 2.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар "ноцтой хохирол, хор уршиг" гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эд хөрөнгийн эрхэд, эсхүл улс орон, хүн амын аюулгүй байдалд ач холбогдол бүхий эрхэд хохирол, хор уршиг учирсныг ойлгоно.

⁵⁰ ЭХЕА-ийн 2.5 дугаар зүйлийн 4.1 дэх хэсэгт зааснаар "их хэмжээний хохирол" гэж тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг;

Залилах гэмт хэргийн 1 дүгээр хэсэгт хохирлын доод хэмжээг зааж өгөөгүй боловч 2 дахь хэсэгт шууд их хэмжээний хохирол учруулсан хэмээн оруулсан учир дутагдалтай байна. Учир нь Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт заагдсан их хэмжээний хохиролд 50 сая буюу түүнээс дээш төгрөгийн хохирол учруулсан тохиолдолд л хөөн хэлэлцэх хугацаа 5 жил болж байгаа бөгөөд нэгэнт учруулсан хохирлын хэмжээнээс хамаарч хөөн хэлэлцэх хугацааг тоолж байгаа тохиолдолд бусад төрлийн хохирлыг ч мөн шат дарааллуулан оруулж, түүнтэй уялдуулж хөөн хэлэлцэх хугацааг өөр өөрөөр тоолох нь зүйтэй.

Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлд хохирлын хэмжээг ангилан тусгаж өгсөн боловч, тэрхүү хохирлын хэмжээг үндэслэн зарим төрлийн гэмт хэрэг, тэр тусмаа Залилах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг дээрх хохирлын хэмжээний төрлүүдтэй нийлцүүлэн өөрчлөхгүй бол бага хэмжээний хохирлоос дээш хохиролтой хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдал дордож байна.

Бага хэмжээний хохирлоос үл ялиг өндөр хохиролтой хулгайлах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг их хэмжээний хохирлоос үл ялиг бага хохиролтой залилах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай харьцуулахад учруулсан хохирлын хэмжээ, хөөн хэлэлцэх хугацаа нь өөр хоорондоо ялгагдах бөгөөд мөн шударга ёсны зарчим алдагдаж байна. Үүнийг жишээн дээр тайлбарлая.

Тохиолдол 2:

Иргэн А нь 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хэмээн Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт иргэн Б-гийн эзэмшлийн 350,000 төгрөгийн үнэ бүхий гар утсыг түүний халааснаас нууцаар, хууль бусаар авсан.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дэх хэсэгт “энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн” хэмээн зааж өгсөн нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан Хулгайлах гэмт хэргийг шууд хамааруулж ойлгох бөгөөд дээрх тохиолдолд учирсан хохирол буюу 350,000 төгрөг нь бага хэмжээний хохирлоос дээш байна.

Асуулт 1: Тохиолдол 1-т гарч байгаа 40 сая төгрөгийн хохирол тохиолдол 2-т дурдагдаж байгаа 350,000 төгрөгийн аль нь нийгэмд илүү хор хөнөөл учруулж байна вэ?

Асуулт 2: Хулгайлах гэмт хэргийн улмаас учирсан хохирол 350,000 төгрөг, хөөн хэлэлцэх хугацаа нь 5 жил, харин залилах гэмт хэргийн улмаас учирсан хохирол 40 сая төгрөг хөөн хэлэлцэх хугацаа нь 3 жил байна. Хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэргийн нийгэмд учруулсан хохирол, хор уршиг, аюул, мөн хэргийг илрүүлэх хүртэлх мөрдөн шалгах хугацааг тус тус харгалзаж тоологдох нь үндэслэлтэй юу? гэсэн асуултууд гарч ирж байгаа ч хариулт нь маш энгийн юм. Гэвч шийдэл нь одоогоор тодорхойгүй байна.

Хулгайлах гэмт хэргийн хохирогч нь эд зүйлсээ хулгайд алдсанаа тэр дороо эсвэл хэсэгхэн хугацааны дараа буюу хэдэн хоног, эсвэл хэдэн цаг, минутын дараа мэддэг байхад, залилах гэмт хэргийн хохирогч нь ихэнх тохиолдолд өөрийн эд зүйлсээ залилуулсан тухайгаа гол төлөв хэдэн сар, жилээр хэмжигдэх урт удаан хугацаа өнгөрсний дараа мэдэж ойлгож, хууль хяналтын байгууллагад гомдлоо гаргадаг.

Ингээд хугацаа алдаж гомдол гаргасан ч хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс эхлэн тоолдог учир ихэнх тохиолдолд залилах гэмт хэрэг хөөн хэлэлцэх

хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болдог байна. Энэ нь эцсийн дүндээ хохирсон иргэдийн эрхийг улам бүр зөрчиж байгаа сөрөг талтай билээ.

Дүгнэлт. Үүнээс дүгнэхэд хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой Эрүүгийн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийн зарим нэг гажуудлыг хөндөн гаргаж ирэх зорилготойгоор илтгэлээр дамжуулан хэдэн жишээн дээр тайлбарлахыг эрмэлзсэн бөгөөд үүнээс гадна хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь тодорхойгүй байдал, мөн өөр зарим нэг төрлийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь хэргийн удаашралтай шалгагддаг онцлогтой харилцан уялдаагүй байдлаар хуульд заагдсан асуудлууд эрдэмтэн судлаачдын дунд өнөөдрийг хүртэл маргаан дагуулсаар л байна.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрүүгийн хуулиар гэм буруутай буруутай этгээдүүдийн үйлдсэн гэмт хэргийн улмаас учирсан хор хөнөөл харилцан адилгүй байхад хөөн хэлэлцэх хугацаа нь хор уршигтайгаа уялдаж өгөхгүй байгаа нь нэг талаасаа гэм буруутай этгээдүүдийн үйлдсэн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаагаар илрэн гарч байна.

Нөгөө талаасаа гэм буруутай этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлж байгаа эрх зүйн зохицуулалт мэт боловч цаана нь гэмт хэргийн улмаас хохирсон эгэл жирийн иргэдийн эрх ашиг маш ноцтой хөндөгдөж байгаа ийм төрлийн гажуудал, хийдлүүд байсаар байгаа ч нэг талдаа шийдэгдэж чадахгүй байна.

Иймд Эрүүгийн хуулийн 1.10 дахь хэсэгт заагдсан хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой заалтуудыг дахин эргэн харж, засаж сайжруулах шаардлагатай байна.

Санал. Дээрх дүгнэлтэд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх 3 жилийн хугацааг хохирлын хэмжээнээс хамаарч нэмэгдүүлэх;
2. Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "үлэмж хэмжээний хохирол" гэх нэр томъёо бүхий хохирлын хэмжээг нэмж оруулж, хөөн хэлэлцэх хугацааг 5 жил болгож нэмэгдүүлэх;
3. Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх 5 жилийн хугацааг 8 жил болгож нэмэгдүүлэх;
4. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээнээс хамаарч хөөн хэлэлцэх хугацааг харилцан адилгүй тооцох (*ж.нь: тохиолдол 2-т дурдагдаж буй нөхцөл байдалтай төсөөтэй үед хэрэглэх*) зохицуулалтыг эрүүгийн хуулийн 1.10 дахь хэсэгт нэмж оруулах;

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН ХОХИРОГЧИЙН
ХОХИРОЛЫГ НӨХӨН ТӨЛӨХ БОЛОН ХОХИРОЛ
ТООЦОХ ТОГТОЛЦООНЫ ТУХАЙ
범죄피해자구조의 적용범위

ДХИС-ийн ЦС-ийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн тэнхимийн дэд профессор,
цагдаагийн хошууч Б.Батцэрэн

내무대학, 경찰대학교의
형법과 범죄학과 교수,
경찰 경위보. 발체렌

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн хохиролыг нөхөн төлөх болон хохирол тооцох тогтолцоо ба гэмт хэргийн улмаас нас барсан, гэмтсэн болон хүнд гэмтэл авсан, гэмт хэргийн улмаас хохирсон хохиролоо бүрэн болон хэсэгчлэн хохиролоо нөхөн төлүүлж чадаагүй гэх мэт нөхцөл байдлууд бий болсон тохилдолд улсаас хохирогч болон нас барсан хүний ар гэрийнхэнд тогтоосон тодорхой хэмжээний дагуу хохирлын нөхөн төлбөрийг тооцож олгох тухай БНСУ-ын хууль тогтоомжид хэрхэн тусгагдсан талаар орчуулгын бүтээл тавигдсан болно.

“범죄피해자구조제도”란, 범죄행위로 사망하거나 장애 또는 중상해를 입었음에도 불구하고 범죄피해의 전부 또는 일부를 보상받지 못하는 등의 사유가 발생한 경우에 국가에서 피해자 또는 유족에게 일정한도의 구조금을 지급하는 제도를 말합니다(사이버경찰청-범죄피해자 지원).

Түлхүүр үг. Гэмт хэргийн хохирогч, хохирол, нөхөн төлөлт, хохирол тооцох тогтолцоо, нөхөн олговор

키 단어,범죄 피해자, 피해, 보상, 피해를 계산하는 제도,보상

Бүгд найрамдах Солонгос улсад гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн хохиролыг нөхөн төлөх болон хохирол тооцох тогтолцоо хууль тогтоомж болон практик хэрэглээндээ төлөвшлөө олчихсон харилцаа байдаг юм байна.

Нөхөн олговор олгох дараалал нь:

1. Хохирогч нь нөхөн олговор авах тухай хүсэлт /өргөдөл/ гаргах
2. Харьяа нутаг дэвсгэрийн Прокурорын газраас судалсаны үндсэн дээр шийдвэр гаргах /Гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох асуудлыг шийдвэрлэх хурлаар/
3. Нөхөн олговор олгох / хохирогчын ар гэрт, хүнд, ноцтой гэмтсэн, яаралтай нөхөн олговор гэсэн төрлүүд байна.

Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчид хамаарагдах нөхцөл:

Гэмт хэргийн хохиролын нөхөн олговор авах субъект нь:

- Гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох сангаас /цаашид “нөхөн олговор” гэх /БНСУ-ын нутаг дэвсгэрээс гадна байгаа БНСУ-ын усан онгоц, нисэх онгоцон дотор үйлдэгдсэн хүний амь нас болон бусдын бие махбодид гэмтэл учруулсан гэмт хэрэг. /Хохирогчийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.4 /

- Эрүүгийн хэрэгт ял шийтгүүлж байгаагүй насанд хүрээгүй этгээдийн үйлдэл /Эрүүгийн хуулийн 9 дүгээр зүйл/, сэтгэл мэдрийн хувьд хэрэг хариуцах чадваргүй хүний үйлдэл /Эрүүгийн хуулийн 12 дугаар зүйл/, албадлагын арга хэмжээ хэргэлсэн үйлдэл /эрүүгийн хуулийн 12 дугаар зүйл/, яаралтай нүүлгэн шилжүүлэх /Эрүүгийн хуулийн 22 дугаар зүйлийн 1/, энэ тохиолдолд гэмт хэргийн нөхөн олговорт хамаарна /Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.4/.

- Аргагүй хамгаалалт /Эрүүгийн хуулийн 20 дугаар зүйл/, аргагүй хамгаалалт /21 дүгээр зүйлийн 1/ өөр ял оногдуулхаар үйлдэл байхгүй болон өөр гэмт үйлдэл байгаа тохиолдолд нөхөн олговор авах субъект болохгүй /Хохирогчыг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.4/

- Нөхөн олговор авах эрхтэй гадаад улсын иргэн нь “гэмт хэргийн хохирогч” эсвэл талийгаачийн ар гэрийн хүнд хоёр улсын хоорондох харилцан тусалцааны гэрээтэй бол нөхөн олговор авч болно. /Гэмт хэргийн хохирогчыг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйл /

Нөхөн олговор авах хохирогч нас барсан, хөдөлмөрийн чадвар алдсан болон гэмтсэн

Гэмт хэргийн улмаас нас барсан, хөдөлмөрийн чадвараа алдсан болон гэмтсэн тохиолдолд нөхөн олговор олгоно. /Гэмт хэргийн хохирогчыг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.4/

“Хөдөлмөрийн чадвар алдсан” гэж гэмт хэргийн улмаас үүссэн өвчнийг эмчилсний /энэ өвчин эмгэг нь бүрэн эдгэрэх үеийг хүртэл/ дараа бие махбодид үлдсэн шинж тэмдэгийг ойлгоно. /гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.5 /

Хүснэгт №1

Нэг дүгээр зэрэглэл	1. Хоёр нүд нь сохорсон тохиолдолд 2. Зажлах, ярих чадвараа бүрэн алдсан тохиолдолд 3. Мэдрэлийн тогтолцооны үйл ажиллагаа алдсан, үргэлж асрамж шаардлагатай болсон тохиолдолд 4. Цээж, хэвлийн эрхтнүүдийн хэвийн үйл ажиллагаа алдагдсаж, үргэлж асрамжанд байх шаардлагатай байх тохиолдолд 5. 2 гар нь тохойноос дээш алдсан тохиолдолд 6. 2 гар бүрэн мэдрэлгүй болсон тохиолдолд 7. 2 хөл хөлөө өвдөгнөөсөө дээш алдсан тохиолдолд 8. 2 хөл бүрэн мэдрэлгүй болсон тохиолдолд 9. Тахир дутуугийн зэрэг нь нэгээс найм хүртэл гэмтэлтэй дүйцэхүйц гэмтэл авч хөгжлийн бэрхшээлтэй гэж тооцогдсон тохиолдолд
Хоёр дугаар зэрэглэл	1. Нэг нүд сохорч нөгөө талын нүдний хараа 0.02-аас бага болсон тохиолдолд. 2. Хоёр нүдний хараа 0.02-аас бага болсон тохиолдолд 3. Хоёр гар хоёулаа бугуйны үенээс дээш алдсан тохиолдолд 4. Хоёр хөл хоёулаа шагайн үенээс дээш алдсан тохиолдолд 5. Тахир дутуугийн зэрэг нь нэгээс дөрөв хүртэл гэмтэлтэй дүйцэхүйц гэмтэл авч хөгжлийн бэрхшээлтэй гэж тооцогдсон тохиолдолд

Гурав дугаар зэрэглэл	1. Нэг нүд сохорч нөгөө нүдний хараа 0.06-аас бага болсон тохиолдолд 2. Зажлах, ярих чадвараа алдсан тохиолдолд 3. Мэдрэлийн тогтолцооны үйл ажиллагаа алдагдсан, насан туршдаа хөдөлмөр эрхэлж чадахгүй болсон тохиолдолд. 4. Цээж, хэвлийн эрхтнүүдэд гэмтэл учирч насан туршдаа хөдөлмөр эрхлэх боломжгүй болсон тохиолдолд 5. Хоёр гарынхаа бүх хурууг алдсан тохиолдолд 6. Тахир дутуугийн зэрэг нь нэгээс тав хүртэл гэмтэлтэй дүйцэхүйц гэмтэл авч хөгжлийн бэрхшээлтэй гэж тооцогдсон тохиолдолд
Дөрөв дүгээр зэрэглэл	1. Хоёр нүдний хараа 0.06-аас бага болсон тохиолдолд 2. Зажлах, ярих эрхтэнд учирсан гэмтэл нь эмчилгээгээр эдгэрэх боломжтой гэмтэл учирсан тохиолдолд 3. Чихний хэнгэрэг цоорсон эсвэл өөр шалтгааны улмаас сонсголоо бүрэн алдагдсан тохиолдолд 4. Нэг гар нь тохойн үенээс дээш алдсан тохиолдолд 5. Нэг хөл нь өвдөгний үенээс дээш алдсан тохиолдолд 6. Хоёр гарны хуруунууд бүрэн мэдээгүй болсон тохиолдолд 7. Хоёр хөл шагай ба тавхайны ясны үенээс дээш алдсан тохиолдолд
Тав дугаар үе шат:	1. Нэг нүд сохорч нөгөө нүд нь нүдний хараа нь 0.1 бага болсон тохиолдолд 2. Нэг гар бугуйнаас дээш алдсан тохиолдолд 3. Нэг хөл нь шагайны үенээс дээш алдсан тохиолдолд 4. Нэг гар бүрэн мэдээгүй болсон тохиолдолд 5. Нэг хөл бүрэн мэдээгүй болсон тохиолдолд 6. Хоёр хөлийн бүх хурууг алдсан тохиолдолд
Зургаа дугаар үе шат:	1. Хоёр нүдний хараа 0.1-ээс бага болсон тохиолдолд 2. Зажлах, ярих эрхтэнд учирсан гэмтэл нь эмчилгээгээр эдгэрэх боломжтой гэмтэл учирсан тохиолдолд 3. Чихний хэнгэрэгийн ихэнх хэсэг цоорсон эсвэл өөр шалтгааны улмаас 2 чихний сонсголоо алдсан, чанг дуугаар ярьхад сонсохгүй болсон тохиолдолд 4. Нуруунд учирсан гэмтэл нь хөдлөх боломжтой байгаа тохиолдолд 5. Нэг гарны гурван үе мөчний хоёр нь мэдээгүй болсон тохиолдолд 6. Нэг хөлний гурван үе мөчний хоёр нь мэдээгүй болсон тохиолдолд 7. Нэг гарын таван хуруу эсвэл эрхий хуруу ба долоовор хурууг оруулаад дөрвөн хуруугаа алдсан тохиолдолд
Долоо дугаар үе шат:	1. Нэг нүд сохорч нөгөө талын нүд нь 0.6-аас бага хараатай болсон тохиолдолд 2. Чихний хэнгэрэгийн тал нь цоорсон, өөр шалтгааны улмаас 2 чихний сонсгол 40 см-ээс дээш зайд энгийн яриа сонсохгүй болсон тохиолдолд. 3. Сэтгэцийн эмгэгээсээ болж хөнгөн хөдөлмөр эрхэлж чадахгүй болсон тохиолдолд 4. Мэдрэлийн системийн үйл ажиллагаанд учирсан гэмтлээс шалтгаалаад хөнгөн хөдөлмөрөөс бусад хөдөлмөр эрхэлж чадахгүй болсон тохиолдолд. 5. Цээж, хэвлийн эрхтнүүдийн учирсан гэмтлээс шалтгаалаад хөнгөн хөдөлмөрлөхөөс өөр бусад хөдөлмөр эрхэлж чадахгүй болсон тохиолдолд 6. Нэг нарын эрхий хуруу, долоовор хуруу алдсан тохиолдолд эсвэл эрхий хуруу, долоовор хуруу оруулаад гурваас дээш хуруу алдсан тохиолдолд 7. Нэг гарын бүх хуруу эсвэл эрхий, долоовор хуруу оруулаад дөрвөн хуруу бүрэн мэдээгүй болсон тохиолдолд 8. Нэг хөлийн шагай, тавхайны ясны үенээс дээш алдсан тохиолдолд 9. Нэг гар хугарсан хэдий ч хөдөлгөх боломжтой байгаа тохиолдолд 10. Нэг хөл хугарсан хэдий ч хөдөлгөх боломжтой байгаа тохиолдолд 11. Хоёр хөлийн бүх хуруу мэдээгүй болсон тохиолдолд 12. Гаднах төрхөд ил шарх, сорви байгаа тохиолдолд 13. Хоёр төмсөгөө алдсан тохиолдолд

Найм дугаар үе шат:	1. Нэг нүд сохорсон эсвэл нэг нүдний хараа 0.02-оос бага болсон тохиолдолд 2. Нурууны гэмтэл нь хөдлөх боломжтой байгаа тохиолдолд 3. Нэг гарын эрхий хуруу оруулаад хоёр хуруугаа алдсан тохиолдолд 4. Нэг гарны эрхий хуруу, долоовор хуруу мэдээгүй болсон тохиолдолд эсвэл эрхий хуруу, долоовор хуруу оруулаад гурваас дээш хуруу мэдээгүй болсон тохиолдолд 5. Нэг талын хөл нь 5 сантиметрээс дээш богино болсон тохиолдолд 6. Нэг талын гар нь гурван үе мөчний аль нэг нь мэдээгүй болсон тохиолдолд 7. Нэг талын хөлний гурван үе мөчний аль нэг нь мэдээгүй болсон тохиолдолд 8. Нэг талын гар гэмтэлтэй байгаа тохиолдолд / яс нь хугараад бүрэн эдгэрээгүй байгааг / 9. Нэг талын хөл гэмтэлтэй байгаа тохиолдолд / яс нь хугараад бүрэн эдгэрээгүй байгааг / 10. Нэг талын хөлний бүх хуруу мэдээгүй болсон тохиолдолд 11. Дэлүү эсвэл нэг талын бөөрөө алдсан тохиолдолд 12. Биеийн 40-өөс дээш хувь нь шарх, сорвитой болсон тохиолдолд
Ес дүгээр үе шат:	1. Хоёр нүдний хараа 0.6-аас бага болсон тохиолдолд 2. Нэг талын нүдний хараа 0.06-аас бага болсон тохиолдолд 3. Хоёр нүдний харааны талбай нарийсалт, холын хараа гажигтай болсон тохиолдолд 4. Хоёр нүдний зовхинд согог болон гэмтэл байгаа тохиолдолд 5. Хамар гэмтсэн, энэ гэмтэл нь эмчилгээ авах боломжтой байгаа тохиолдолд 6. Зажлах, ярих эрхтэн гэмтсэн хэдий ч захлах, ярих боломжтой байгаа тохиолдолд 7. Чихний хэнгэрэг гэмтсэн эсвэл өөр бусад шалтгаанаас болж нэг чихэний сонсголоо бүрэн алдсан тохиолдолд 8. Нэг гарын эрхий хуруугаа алдсан тохиолдолд, долоовор хуруу оруулаад хоёр хуруу алдсан тохиолдолд эсвэл эрхий хуруу ба долоовор хуруу бусад гурван хуруугаа алдсан тохиолдолд 9. Нэг гарын эрхий хурууг оруулаад хоёр хуруу мэдээгүй болсон тохиолдолд 10. Нэг талын хөлийн эрхий хуруу оруулаад хоёр хуруунаас дээш алдсан тохиолдолд 11. Нэг талын хөлийн бүх хуруу мэдрэлгүй болсон тохиолдолд 12. Бэлэг эрхтэнд гэмтэл учирсан тохиолдолд 13. Сэтгэцийн өвчинтэй болсон, ажил эрхлэх чадвартай боловч хязгаарлагдмал хөдөлмөр эрхлэх боломжтой тохиолдолд 14. Мэдрэлийн өвчинтэй болсон, ажил эрхлэх чадвартай боловч хязгаарлагдмал хөдөлмөр эрхлэх боломжтой тохиолдолд
Арав дугаар үе шат:	1. Нэг талын нүдний хараа 0.1-ээс бага болсон тоамоолдолд 2. Зажлах, ярих боломжтой байгаа тохиолдолд 3. 14-ээс дээш шүдэнд шүдний протез /хиймэл/ хийлгэсэн тохиолдолд 4. Чихний хэнгэрэгний ихэнх хэсэг гэмтсэн, өөр бусад шалтгаанаас болж чихтэй ойрхон ярихгүй бол чангаар ярих яриа сонсохгүй байгаа тохиолдолд 5. Нэг гарын эрхий хуруу мэдрэлгүй болсон тохиолдолд долоовор хуруунаас гадна хоёр хуруу алдсан тохиолдолд 6. Нэг гарын эрхий хуруу мэдрэлгүй болсон тохиолдолд долоовор хуруу оруулаад хоёр хуруу мэдрэлгүй болсон тохиолдолд эсвэл эрхий хуруу ба долоовор хуруунаас гадна гурван хуруу мэдрэлгүй болсон тохиолдолд 7. Нэг талын хөл 3 сантиметрээс дээш богино болсон тохиолдолд 8. Нэг талын хөлний эрхий хуруу эсвэл түүнээс гадна дөрвөн хөлийн хуруугаа алдсан тохиолдолд 9. Нэг талын гарын гурван үений аль нэг нь хэвийн бусад үе мөч нь гэмтэж хөдөлмөрийн чадвар алдсан тохиолдолд 10. Нэг талын хөлний гурван үений аль нэг нь хэвийн бусад үе мөч нь гэмтэж хөдөлмөрийн чадвар алдсан тохиолдолд

Арван нэгдүгээр үе шат:	1. Хоёр нүдний хараа хэвийн боловч хөдөлмөр эрхлэлтэнд нөлөөлөл байгаа тохиолдолд 2. Хоёр нүдний зовхинд тодоохой эмгэг байгаа бөгөөд хөдөлмөр эрхлэлтэнд нөлөөлөл байгаа тохиолдолд 3. Нэг талын нүдний зовхинд гэмтэл, шарх, гажиг байгаа тохиолдолд 4. Чихний хэнгэрэгний хагас нь гэмтсэн, шархалсан, гажигтай эсвэл бусад шалтгаанаас болж чихний сонсгол 40 сантиметрээс илүү зайд хэвийн яриаг сонсохгүй болсон тохиолдолд 5. Нурууны хэлбэрт гажиг байгаа тохиолдолд 6. Нэг талын гарны дунд хуруу эсвэл чигчий хуруугаа алдсан тохиолдолд 7. Нэг талын гарын хурууны долоовор хуруу мэдрэлгүй болсон эсвэл эрхий хуруу ба долоовор хуруунаас гадна бусад хоёр хуруу мэдрэлгүй болсон 8. Нэг талын хөлийн эрхий хурууг оруулаад хоёроос дээш хуруу мэдрэлгүй болсон тохиолдолд 9. Цээж, хэвлийн хөндийн эрхтнүүдээс шалтгаалаад хөдөлмөр эрхлэх боломжгүй болсон тохиолдолд
Арван хоёрдугаар үе шат:	1. Нэг нүдний хараа хэвийн боловч хөдөлмөр эрхлэлтэнд нөлөөлөл байгаа тохиолдолд 2. Нэг нүдний зовхинд эмгэг байгаа бөгөөд хөдөлмөр эрхлэлтэнд нөлөөлөл байгаа тохиолдолд 3. 7-ээс дээш шүдэнд шүдний протез /хиймэл/ хийлгэсэн тохиолдолд 4. Нэг талын чихний гадна дэлбээний ихэнх хэсэгт гэмтэл, шархтай болсон тохиолдолд 5. Эгэм, өвчүү, хавирга, дал мөр эсвэл аарцгийн ясанд мэдэгдэхүйц гажиг байгаа бол 6. Нэг талын гарны гурван үений аль нэг нь гэмтэлтэй хөдөлмөр эрхлэх боломжгүй байгаа тохиолдолд 7. Нэг талын хөлний гурван үе мөчний аль нэг нь гэмтэлтэй хөдөлмөр эрхлэх боломжгүй байгаа тохиолдолд 8. Гар болон хөлний урт ясны гажигтай байгаа тохиолдолд 9. Нэг гарын дунд хуруу эсвэл чигчий хуруу мэдрэлгүй болсон 10. Нэг талын хөлийн хоёр дахь хуруугаа алдсан тохиолдолд хоёр дахь хурууг оруулаад хоёр хөлийн хуруу алдсан тохиолдолд эсвэл дунд хуруунаас гурван хуруу алдсан тохиолдолд. 11. Нэг талын гарын эрхий болон түүнээс гадна дөрвөн хуруу мэдрэлгүй болсон тохиолдолд 12. Мэдрэлийн өвчний шинж тэмдэг хэсчилсэн байдлаар илэрсэн тохиолдолд 13. Гадаад төрх хэлбэрт гэмтэл, шарх, сорви байгаа тохиолдолд
Арван гуравдугаар үе шат:	1. Нэг талын нүдний хараа 0.6-аас бага байгаа тохиолдолд 2. Нэг талын нүдний хараа нарийссан, эсвэл хараа хэвийн бус байдалтай байгаа тохиолдолд 3. Хоёр нүдний зовхины зарим хэсэгт гэмтэл, шарх байгаа, сормууст гэмтэл, шарх байгаа тохиолдолд 4. Нэг гарын чигчий хуруугаа алдсан тохиолдолд 5. Нэг гарын эрхий хурууны үений хэсгийг алдсан тохиолдолд 6. Нэг гарын долоовор хурууны үений хэсгийг алдсан тохиолдолд
Арван дөрөвдүгээр үе шат:	1. Нэг талын нүдний зовхины зарим хэсэгт гэмтэл, шарх байгаа сормууст гэмтэл, шарх байгаа тохиолдолд 2. 3 ба түүнээс дээш шүдэнд шүдний протез /хиймэл/ хийлгэсэн тохиолдолд 3. Гарны ил гарсан хэсэгт гарын алганы хэмжээний шарх, сорви байгаа тохиолдолд 4. Хөлийн ил гарсан хэсэгт гарын алганы хэмжээний шарх, сорви байгаа тохиолдолд 5. Нэг гарын чигчий хуруу мэдээгүй болсон тохиолдолд 6. Нэг гарын эрхий хуруу ба долоовор хуруунаас гадна хуруун дундаас хурууны үений ясны нэг хэсгийг алдсан тохиолдолд 7. Нэг гарын эрхий хуруу ба долоовор хуруу бусад хурууны үений үе мөч нь нугалж, тэнийхээ больсон тохиолдолд 8. Нэг талын хөлийн дунд хурууныхаас нэг эсвэл хоёр хуруу мэдрэлгүй болсон тохиолдолд 9. Мэдрэлийн өвчний шинж тэмдэг хэсэгчилэн илэрч байгаа тохиолдолд

Харааны хэмжилтийг олон улсын харааны хэмжилтийн журмыг үндэслэн хэмжилт хийнэ. “Гарын хуруугаа алдсан” гэж эрхий хурууны үе, бусад хурууны нэгдүгээр үеэс дээш алдсаныг хэлнэ.

“Гарын хуруу мэдээгүй болсон” гэж хурууны үзүүрийн хоёр хэсгийн нэгээс дээш мэдрэлгүй болсон эсвэл нэгдүгээр үе / эрхий хурууны хувьд үе / мэдрэлгүй болсныг хэлнэ. “Хөлийн хуруугаа алдсан” гэж хөлийн бүх хуруу тасарч байхгүй болсоныг хэлнэ.

“Хөлийн хуруу мэдээгүй болсон” гэж эрхий хурууны хувьд хурууны үзүүрийн хоёр хэсгийн нэгээс дээш хэсэг мөн үүнээс гадна хөлийн хурууны үзүүр хэсгээс дээш алдсан

болон мэдрэлгүй болсон. Хурууны нэгдүгээр үед / эрхий хурууны хувьд үе / илт тодорхой гэмтэл учирсан мэдрэлгүй болсныг хэлнэ.

Дээрх журманд хамаарагдаагүй бусад биед учирсан гэмтлийг хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг харгалзан үзэж хамаарагдах зэрэглэлийн гэмтлээр тооцно.

Гэмт хэргийн улмаас биедээ гэмтэл авч хөдөлмөрийн чадвараа алдсан 2 хүн байгаа тохиолдолд дээрх журмыг баримтлан тус бүрийн гэмтлийг тогтоон нэгтгэн нэг зэрэглэлд хамааруулан шийдвэрлэнэ. / Хохирогчийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.5 /

“Гэмтэл учирсан” гэж гэмт хэргийн улмаас бие махбод, ур чадвартаа гэмтэл авсан. Гэмтэлээ / гэмт хэргийн улмаас бий болсон өвчин / эмчлүүлэхэд 2 сараас дээш хугацаа шаардлагатай гэмтэл авсаныг хэлнэ. Хохирогчийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.6 /

- Хүний амь нас болон бие махбодтой холбоотой гол чухал эд эрхтэнд гэмтэл учирсан тохиолдолд
- Биеийн зарим хэсэг тасарсан эсвэл хугарсан хэлбэр дүрс өөрчлөгдөж гажсан тохиолдолд
- 1 болон 2 дугаар зэрэглэлд хамаарах бие махбод, ур чадварт учирсан гэмтэл нь нэг долоо хоногоос дээш эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх шаардлагатай тохиолдолд
- Гэмт хэргийн улмаас хохирч хүнд хэлбэрийн сэтгэц мэдрэлийн өвчин эмгэгээр гурваас дээш өдөр эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх шаардлагатай тохиолдолд

Гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн олговрын төрөл болон мөнгөн дүн

Нөхөн олговрыг нас барсан хүний ар гэрт олгох нөхөн олговор, хөдөлмөрийн чадвараа алдсаны нөхөн олговор, гэмтэж бэртсэнд олгох нөхөн олговор гэж ангилна. / Хохирогчийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 /

Нас барсан хүний ар гэрт олгох нөхөн олговор авах эрх бүхий хүмүүс

Хохирогчыг нас барах үед дараах дарааллыг баримтлан хамгийн эхэнд байгаа ар гэрт нь нөхөн олговрыг олгоно. Дараалал адилхан ар гэрийн хүн хоёроос дээш байгаа тохиолдолд адилхан хуваан нөхөн олговрыг олгоно / Хохирогчийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2, 18 дугаар зүйлийн 1 /

1. Эхнэр, нөхөр / гэрлэлтийн гэрчилгээтэй байх / хохирогчыг нас барах үед хохирогчын орлогоор амьдарч байсан хохирогчын хүүхдүүд
2. Хохирогчыг нас барах үед хохирогчын орлогоор амьдарч байсан эцэг, эх
3. Хохирогчыг нас барах үед хохирогчын орлогоор амьдарч байсан ач, зээ
4. Хохирогчыг нас барах үед хохирогчын орлогоор амьдарч байсан өвөө, эмээ
5. Хохирогчыг нас барах үед хохирогчын орлогоор амьдарч байсан ах, эгч
6. Дээрхтэй хамааралгүй хохирогчын хүүхдүүд
7. Дээрхтэй хамааралгүй хохирогчын эцэг, эх
8. Дээрхтэй хамааралгүй хохирогчын ач, зээ
9. Дээрхтэй хамааралгүй хохирогчын өвөө, эмээ
10. Дээрхтэй хамааралгүй хохирогчын ах, эгч

Дараах тохиолдолд нас барсаны нөхөн төлбөрийг ар гэрт нь олгохгүй.

1. Хохирогч зохиудаар нас барсан / амиа хоролсон / тохиолдолд
2. Хохирогчыг нас барахын өмнө үхэх юм бол нас барсаны нөхөн олговор авч болох ар гэрийн хүн нь зориудаар үхүүлсэн үйлдэл хийсэн тохиолдолд
3. Хохирогчыг нас барсаны дараа нас барсаны нөхөн олговор авч болох ар гэрийн хүнтэй ижил дараалалд байгаа хүн зориудаар үхүүлсэн үйлдэл хийсэн тохиолдолд

Нас барсаны нөхөн олговор олгох мөнгөн дүн

Нас барсаны нөхөн олговор нь хохирогчийг нас барсан үед / бие махбодидоо авсан гэмтлийн улмаас нас барсан тохиолдлыг хэлнэ /сарын цалин, сарын бодит орлого эсвэл сарын дундаж цалин хөлсийг өөр бусад саруудтай үржүүлж тооцно.

Хүснэгт №2

Холбоо хамаарал	Сарын цалинг үржүүлэх сарын тоо
1. Эхнэр, нөхөр /гэрлэлтийн гэрчилгээтэй/ гэмт хэрэг үйлдэгдэх үед хохирогчийн орлогоор амьдарч байсан хүүхдүүд	40 сар × 6/6
2. Хохирогчийг нас барах үед хохирогчийн орлогоор амьдарч байсан эцэг, эх, ач, зээ, өвөө, эмээ болон ах, эгч	2 хүнээс дээш байгаа тохиолдолд 32 сар × 6/6 1 хүн байгаа тохиолдолд 32 сар × 5/6
3. 1 болон 2 дугаар ангилалд хамаарахгүй хохирогчийн хүүхдүүд болон эцэг, эх	24 сар × 3/6
4. 1 болон 2 дугаар ангилалд хамаарахгүй хохирогчийн ач, зээ, өвөө, эмээ болон ах, эгч	24 сар × 1/6
Хохирогчийн орлогоор амьдарч байсан хохирогчийн хүүхдүүд, ач, зээ, ах, эгч тус бүр 19 наснаас доош хүмүүс байх бөгөөд хохирогчийн орлогоор амьдарч байсан хохирогчийн эцэг, эх, өвөө, эмээ тус бүр 60 наснаас дээш байна. Тахир дутуу иргэн нийгмийн халамжийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан тахир дутуу иргэнд дээрх нас хязгаарлалт хамаарахгүй.	

Нас барсаны нөхөн олговрын мөнгөн дүн дундаж цалин хөлсний 48 сараас дээш хэтэрч болохгүй / Хохирогчийг хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйл /

Хөдөлмөрийн чадвараа алдсан болон гэмтсэний /өвчилсөн/ нөхөн олговор

Гэмт хэргийн улмаас хөдөлмөрийн чадвар алдсан болон гэмтсэн хохирогчид нөхөн олговор олгоно. /Хохирогчийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 3 /

Хөдөлмөрийн чадвар алдсаны нөхөн олговрын мөнгөн дүн нь хохирогчийн биед гэмтэл учирсан үед сарын цалин, сарын бодит орлого эсвэл сарын дундаж цалин хөлсийг өөр бусад саруудтай үржүүлж тооцно / Хохирогчийг хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 2 /

Хүснэгт №3

Зэрэглэл	Сарын цалин болон үржүүлэх сарын тоо	
1 зэрэглэл: 40 сар 2 зэрэглэл: 36 сар 3 зэрэглэл: 32 сар 4 зэрэглэл: 28 сар 5 зэрэглэл: 24 сар 6 зэрэглэл: 20 сар 7 зэрэглэл: 16 сар 8 зэрэглэл: 12 сар 9 зэрэглэл: 8 сар 10 зэрэглэл: 4 сар 11,12 зэрэглэл: 3 сар 13,14 зэрэглэл: 2 сар	1. Эхнэр, нөхөр / гэрлэлтийн гэрчилгээтэй / гэмт хэрэг үйлдэгдэх үед хохирогч болон эхнэр, нөхрийн орлогоор амьдарч байсан хүүхдүүд байгаа тохиолдолд	Зэрэглэл өөр сарын тоог × 6/6
	2. 1 дүгээр зэрэглэлийн цусан төрөл байш ч гэсэн гэмт хэрэг үйлдэгдэх үед хохирогчийн мөн эхнэр, нөхрийн орлогоор амьдарч байсан эцэг, эх, ач, зээ, өвөө, эмээ болон ах, эгч	Зэрэглэл өөр сарын тоог × 3/6
	3. 1 болон 2-оос бусад тохиолдолд	Зэрэглэл өөр сарын тоог × 3/6
Хохирогчийн орлогоор амьдарч байсан хохирогчийн хүүхдүүд, ач, зээ, ах, эгч тус бүр 19 наснаас доош хүмүүс байх бөгөөд хохирогчийн орлогоор амьдарч байсан хохирогчийн эцэг, эх, өвөө, эмээ тус бүр 60 наснаас дээш байна. Тахир дутуу иргэн нийгмийн халамжийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан тахир дутуу		

иргэнд дээрх нас хязгаарлалт хамаарахгүй.

Гэмт хэргийн улмаас гэмтсэний /өвчилсөн/ нөхөн олговор

Гэмт хэргийн улмаас биедээ гэмтэл авч хохирсон үед сарын цалин, сарын бодит орлого эсвэл сарын дундаж цалин хөлсийг өөр бусад саруудтай үржүүлж тооцно. Гэмтсэний нөхөн олговрын мөнгөн дүн дундаж цалин хөлсний 40 сараас дээш хэтэрч болохгүй / Хохирогчийг хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 2 /

Хүснэгт №4

Ангилал	Сарын цалин болон үржүүлэх сарын тоо
1. Эхнэр, нөхөр / гэрлэлтийн гэрчилгээтэй / гэмт хэрэг үйлдэгдэх үед хохирогч болон эхнэр, нөхрийн орлогоор амьдарч байсан хүүхдүүд байгаа тохиолдолд	Гэмтлийн зэрэглэл болон гэмтлийг эмчилхэд шаардлагатайг хэвтэж эмчлүүлж байгаа эмнэлгийн эмчийн тодорхойлолтоор хүлээн зөвшөөрсөн бол сарын тоог ✕ 6/6
2. 1 дүгээр зэрэглэлийн цусан төрөл байш ч гэсэн гэмт хэрэг үйлдэгдэх үед хохирогчийн мөн эхнэр, нөхрийн орлогоор амьдарч байсан эцэг, эх, ач, зээ, өвөө, эмээ болон ах, эгч	сарын тоог ✕ 5/6
3. 1 болон 2-оос бусад тохиолдолд	сарын тоог ✕ 3/6
Хохирогчийн орлогоор амьдарч байсан хохирогчийн хүүхдүүд, ач, зээ, ах, эгч тус бүр 19 наснаас доош хүмүүс байх бөгөөд хохирогчийн орлогоор амьдарч байсан хохирогчийн эцэг, эх, өвөө, эмээ тус бүр 60 наснаас дээш байна. Тахир дутуу иргэн нийгмийн халамжийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан тахир дутуу иргэнд дээрх нас хязгаарлалт хамаарахгүй. Эмнэлгийн тодорхойлолт нь тэмдэглэл үйлдэж эмчилгээний хугацаа, он, сар, өдөр, 30 хоногийг 1 сараар тооцож сарын тоог тооцно. Эмчилгээний хугацааг 7 хоногоор байгаа тохиолдолд нэг өдөрлүү шилжүүлсэний дараа 30 өдрийг 1 сард шилжүүлж сарын тоогоор тооцно.	

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ОНЦЛОГ
CHARACTERISTICS OF THE LEGAL STATUS OF A POLICE OFFICER

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Гүйцэтгэх
ажлын тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D),
цагдаагийн хурандаа Ү.Хосбаяр
Head of the police intelligence Department of
Police School, doctor (Ph.D), police colonel U.
Hosbayar*

Товч утга: Монгол улсад өрнөж буй эрх зүйн шинэтгэлийн хүрээнд ЭХХШТХууль, Зөрчлийн тухай, Цагдаагийн албаны тухай, зэрэг олон хуулиудыг УИХ-аас шинэчлэн найруулж баталснаар төрийн тусгай албаны алба хаагчийн хувьд хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэх албан тушаалын эрх зүйн байдал тодорхойлогдож байгаа хэдий ч нөгөө талаас цагдаагийн алба хаагч нь хүн, бие хүн, иргэнийхээ хувьд эрх зүйн байдлыг тодорхойлогч гол элемент болох эрхийн тодорхой хязгаарлалтад ордог гэх ойлголтыг тайлбарлах, мөн цагдаагийн алба хаагч нь бусдаас давуу эрх эдэлдэггүй энэ “давуу эрх” нь цагдаагийн алба хаагчийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх “баталгаа”-г төрөөс хангаж байгаа эрх зүйн байдлыг тодорхойлогч нэг элементийн илрэн гарч байгаа хэлбэр юм гэсэн судлаачийн санааг илэрхийлэхийг зорилоо.

Summary: In the framework of judicial innovation in Mongolia, many laws, such as law enforcement, resistance, police departments, and so on, have been reaffirmed by the Parliament of Mongolia, although the legal status of a special government official is defined as a legal obligation, on the other hand, a police officer is a person, it is intended to explain the concept that judicial status as a person and citizen falls under certain restrictions on rights, and to express the researcher's idea that this "privilege" that police officers do not exercise superiority over others is a form of judicial clarification that provides a definite element of judicial status that provides a "guarantee" to fulfill their obligations under the law of a police officer.

Түлхүүр үг: Статус, эрх зүйн байдал, бие хүн, эрх, үүрэг, хариуцлага, баталгаа, албан тушаал, цагдаагийн алба хаагч,

Keywords: status, legal status, individual, rights, duties, responsibilities, guarantee, position, police officer,

Аливаа шинжлэх ухаан болон салбар шинжлэх ухааны судлах зүйл нь уг шинжлэх ухааны байгаль болон нийгэмд орших зүй тогтлын шинж чанараар тодорхойлогдоно. Эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах нийгмийн харилцааны зүй тогтлыг эрх зүйн шинжлэх ухаан судлах ба нийгмийн харилцаа гэдэг нь хүмүүс хоорондын нийгмийн холбоо юм. Энэ холбооны нэг хэсэг нь тодорхой этгээдүүдийн хүсэл зоригийн дагуу бий болж байхад нөгөө хэсэг нь амьдралын бодит шаардлагаар аяндаа бий болж байдаг. Ийм учраас нийгмийн харилцаа нь хүний чөлөөт хөгжил, мөн тодорхой хэмжээний хязгаарлалтыг зайлшгүй шаарддаг.⁵¹ Хүний гол шинж нь байгаль дэлхийн аясаар дасан зохицох, түүнийг өөрийн хэрэгцээнд тааруулах чадвар юм. Хүн юмсыг өөрийн хэрэгцээ, сонирхолд зохицуулан байгалийн, түүнчлэн нийгмийн хүрээ үүсгэдэг байна. Энэ утгаараа хүн гэдэг ойлголт нь хоёрдмол утгыг илэрхийлэх ба биологийн болон нийгмийн шинж чанараараа эдгээр утгууд ялгагдана.

⁵¹ Нямсүрэн, Ч. “Эрх зүйн ерөнхий онол”. Уб., 2017. 271 дэх тал

Хүний асуудал, түүний статусын тухай ойлголт нь хууль зүйн шинжлэх ухааны судалгааны тэргүүлэх чиглэл юм. Хүний үүсэл, мөн чанарыг нийгэмчилж тайлбарласан түүхэн анхны томоохон төлөөлөгчдийн нэг нь Аристотель бөгөөд, тэрээр хүнийг “полис /хот улс/-ын амьтан гэж томъёолжээ.⁵² Полис нь бүх хүмүүсийн сайн сайхныг хангахад хүрэлцээтэй, харьцангуй том хэмжээтэй байхын зэрэгцээ дотоод үйл ажиллагаагаа хамгийн сайн сайхнаар удирдан зохион байгуулж болохуйц жижиг бүтэцтэй, хамрах хүрээ, нутаг дэвсгэр цомхон байна гэж тодорхойлсон байна.⁵³ Аристотелийн энэхүү тодорхойлолтод суурилан И.Кант өөрийн Үндсэн хуульт төрийн онолоо гаргаж ирсэн ба түүний үзсэнээр төр гэдэг нь хуулийн хүрээнд нэгдмэл үйл ажиллагаа явуулж буй хүмүүсийн нэгдэл юм. Төрийн хууль тогтоох үйл ажиллагаанд оролцдог хүмүүсийг иргэн гэж үзнэ⁵⁴ гэжээ. Бие хүн бол нийгмийн янз бүрийн дүрэм, хэм хэмжээнд захирагдаж, сонголт хийн түүнийхээ төлөө хариуцлага хүлээх чадвартай амьтан мөн гэдэг И.Кантын үзлийг америкийн философич Уилфрид Селларс өөрийн бүтээлдээ арга зүйн хувьд баримталжээ.⁵⁵

Иймээс “статус” гэх нэр томъёо, түүний илэрхийлэх утгын талаар тодруулах хэрэгтэй гэж бид үзлээ. ОХУ-ын эрдэмтэд болох Ф.А.Брокгауза, И.А.Ефрона нар 1907 онд гаргасан хууль зүйн бага тайлбар тольдоо латин хэлний “status” гэдэг үгийг “хэргийн байдал, байр байдал”⁵⁶ гэдэг талаас нь анх удаа тайлбарлаж⁵⁷ байжээ. Мөн ОХУ-н эрдэмтэн, профессор А.В.Малько “иргэн, хуулийн этгээдийн эрх, үүргийн нэгдлийг хэлнэ”⁵⁸ гэж товчоор тодорхойлсон бол ОХУ-н эрдэмтэн Тихомиров М.Ю. статус (төлөв, байр суурь) нь шууд утгаараа аливаа шатлал, бүтэц, тогтолцоонд эрхлэх албан тушаал түүний зэрэглэл, хүний төрийн байгууллага, олон улсын байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх байдал, төрийн олон улсын байгууллагад эзлэх эрх зүйн байр суурийг тодорхойлсон эрх үүргийн цогц юм⁵⁹ гэж үзжээ. “Статус “ гэх нэр томъёог Монгол хэлнээ “тухайн байдал”⁶⁰ гэж үг зүйн талаас нь нэрт эрдэмтэн Ц.Дамдинсүрэн хөрвүүлсэн бөгөөд, академич С.Нарангэрэл эрх зүйн хэм хэмжээгээр тогтоосон субъектийн эрх ба үүргийн нэгдэл хэмээн, профессор. Ч.Нямсүрэн “Хүний эрх зүйн байдал нь үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор хуульчлан баталгаажуулсан бие хүний эрх, үүргийн тогтолцоо мөн”⁶¹ гэж тус тус үзсэн байна. Дээрхээс үзэхэд статус буюу эрх зүйн байдал гэдэг ойлголт нь эрх ба үүрэг гэсэн ухагдахуунуудтай зайлшгүй холбогдох нь тодорхой байна.

Үүнээс гадна “статус” гэх ойлголтод баталгаа, хариуцлага гэсэн элементүүд багтах⁶² ба бид нэн түрүүнд эрхийн тухай элементийг авч үзэх шаардлагатай болно. Хүний эрхийн мөн чанар, ойлголтын талаар хоёр үндсэн хандлага байдаг байна. Эхний хандлагаар хүний эрх нь түүнийг төрөөс хүлээн зөвшөөрөх эсэхээс үл хамааран оршиж байгаа, хүний жам ёсны чанар гэж үзэх, хоёрдох хандлага нь хүний эрх нь төрөөс үүсмэл бөгөөд төр нь өөрийн үзэмжээрээ хүний эрхийн хүрээг тодорхойлж, түүнд буюу хүнд тухайн эрхийг нь өгч байдаг гэсэн үзэл юм. Ийм учраас хүний эрх түүний гарал, нийгмийн үндсийн тухай асуудал нь гүн ухааны, улс төрийн, эрх зүйн, шашны сэтгэлгээний мөнхийн асуудлын нэг байсаар иржээ.

Гэхдээ эрх, эрх чөлөө нь нэгдмэл ойлголт биш бөгөөд эрх нь бие хүн, иргэний материаллаг болон оюун санааны боломжийг нийгмийн төрөл бүрийн салбарт ашиглах тухай

⁵² Гомбосүрэн, Ц. “Философи” сурах бичиг. Уб., 2008. 270 дахь тал

⁵³ Юндэндорж, А. Атар, Ю. Жам ёсны хөгжлийн талаарх сургаал номлол. Уб., 2015. 111 дэх тал

⁵⁴ Мөн тэнд 354 дэх тал

⁵⁵ Гомбосүрэн, Ц. “Философи” сурах бичиг. Уб., 2008. 271 дэх тал

⁵⁶ [Энциклопедический словарь Брокгауза и Ефрона](#) : в 86 т. (82 т. и 4 доп.). СПб., 1890—1907.

⁵⁷ [Брокгауз-Ефрон //Большая советская энциклопедия](#) : в 66 т. (65 т. и 1 доп.)

гл. ред. [О. Ю. Шмидт](#). М. : [Советская энциклопедия](#), 1926—1947.

⁵⁸ Малько, А.В. Юридический энциклопедический словарь. М., 2016. 741 дэх тал

⁴ Равильевна, А.Е. “Правовой статус сотрудников органов внутренних дел” М., 2006. 13 дахь тал

⁶⁰ Дамдинсүрэн, Ц. Орос монгол толь. Уб., 1983. 690 дэх тал

⁶¹ Нямсүрэн, Ч. “Эрх зүйн ерөнхий онол”. Уб., 2017. 370 дахь тал

⁶² Мөн тэнд 372 дах тал

хуулиар тогтоосон баталгаа байдаг бол эрх чөлөө нь нийгмийн төрөл бүрийн салбарт бие хүн, иргэнээс өөрийн чадвараа хэрэгжүүлэх хуулиар тогтоосон боломж гэж үзэж байна.

Нөгөө талаас эрхгүй үүрэг, үүрэггүй эрх байхгүй гэсэн эрх зүйн зарчим нь эрх зүйн харилцааны зүй тогтлыг тодорхойлдог. Эрх нь хүмүүсээс сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх зан үйлийн боломж хэлбэрээр илэрдэг бол үүрэг нь хүмүүсээс зайлшгүй хийж гүйцэтгүүлэхээр хуульчлан тогтоосон зан үйл байна⁶³. Эрх зүйн зан үйл гэдэг нь эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж, хууль зүйн үр дагавар дагуулж, нийгмийн ач холбогдлоороо ямар нэгэн түвшинд ухамсарлагдаж байгаа хувь хүн болон хамт олны зан үйл юм⁶⁴. Хүмүүсийн зан үйл нь илэрхийлэгдэх хэлбэр, сэдэлт зорилго, үр дагаврын хувьд маш олон янз байдаг. Хууль цаазын шинжлэх ухаан болон практик нь эрх зүйн нөлөөллийн хүрээнд байгаа зан үйл буюу эрх зүйгээр зохицуулагдаж байгаа зан үйлд гол анхаарлаа хандуулдаг байна. Хүмүүс нь ухамсар, хүсэл зоригийнхоо дагуу ямар нэгэн үйл ажиллагаа явуулахын хамт, өөрийн зан үйлд хяналт тавьж байдаг бөгөөд зан үйлийн обьектив ба субъектив байдлууд нь эрх зүйн хэм хэмжээнд тусгагдсан байхаас гадна төрийн хяналт дор оршиж хууль зүйн үр дагавар үүсгэнэ.

“Статус” гэх ойлголтот хамаарах дараагийн асуудал нь хүний эрхийн баталгааны тухай юм. Энэхүү асуудал нь хууль тогтоомжид хуульчлах төдийхнөөр хангагдан хамгаалагддаг ойлголт биш учир улс гүрнүүд түүнийг хангах механизмыг бүрдүүлэхэд онцгой анхаарал тавьдаг байна. Хүний эрх, эрх чөлөөг хэр зэрэг хангаж байна вэ гэдгээр нь тухайн улсын олон улсын тавцанд эзлэх байр суурь, нийгмийн хөгжлийн түвшин зэргийг тодорхойлох боломжтой юм. Төр хүний эрхийг хангах үндсэн механизм болохын хувьд хүний эрх, эрх чөлөөг хангах баталгаа буюу бодит нөхцөл боломжийг хангах асуудлыг зохион байгуулна. Хүний эрхийн баталгаа гэдэг нь хуульчлан тодорхойлсон эрхийг үнэн бодитой хэрэгжүүлэх нөхцөл боломжийг хангахад чиглэгдсэн нийгэм, эдийн засаг, улс төр, үзэл суртал, хууль зүйн цогц асуудлыг хамтатгасан нийгмийн шинжтэй асуудал юм.

Хүний эрхийн баталгааг хангах нь аль нэг улсын дангаараа өөрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх бололцоотой мэт боловч орчин үед дэлхий нийтийг хамарсан /тухайлбал дайн, халдварт өвчин гэх мэт/ үйл явдлын үед энэ нь аливаа нэг төрт улсын хүрээнээс хальж олон улсын чанартай асуудал болсоор байна.

Хариуцлагын тухай асуудал нь “статус” гэх ойлголтыг бүрдүүлэгч дөрөв дэх элемент бөгөөд эрх зүйн энэ үзэгдлийн олон талт нарийн төвөгтэй шинж нь эрх зүйн онол болон хууль зүйн шинжлэх ухааны хандлагаар тодорхойлогдоно. Хууль зүйн хариуцлага нь эрх зүйн мөн чанар, түүний чиг үүрэг, зарчим, нийгмийн зорилгыг илүү тодорхой илэрхийлэх бөгөөд хууль зүйн хариуцлага гэсэн ойлголтын олон талт, нарийн төвөгтэй байдал нь эрх зүйн зөрчил, эрх зүйн хэм хэмжээ, төрийн албадлага, эрх зүйн харилцаа, эрх зүйн хэрэглээ, эрх зүйн зан үйлтэй илүү нягт холбоотойгоор тайлбарлагдана.

Хууль зүйн онол, практикт хууль зүйн хариуцлага гэх ойлголтыг эрх зүйн зөрчилтэй холбоотой агуулгаар нь илүүтэй авч үздэг байна. Тухайлбал академич Ж.Амарсанаа “Эрх зүйн зөрчил гаргасан субъектэд хүлээлгэхээр эрх зүйн хэм хэмжээнд заан тогтоосон үүрэг”⁶⁵ гэж үзсэн бол академич С.Нарангэрэл “ Эрх зүйн хэм хэмжээнд заасан таагүй, сөрөг үр дагавар буй болгосон эрх зүйн субъектийн үүрэг, нийгэмшлийн хариуцлагын төрөл”⁶⁶ гэж тус тус тодорхойлсон байна. Хууль зүйн хариуцлага нь хариуцлагыг зөвхөн эрх зүй зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйд хүлээлгэх, хариуцлагыг зөвхөн гэм буруутай эрх зүйн зөрчил гаргасан тохиолдолд хүлээлгэх, хариуцлага хуульд нийцсэн байх, хариуцлагыг шударга оногдуулах, хариуцлага зүй зохистой байх зарчмууд дээр үндэслэх бөгөөд эрх зүйн хэм хэмжээний аль

⁶³ Нармандах, Б. “Үндсэн хуулийн эрх зүй” сурах бичиг. Уб., 2017. 125 дахь тал

⁶⁴ Нямсүрэн, Ч. “Эрх зүйн ерөнхий онол”. Уб., 2017. 337 дахь тал

⁶⁵ Амарсанаа, Ж. нар “Хууль зүйн тайлбар толь”. Уб., 2003. 318 дахь тал

⁶⁶ Нарангэрэл, С. Эрх зүйн эх толь бичиг. Уб., 2007. 556 дахь тал

салбарт хамаарч байгаагаас шалтгаалан хууль зүйн хариуцлагыг эрүүгийн хариуцлага, иргэний эрх зүйн хариуцлага, захиргааны хариуцлага, сахилгын хариуцлага гэж ангилдаг байна. Мөн үүнээс гадна хууль зүйн хариуцлагыг негатив буюу сөргүү, позитив буюу эергүү хариуцлага гэсэн хоёр хэлбэрт хуваан үзэх хандлага байдаг. Эрх зүйн негатив буюу сөргүү хариуцлага нь санкцийн хэрэгжилт, төрийн албадлагын арга хэмжээ, ял шийтгэл, эрх зүйн зөрчилд нийгмээс үзүүлэх хариу үйлдэл, эрх зүйн зөрчлөөс урган гарсан хуулийн дагуух үүрэг, өөрийн зан үйлийн төлөө хүлээж буй үүрэг, албадлагын нөлөөллийн арга хэмжээг хүлээх чадвар, нийгэмд аюултай үзэгдэлд өгөх үнэлэмж болон түүнийг үйлдсэн этгээдийг буруутгах хэлбэр буюу санкц дээр суурилсан хариуцлагын хэлбэр байдаг бол позитив хариуцлага нь үүргийн ухамсар, үүргийн мэдрэмж, хууль зүйн дагуу үйл ажиллагаа явуулах үүрэг болон тухайн үүргийн хэрэгжилт буюу ёс зүй, ухамсар дээр суурилсан хариуцлагын хэлбэрийн тухай хандлага юм.

Нийгмийн харилцаанд бие даан оролцох чадвар, чадамж бүхий хүнийг бие хүн гэж ойлгоно.⁶⁷ Эрх зүйн чадвар гэдэгт эрх эдэлж, үүрэг хүлээх ерөнхий чадварыг ойлгох ба хүн нь нийгмийн олон төрлийн харилцаанд оролцохдоо тухайн харилцааны шинж байдал, хүний өөрийн нийгэм-биологийн онцлогоос хамаарч өөр өөр чадварыг илэрхийлж байдаг. Иймээс хүн бүр тодруулбал сэтгэцийн өвчтэй хүн, хөхүүл хүүхэд зэрэг нь хуулийн дагуу ямар нэгэн үйлдэл хийх шаардлагагүйгээр эрх зүйн чадвартай байдаг байна. Бие хүн гэдэг ойлголт нь хүний чадварын илрэлийн дээд хэлбэр юм. Энэ ойлголт нь нийгмийн шинжтэй бөгөөд бие хүн төрдөггүй, бие хүн бий болдог тухай асуудал юм. Өөрөөр хэлбэл хүн байгалиас төрж, өсөж томрох тусам нийгмийн амьтан, бие хүн болж төлөвшдөг гэж үздэг байна.

Харин эрх зүйн чадамжийн тухай ойлголт нь эрх зүйн харилцаанд идэвхтэй оролцохын тулд өөрийн үйлдлээр эрх олж авах, үүрэг бий болгох үүнээсээ үүсэх эрх зүйн үр дагаврыг биечлэн хариуцах онцгой чадварыг илэрхийлдэг байна. Эрхийн чадвар нь тухайн хүн эрх, үүрэгтэй байх байх боломж байдаг бол эрхийн чадамж нь уг боломжийг ашиглан өөрөө биеэрээ эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгодгоороо ялгаатай юм.⁶⁸

Бие хүн эрх зүйн харилцаанд хуулиар олгогдсон эрхээ эдлэх, хүлээсэн үүргээ биелүүлэх замаар оролцох бөгөөд эрх зүйн харилцаа гэх ойлголтыг зарим эрдэмтэн судлаач нар⁶⁹ тодорхой субъектүүдийн хооронд тэдгээрийн эдлэх боломж болон гүйцэтгэх зан төлөвөөр тодорхойлогдсон эрх үүргийн харилцаа юм гэж тодорхойлсон бол профессор. Ч.Нямсүрэн эрх зүйн харилцаа нь эрх зүйн хэм хэмжээ болон амьдралын тодорхой нөхцөл байдлын улмаас харилцан субьектив эрх, үүрэг бүхий эрх зүйн тодорхой субьектүүдийн хооронд үүссэн нийгмийн харилцааны хууль зүйн хэлбэр мөн⁷⁰ гэж тодорхойлжээ. Төр ба бие хүний хооронд үүсэж буй олон талт харилцаа нь тухайн улсын эрх зүйн төрөл бүрийн салбаруудаар зохицуулагдах боловч Үндсэн хууль гол эх сурвалж болж иргэдийн нийгэм, улс төр, эдийн засаг, хувийн эрх, эрх чөлөөний үндсийг хуульчилсан байдаг. Тухайлбал Монгол улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлэг, Энэтхэг улсын Үндсэн хуулийн 3 дугаар хэсэг, БНХАУ-н Үндсэн хуулийн 2 дугаар бүлэг, Италийн Үндсэн хуулийн 1 дүгээр бүлэгт тус тус хүний эрх, эрх чөлөө, эрхийн байдлын талаар заасан байна.⁷¹

Дээрхээс үзвэл бие хүн нь эрх зүйн харилцааны нэг субьект мөн бөгөөд субьект хэмээх ойлголтыг философийн үүднээс авч үзвэл хүн өөрийн оршин буй гадаад ертөнцтэй харилцах харилцаагаа ухамсарлах үйл явцаас эхлэн субьект болж төлөвшдөг. Харин хууль зүйн шинжлэх ухааны талаасаа хуульд заасан эрх, эрх чөлөө, үүргийг хэрэгжүүлэгч этгээдийн хувьд бие хүн нь хуулийн субьект гэж үздэг. Түүний эрх зүйн байдал нь тухайн

⁶⁷ Нармандах, Б. “Үндсэн хуулийн эрх зүй” сурах бичиг. Уб., 2017. 108 дахь тал

⁶⁸ Мөнхжаргал, Т. “Монгол улсын иргэний эрх зүй”. Уб., 2014. 71 дэх тал

⁶⁹ Амарсанаа, Ж. нар “Хууль зүйн тайлбар толь”. Уб., 2003. 376 дахь тал

⁷⁰ Нямсүрэн, Ч. “Эрх зүйн ерөнхий онол”. Уб., 2017. 272 дахь тал

⁷¹ Нармандах, Б. “Үндсэн хуулийн эрх зүй” сурах бичиг. Уб., 2017. 108 дахь тал

хүний нийгэмд эзлэх байр суурийг тодорхойлдог. Өөрөөр хэлбэл бие хүний эрх зүйн байдал гэдэг нь хүн өөрийн хэрэгцээ, ашиг сонирхлоо хангах үүднээс явуулж буй нийгэм, улс төр, хөдөлмөрийн үйл ажиллагаа болон төр, бие хүний хоорондын харилцааг илэрхийлэх ойлголт юм. Бие хүний эрх зүйн байдал нь хүний нийгмийн байдлын эрх зүйн илэрхийлэл байдаг. Хуулийн хэм хэмжээ нь нийгмийн бодит байдлыг тогтоож, улмаар түүнийг хууль ёсны болгож хувиргадаг бол эрх зүйн байдлын үндэс, үндсэн агуулга нь бие хүний хууль тогтоомжид заасан, төрөөс баталгаажуулсан эрх, эрх чөлөө, үүрэг юм⁷² гэж тодорхойлсон байна. Энэ утгаар нь авч үзвэл эрх зүйн харилцааны субъект болох бие хүн нь тухайн харилцаанд оролцохдоо ямар хэмжээний эрх эдэлж, үүрэг хүлээж байгаагаас хамааралтайгаар бие хүний эрх зүйн байдал тодорхойлогдоно гэж судлаачийн зүгээс дүгнэж байна.

Хүн аль нэг улсын харьяат иргэн болсноор бие хүний эрх зүйн байдлыг тодорхойлж тогтоох үндэслэл бий болж, тухайн хүнийг төрийн хамгаалалтад авах, эрх, эрх чөлөөг нь хангах, хамгаалах, хэрэгжих баталгааг бий болгох, харьяат бус хүмүүсийн эрх зүйн байдлыг онцлогтой тогтоох зэрэг хууль зүйн үр дагаврыг үүсгэдгээрээ уг элементийн мөн чанар оршино. Төр түүний харьяат иргэн хоёрын хооронд иргэний хүсэл зоригоос хамааралтайгаар болон хууль тогтоомжид заасан үндэслэлээр харьяатаас гарах асуудлыг шийдвэрлэх хүртэл бие биеэ хүлээн зөвшөөрсөн харьцангуй тогтвортой эрх зүйн харилцаа үүснэ. Төр иргэнийг ивээлдээ авч, эрх, эрх чөлөөг нь хамгаалж хангах, баталгааг нь тогтоох үүрэг хүлээнэ. Үүний зэрэгцээ иргэнд хууль тогтоомжоор тодорхой үүрэг хүлээлгэж, биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг тогтоодог. Иргэн нь төрийн засаглалыг хүлээн зөвшөөрч, төрийн өмнө эрх эдэлж, үүрэг хүлээх ба төр нь дотоодод мөн гадаадад иргэнийхээ эрх ашгийг хамгаалах үр дагаврыг үүсгэдэг байна.

Дээрхээс үзэхэд эрх зүйн онолын хувьд бие хүн, түүний “эрх зүйн байдал” буюу “статус” гэх ойлголт нь анх МЭӨ 342 оны үеэс анх бүрэлдэж хүний эрхийн тухай ойлголттой салшгүй холбоотойгоор нийгмийн хөгжлийн олон үе шатыг дамжин хөгжиж иржээ. Түүний мөн чанар нь бие хүний эрх, үүрэг, баталгаа, хариуцлага гэсэн элементүүдийн харилцан хамаарлаар тодорхойлогдохын зэрэгцээ дээрх элементүүдийн бие хүнд хэрхэн нөлөөлөх байдлаас шалтгаалан хүний нийтлэг буюу Үндсэн хуулийн статус, тодорхой хэсэг бүлэг хүмүүсийн тусгай статус, ганцаарчилсан буюу хувийн шинжтэй статус, гадаадын иргэн болон харьяалалгүй хүмүүсийн статус гэсэн төрлүүдэд хуваан авч үздэг байна.

Эрх зүйн аль ч салбар нь нийгмийнхээ шинж чанарыг хамгаалж, чухам ямар харилцааг зохицуулж байгаагаасаа хамаарч тэдгээрийн судлах зүйлүүд өөр хоорондоо ялгаатай байдаг.

Энэ нь эрх зүйн харилцаанд оролцогч этгээд нь иргэний харьяалал, эрхийн чадвар, чадамж буюу Үндсэн хуулийн статустай байх нь тусгай статустай болоход хангалтгүй гэж ихэвчлэн хүлээн зөвшөөрдөгтэй холбоотой.⁷³ Эрх зүйн тусгай статусыг эзэмшигч нь зөвхөн Үндсэн хуулийн буюу нийтлэг статустай байхаас гадна тодорхой шинж чанар, чадвартай нийгмийн харилцааны этгээд байж болно.

Үүнд: нас, боловсрол, эрүүл мэндийн байдал, ажлын туршлага зэрэг ордог.

Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлын ойлголт нь юуны түрүүнд тухайн улсын иргэн, төрийн алба хаагч, албан тушаалтан, эрх мэдлийн төлөөлөгч гэсэн хэд хэдэн төрлийн эрх зүйн байдлын шинж тэмдгийг хослуулсан цогц асуудал гэдгийг тодотгох нь зүйтэй⁷⁴.

Иймээс а) Монгол улсын иргэн биш;

б) 18 насанд хүрээгүй;

⁷² Черниченко, С.В. Личность и международное право. М., 1974. 16 дахь тал

⁷³ Равильевна, А.Е. “Правовой статус сотрудников органов внутренних дел” М., 2006. 112 дахь тал

⁷⁴ Мөн тэнд. 114 дэх тал

в) Эрүүгийн ял шийтгэлтэй гэсэн гурван нөхцөлийн аль нэг нь байвал тухайн хүнийг цагдаагийн албанд авахгүй буюу хуулиараа томилогдох боломжгүй болно.

Үндсэн хуулийн статустай байх зайлшгүй шаардлагатай урьдчилсан нөхцөл нь иргэншил юм. Иргэний харьяаллын институтци нь тухайн хүний тодорхой улстай эрх зүйн тогтвортой харилцаанд холбогдох эрх зүйн хэм хэмжээг тогтоосноор илэрхийлэгддэг. Өөрөөр хэлбэл иргэн гэдэг нь тухайн хүнийг субьектив эрх, хууль ёсны үүрэг, хариуцлага хүлээгч гэж төр эрх зүйн хүрээнд хүлээн зөвшөөрсний үндсэн дээр нийгэм дэх улс төрийн эрх мэдэл, хууль тогтоомжийн хамааралд авсан хүн юм.⁷⁵ Төрийн бүрэн эрхт байдал нь түүнд шууд хамааралтай ба тэрээр төрийн хэргийг удирдахад оролцож, хамгаалалтыг нь авах боломжтой байдаг. Зөвхөн тухайн улсын иргэд Үндсэн хуулийн статустай байх ба энэ нь цагдаагийн албанд орох урьдчилсан нөхцөл юм. Энэ тухай Цагдаагийн албаны тухай хуульд “Цагдаагийн албан тушаалд анх томилохдоо гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байгаагүй, нас, эрүүл мэнд, бие бялдар, боловсрол, мэргэжил, мэргэшил, ёс зүйн болон бусад тусгайлсан шалгуур үзүүлэлтийг хангасан 18 насанд хүрсэн Монгол Улсын **иргэнийг** хүсэлтийг нь үндэслэн шалгуур хангасан байдлаар нь эрэмбэлэн шалгаруулж томилно”⁷⁶ гэж заасан нь энэ нөхцөлийг шаардаж байгаа хэлбэр юм.

Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал нь тодорхой хэсэг бүлэг хүмүүсийн тусгай статус мөн. Тусгай статус нь тусгай эрх, үүрэгтэйгээр тодорхойлогдох ба эрх зүйн тусгай статус нь нийгмийн ангилал, хүйс, нас, гэр бүл, албан тушаалын болон ижил төстэй байдлын үндсэн дээр тодорхойлогдсон хүмүүсийн эрх үүргийг багтаадаг гэж судлаач Н.В.Витрук үзжээ⁷⁷. Тэр ч утгаараа цагдаагийн албаны тухай хуулийн наймдугаар бүлэг бүхэлдээ цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, түүнтэй холбоотой үүсэх эрх зүйн харилцааг зохицуулахаар тусгагдсан байна.

Цагдаагийн алба хаагчид тавигдах шалгуурын нэмэлт нөхцөл нь эрүүл мэндийн байдал, бие бялдрын, шаардлагатай боловсрол, мэргэжил, сэтгэл зүйн болон ёс зүйн шаардлагын үзүүлэлтүүдийг хангасан байх явдал юм. Ийм учраас эхлээд тодорхой бие хүнийг албан тушаал хашиж, тусгай статустай болгох асуудлыг шийдвэрлэх үүднээс Цагдаагийн албаны тухай хуульд шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон бөгөөд тухайн шалгуур үзүүлэлтийг хангаснаар албан тушаалд томилогдох, эрх зүйн тусгай статустай болох боломж нээгддэг. Энэ талаар Цагдаагийн албаны тухай хуульд “... 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэнийг хүсэлтийг нь үндэслэн шалгуур хангасан байдлаар нь эрэмбэлэн шалгаруулж томилно”⁷⁸ гэж заасан.

Үүний зэрэгцээ эрх зүйн тусгай статустай хүмүүсийн нийтлэг эрх, үүргийг хязгаарлаж болзошгүй хэм хэмжээ байгаа эсэхийг онцлон авч үзэх хэрэгтэй гэж судлаач А.Е.Равильевна үзжээ⁷⁹. Энэ талаар проф. Б.Пүрэв “цагдаагийн алба хаагчийн “эрхийн хязгаарлалт” гэсэн нэр томъёог нэлээд хэрэглэдэг нь буруу юм. Энэ бол иргэний эрхийг хязгаарласан хэрэг биш, иргэн хүн тодорхой төрийн алба эрхлэхэд нөхцөл, болзол тавьж байгаа хэрэг юм. Энэ нөхцөл, болзлыг хангавал цагдаагийн алба хаана, хангахгүй бол хаахгүй. Эдгээр нөхцөл, болзлыг биелүүлж цагдаагийн алба хаах, эсвэл иргэний эрх, эрх чөлөөгөө элдэв нөхцөл, болзолгүйгээр эдлэхийн тулд цагдаагийн албанаас татгалзах сонголтын аль нэгийг иргэн өөрөө сонгож авна.”⁸⁰ гэж тайлбарласантай бид санал нэг байгаа болно. Энэхүү сонголттой холбоотой нэг асуудал нь цагдаагийн алба хаагч нь иргэнийхээ хувьд улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй ч цагдаагийн алба хаагчийн хувьд нам,

⁷⁵ Алексеев, С.С. Общая теория права. М., 2002. 140 дэх тал

⁷⁶ Цагдаагийн албаны тухай хууль. //Төрийн мэдээлэл. Уб., 2017. № 08 66 дугаар зүйлийн 66.2 дахь хэсэг

⁷⁷ Витрук, Н.В. Статус личности в политической система общества. М., 1993. 158 дахь тал

⁷⁸ Цагдаагийн албаны тухай хууль. Уб., 2017. 66 дугаар зүйлийн 66.2 дахь хэсэг

⁷⁹ Равильевна, А.Е. “Правовой статус сотрудников органов внутренних дел” М., 2006. 113 дахь тал

⁸⁰ Пүрэв, Б. “Цагдаагийн байгууллагын тухай хуулийн тайлбар.” Уб., 1997. 86 дахь тал

үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, улс төрийн үзэл баримтлалыг сурталчлах, дэмжлэг үзүүлэхийг Цагдаагийн албаны тухай хуулиар хориглосон⁸¹ явдал юм. Цагдаагийн алба хаагч нь улс төрийн аливаа ажиллагаа явуулдаг эвсэл, холбооны гишүүн байж болохгүй. Төрийн бус ямар нэг байгууллага нь улс төрийн үйл ажиллагаа явуулдаггүй байснаа явуулдаг болбол цагдаагийн алба хаагч түүний гишүүнээс гарах шаардлагатай. Улс төрийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагын гишүүн хэвээр үлдэж, харин улс төрийн үйл ажиллагаа явуулахгүй байж болох мэт тайлбар гардаг. Энэ буруу хуульд "гишүүн байх" гэж заасан юм. Иймд гишүүн байж болохгүй, гарах ёстой.

Цагдаагийн бие бүрэлдэхүүний дотор аль нэг нам, эвсэл, холбооны улс төрийн үзэл баримтлалыг сурталчлахыг хориглосон тухай асуудлыг

а) цагдаагийн аливаа байгууллагын албан байранд;

б) цагдаагийн албан байранд биш боловч цагдаагийн алба хаагчдыг цуглуулж сурталчилж болохгүй гэж ойлгоно.

Суртал нэвтрүүлэгчийн хувьд бол нам, эвсэл, холбооны зүтгэлтэн, идэвхтэн, цагдаагийн алба хаагч, алба хаагч биш иргэн хэн боловч сурталчилж болохгүй гэж ойлгоно. Энэ заалт УИХ-ын гишүүн, орон нутгийн хурлын төлөөлөгч хүнд бүрэн хамаарна. Харин цагдаагийн алба хаагч нь ямар ч нам, эвсэл, холбооны улс төрийн үйл ажиллагаанд огт оролцож болохгүй гэж ойлговол буруу. Дээр дурдсанаас өөр хэлбэрээр, бусад нөхцөлд улс төрийн үйл ажиллагаанд оролцож болно. Жишээлбэл, аль нэг нам, холбоо, эвслийн улс төрийн үзэл баримтлалыг сурталчилж байгаа цуглаан бусад ажиллагаанд оролцож болно. Цагдаагийн алба хаагч өөрөө цагдаагийн алба хаагч биш иргэдэд аль нэг нам, эвсэл, холбооны улс төрийн үзэл баримтлал сурталчилж болно.

Цагдаагийн алба хаагч өөрөө аль нэг нам, эвсэл холбооноос нэр дэвших, нэр дэвшигчийн туслагчаар, идэвхтнээр ажиллах, аль нэг нам, эвслийн хөтөлбөрийн тухай цагдаагийн алба хаагч биш хүмүүст сурталчилгаа хийхийг хориглодоггүй. Гэхдээ цагдаагийн алба хаагч нарыг нам, эвсэл, холбооны улс төрийн үйл ажиллагаанд оролцохгүй байхыг зөвлөдөг болсон нь монголын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тун нааштай нөлөөлсөн нэг хүчин зүйл яах аргагүй мөн⁸².

Цагдаагийн албан хаагч нь төрийн төлөөлөгч бөгөөд түүгээр бүрдсэн тусгай бүрэн эрхийн нэгжийг байгуулах замаар төрийн түүхэн хөгжлийн явцад түүний эрх ашгийг хамгаалахын зэрэгцээ төрөөс иргэний өмнө хүлээсэн үүргийг биелүүлж байдаг. Энэ ойлголтыг хууль зүйн эх сурвалж талаас нь авч үзвэл Монгол Улсын Үндсэн хуульд "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна"⁸³ гэж, Төрийн албаны тухай хуульд "төрийн алба гэж төрийн зорилт чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтыг"⁸⁴ ойлгохоор, мөн хуулийн 6 дугаар зүйлд: Төрийн албыг төрийн улс төрийн алба, төрийн захиргааны алба, төрийн тусгай алба, төрийн үйлчилгээний алба"⁸⁵ гэж ангилахаар хуульчилсан бөгөөд Цагдаагийн албаны тухай хуульд "Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн"⁸⁶ гэж тус тус зааснаар илэрч байна. Энэ нь төр өөрийн тогтолцооны байгууллага болох тусгай алба буюу цагдаагийн

⁸¹ Цагдаагийн албаны тухай хууль. // Төрийн мэдээлэл. Уб., 2017. № 08 69 дүгээр зүйл 69.1.8 дахь хэсэг

⁸² Пүрэв, Б. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн тайлбар. Уб., 1997. 87 дахь тал

⁸³ Монгол улсын Үндсэн хууль // Төрийн мэдээлэл. Уб., 1992. №1 2 дугаар бүлгийн 19 дүгээр зүйл

⁸⁴ Төрийн албаны тухай хууль // Төрийн мэдээлэл. Уб., 2018. №01 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэг

⁸⁵ Мөн тэнд.

⁸⁶ Цагдаагийн албаны тухай хууль. // Төрийн мэдээлэл. Уб., 2017. № 08 4 дүгээр зүйл

албаар дамжуулан Үндсэн хуулиар хүлээсэн үүргийнхээ тодорхой хэсгийг иргэнийхээ өмнө хэрэгжүүлж байгаа явдал юм. Иймээс цагдаагийн алба хаагч нь цагдаагийн албанаас хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн үүргийг биелүүлэх явцдаа тодорхой эрхийг эдлэхийг зэрэгцээ өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон эрх зүйн баталгааг эдлэх тул цагдаагийн байгууллагаар дамжуулан төрийн үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн төлөөлөгч мөн.

Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал нь босоо болон хэвтээ бүтэцтэй цогц систем юм. Эрх зүйн байдлын босоо хуваарилалт нь эрхэлж буй албан тушаалаас (бага, дунд, ахлах, удирдах ажилтан г.м.) хамааран алба хаагчдын төрлийг ялгахад бүрддэг бол хэвтээ бүтэц нь цагдаагийн алба хаагчийн хэрэгжүүлж байгаа чиг үүргээс хамааралтайгаар захиргааны үйл ажиллагаа, зөрчил шалгаж шийдвэрлэх ажиллагаа, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, гүйцэтгэх ажил зэргээр илэрдэг. Эдгээр нь ерөнхий бүтэц бөгөөд эрх зүйн харилцааны субъект болох цагдаагийн алба хаагчийн байр суурийг тодорхойлдог байна. Албан тушаал нь цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлын анхны, үндсэн элемент гэж үзэж болох юм. Хэдийгээр энэ нь өөрөө тодорхой хугацаанд албан тушаалыг хашиж байгаа хүнээс хамаардаггүй боловч тухайн бие хүний хувийн чанар, чадвар нь албан тушаалын бүрэн эрхийг хэрэгжүүлэх үйл явц, албан тушаалтны мэргэжлийн үйл ажиллагааны үр дүнд ихээхэн нөлөөлдөг. Тиймээс цагдаагийн албан хаагчийн эрх зүйн байдлыг тэдний эрхэлж буй албан тушаал, хэрэгжүүлж буй чиг үүрэг, байр сууриар нь нарийн тодорхойлдог. ОХУ-ын судлаач Розенбаумын үзсэнээр албан тушаал нь ажилтны эрх зүйн байдал, түүний чиг үүрэг, төрийн байгууллага, байгууллагын тогтолцоо дахь байр суурийг тодорхойлдог⁸⁷ гэжээ. Албан тушаал нь цагдаагийн алба хаагчдад бүхэл бүтэн эрх үүргийг хуваарилах объектив хүчин зүйл, чухал урьдчилсан нөхцөл бөгөөд албан тушаалаар дамжуулан нэг талаас төр, нөгөө талаас цагдаагийн алба хаагч хоёрын анхдагч холбоо тогтоогддог. Тухайлбал цагдаагийн алба хаагчийг Цагдаагийн төв байгууллагын дарга гэх албан тушаалтан өөрийн тухайн албан тушаалын хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд томилдог бөгөөд энэхүү томилогдсон явдал тухайн бие хүн, төрийн хооронд анхдагч холбоо үүсгэнэ. Өөрөөр хэлбэл ийнхүү цагдаагийн албанд томилогдсоноор цагдаагийн буюу төрийн албан хаагчийн эрх зүйн байдал бий болно гэсэн үг юм.

Цагдаагийн алба хаагч нь төрийн байгууллын тогтолцоонд албан тушаал эрхэлж буй төрийн алба хаагчдын нэг хэсэг бөгөөд энэ чанараараа төрийн байгууллагын бусад салбарын алба хаагчдын нэгэн адил өөрийн онцлог шинж чанартай байдаг. Энэхүү онцлог нь цагдаагийн цол хэрэглэх явдал юм.

Өөрөөр хэлбэл а) цагдаагийн тангараг өргөж;

б) цагдаагийн аль нэг байгууллагад томилогдон ажиллаж

в) цагдаагийн цолтой иргэнийг цагдаагийн алба хаагч гэнэ.

Нэг талаас албан тушаал нөгөө талаас цагдаагийн цол хэрэглэх явдал нь хоорондоо уялдаа холбоотой байдаг ч энэ холбоо нь туйлын тодорхойгүй байдаг. Цагдаагийн алба хаагчийн цолны албан тушаалаас ялгаатай тал нь насан туршийнх бөгөөд хууль ёсны дагуу албанаас чөлөөлөгдөх буюу тэтгэвэр тогтоолгох насанд хүрч, тэтгэвэр тогтоолгосон алба хаагчийг чөлөөнд гарахад цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр эдэлж байсан цагдаагийн цолыг хадгалуулахаар зохицуулагдсан⁸⁸ явдал юм. Зарим тохиолдолд тодорхой албан тушаалд томилогдоогүй бол дараагийн цол олгогдохгүй байх нөхцөл үүсдэг атлаа албан тушаалын зэрэг, дэв буурсан ч урьдын цолоо хэвээр хэрэглэх жишээ цагдаагийн албанд олон байна.

Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлын өөр нэг элемент нь тухайн алба хаагчийн албан тушаалаас шалтгаалсан төрийн эрх мэдэл юм. Цагдаагийн алба хаагч өөрийн

⁸⁷ Розенбаум, Ю.Г. Формирование управленческих кадров. М., 1992. 61 дэх тал

⁸⁸ Монгол улсын Засгийн газрын тогтоол. Уб., 2017. №72 “Журам батлах тухай”

чиг үүрийг хэрэгжүүлэх явцад үүсэж буй асуудал, нөхцөл байдлыг шийдвэрлэхийн тулд төрөөс түүний өөрийн нэрийн өмнөөс зөвшөөрөл авдаг. Өөрөөр хэлбэл эрх зүйн хязгаарлалт албан тушаалын байдлаас шалтгаалж үйлчилдэг бөгөөд энэ шинж нь гэмт хэрэгтэй тэмцэх тодорхой арга, ажиллагааг зохион явуулах үед тасаг, хэлтсийн дарга, зарим тохиолдолд ЦЕГ-ын даргаас зөвшөөрөл авах хэлбэрээр илэрч байна. Үүнээс гадна цагдаагийн алба хаагчийн тэр дундаа удирдах түвшний алба хаагчаас хэрэгжүүлж буй төрийн эрх мэдлийн шинж нийгэмд илүүтэйгээр мэдрэгддэг. Цагдаагийн албаны хуульд заасан тодорхой шалгуур, шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг цагдаагийн албаар дамжуулан төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх эсэхийг цагдаагийн төв байгууллагын дарга хуулиар олгосон⁸⁹ бүрэн эрхийн хүрээнд цагдаагийн албанд томилох, эсхүл чөлөөлөх байдлаар шийдвэрлэнэ. Эдгээр ойлголтууд дээр үндэслэн бид цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдалд албан тушаал дараах байдлаар нөлөөлнө гэж үзлээ. Үүнд:

- Албан тушаал нь цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлын анхны, хуваагдашгүй тодорхой хэмжээгээр тусгаарлагдсан элемент юм.
- Албан тушаал нь цагдаагийн алба хаагчийн чиг үүргийг хуваарилах, цагдаагийн албаны үйл ажиллагааг тогтворжуулах хэрэгсэл юм.
- Албан тушаал нь цагдаагийн албанд ажиллаж байгаа хүнд хуулиар тогтоож өгсөн чиглэгдсэн эрх, үүргийн тогтвортой цогц юм.
- Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлыг тодорхойлж байгаа албан тушаал нь цагдаагийн алба хаагчаас явуулах үйл ажиллагааны зохион байгуулалт, эрх зүйн эх сурвалжийн нэгдэл юм.
- Албан тушаал нь цагдаагийн алба хаагчийг эрх зүйн байдлын хувьд тусгай статустай болохыг илэрхийлэх нэг хэлбэр юм гэж тус тус үзэж байгаа болно.

Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал нь төрийн албаны харилцааны агуулга, эрх, үүрэг, эрх, үүргийг хэрэгжүүлэх баталгаа, хариуцлагын хэм хэмжээгээр тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл түүний эрх зүйн байдал нь хууль тогтоомжоор тогтоосон, төрөөс баталгаажсан, эрх, эрх чөлөө, үүрэг, хязгаарлалт, хариуцлагын цогц юм. Судлаач Б.Нармандах хүний эрхийн баталгааг хангах гэдэг нь хуульчлан тодорхойлсон эрхийг үнэн бодитой хэрэгжүүлэх нөхцөл боломжийг хангахад чиглэгдсэн нийгэм, эдийн засаг, улс төр, үзэл суртал, хууль зүйн цогц асуудлыг хамтатгасан нийгмийн шинжтэй асуудал юм⁹⁰ гэжээ. Үүнийг өргөн утгаар нь нийгмийн хамгаалал гэж томъёолдог ба нийгмийн хамгаалал гэсэн ойлголт нь хүн өглөх, осол гэмтэлд өртөх, өвчлөх, хөдөлмөрийн чадвараа алдах зэргээр хэвийн байдлаар амьдрах нөхцөл боломж алдагдахад төрийн зүгээс амьдралын наад захын баталгааг бүрдүүлэх үүднээс асрамжлах, халамжлах, тэтгэвэр, тэтгэмж олгох, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох харилцаа юм. Нийгмийн хамгааллын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа нь ихэнхдээ эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагддаг.

Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлыг хангах асуудал нь ихэвчлэн баталгааны тогтолцоотой байдаг бөгөөд баталгаа нь эдийн засаг, нийгэм, улс төр, хууль эрх зүйн олон төрлийн баталгааны тогтолцоог илэрхийлдэг. Энэ тогтолцоог цагдаагийн алба хаагчийн "давуу эрх" гэдэг нэр томъёогоор илэрхийлэх явдал байдаг нь буруу юм. Цагдаагийн алба хаагч нь бусад иргэний адил тэгш эрхтэй. Харин албан үүргээ биелүүлэхэд нь зайлшгүй шаардлагатай зарим баталгааг төр тогтоож өгдөг. Энэ нь албан үүргээ биелүүлэх нөхцөл бүрдүүлж өгч байгаа хэрэг болохоос цагдаагийн алба хаагчийг бусад иргэдээс давуу, илүү эрх, эрх чөлөөтэй болгосон хэрэг биш.

⁸⁹ Цагдаагийн албаны тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2017. № 08 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэг

⁹⁰ Нармандах, Б." Үндсэн хуулийн эрх зүй" сурах бичиг. УБ., 2017. 136 дахь тал

Эрх зүйн иймэрхүү онцлог зөвхөн цагдаагийн ч биш, төрийн олон албанд бий. Намын гишүүнээсээ түдгэлзэх, давхар ажил эрхлэхгүй байх, бизнесийн үйл ажиллагаа явуулахгүй байх, гадаадад зорчихдоо зөвшөөрөл авах гэх мэт "хязгаарлалт", зохих зөвшөөрөлгүйгээр эрүүгийн болон захиргааны хэрэгт татахгүй байх зэрэг "давуу тал" төрийн олон албанд байгаа юм.⁹¹

Энэ талаар ОХУ-ын эрдэмтэн Н.В. Витрук “ эрх, үүрэг бүр өөрийн гэсэн баталгааны тогтолцоотой байх ба энэхүү тогтолцоонд эдийн засаг, нийгэм улс төр, оюун санааны ерөнхий нөхцөл, тэдгээрийг хэрэгжүүлэх, хамгаалахад чиглэсэн эрх зүйн тусгай арга, хэрэгсэл хоёулаа багтана”⁹² гэж үзсэн бол Ф.М.Рудинский “Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлын баталгааны объект нь баталгааны хэрэгжилтийг хангахтай холбоотой олон нийтийн харилцаа юм. Тэдний агуулга нь өөр өөр байдаг бөгөөд энэ нь цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагааны зорилго, нийгмийн чиг баримжаагаар тодорхойлогддог. Иймээс цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлын баталгааны тогтолцоо нь ерөнхий болон тусгай баталгаанаас бүрдэнэ”⁹³ гэж үзжээ. Мөн тэрээр нийгмийн чиг баримжаа олгох ерөнхий баталгааг эдийн засаг, улс төр, нийгэм, оюун санааны гэж хуваах ба эдгээр нь бүх субъектийн эрх зүйн байдлын хэрэгжилтийг хангах онцлог шинж гэж тайлбарласан байна.

Ерөнхий баталгаа нь цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлыг хангах үндэс суурь болдог. Гэхдээ тэдний үйлдлийг голчлон тусдаа хуулиар зохицуулдаг бөгөөд үүнийг хууль зүйн баталгаа гэж нэрлэдэг. Үүний зэрэгцээ ерөнхий болон тусгай баталгаа нь харилцан уялдаатай, агуулга, эрх зүйн хэлбэрийн хувьд нягт нэгдмэл байдаг байна. Тусгай баталгаа нь цагдаагийн алба хаагчийн статусыг хэрэгжүүлэх арга, хэрэгслийн тогтолцоо, түүний хууль ёсны хамгаалалт, хамгаалах хэрэгсэл нь юм. Өөрөөр хэлбэл цагдаагийн алба хаагч тухайн үед ямар үүрэг гүйцэтгэж байгаагаас хамааран эрх зүйн байдал нь өөрчлөгдөж байдаг. Энэ талаар проф Б.Пүрэв цагдаагийн албаны онцлогоос хамааран цагдаагийн алба хаагч нарын эрх зүйн байдалд зарим онцлог бий. Нэгдүгээрт цагдаагийн алба хаагч иргэний эрх, эрх чөлөөг эдлэхдээ эрхэлж буй ажил албаны онцлогоос шалтгаалсан зарим нөхцөл болзлыг хангахыг шаарддаг, хоёрдугаарт цагдаагийн алба хаагчийн үүргээ биелүүлэхэд шаардлагатай зарим баталгааг төрөөс тогтоож өгөх шаардлага гардаг бөгөөд цагдаагийн албаны энэ хоёр онцлогийг ямагт хамт авч үзэж байх хэрэгтэй⁹⁴ гэж үзжээ. Мөн цагдаагийн алба хаагч тухайн үед ямар үүрэг гүйцэтгэж байгаагаас хамааран эрх зүйн байдал нь өөрчлөгдөж байдаг тул цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлыг дараах ялгаатай байдлаар авч үзжээ. Үүнд:

➤ Иргэн хүн цагдаагийн алба хаагч болмогц үүсэж албанаас чөлөөлөгдөх, халагдах хүртэл байнга үйлчлэх ажил хаяхыг хориглох, цолны нэмэгдэл авах гэх мэт нийтлэг эрх хэмжээ

➤ Хууль сахиулах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх үед үүсэх хот,суурингийн дотор таксинаас бусад нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчих, тусгай хэрэгсэл хэрэглэх гэх мэт тусгай эрх хэмжээ

➤ Зөвхөн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах тодорхой үүргийг гүйцэтгэх үед хэрэгжүүлэх үйлдлийн улмаас үүсэж болох тээврийн хэрэгслийг дайчлан ашиглах гэх мэт эрх хэмжээ⁹⁵ гэж ангилсан байна.

Үүнээс гадна цагдаагийн алба хаагчийн эрх мэдэл нь хэд хэдэн онцлог шинж чанараар тодорхойлогддог. Тухайлбал өөрт нь шууд харьяалагддаггүй хүмүүст хуульд үндэслэн шаардлага тавих, өөрт олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн байгууллага, төрийг бүхэлд нь төлөөлөн ажиллах, шаардлагатай тохиолдолд төрийн албадлагын арга

⁹¹ Пүрэв, Б. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн тайлбар. Уб., 1997. 84 дэх тал

⁹² Витрук, Н.В. Статус личности в политической система общества. М., 1993. 200 дахь тал

⁹³ Рудинский, Ф.М. Личность и социалистическая законность. Волгоград., 1986. 51 дэх тал

⁹⁴ Пүрэв, Б. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн тайлбар. Уб., 1997. 85 дахь тал

⁹⁵ Мөн тэнд

хэмжээ авах зэргийг дурдаж болно. Албадлагын арга хэмжээтэй холбоотой нийгэмд байдаг сөрөг ойлголт нь цагдаагийн алба хаагчийн эрх мэдлийн хэмжээ, төрийн албадлагын арга хэмжээний шинж чанараас хамааран цагдаагийн алба хаагчийг эрх баригчдын төлөөлөгчөөр ажилладаг гэх хандлага юм. Энэ нь буруу ойлголт бөгөөд цагдаагийн алба хаагчид хуулиар олгосон бүрэн эрх нь төрийн албадлагын арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэхээр зохицуулагдсан байгаагаас шалтгаалдаг гэдгийн тэмдэглэх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй хүмүүст биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэж байгаа явдал нь эрх баригчдын эрх ашгийн төлөөлж байгаа бус хуульд заасан өөрийн бүрэн эрхийг л хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа гэж ойлгох нь зүйтэй.

Цагдаагийн алба хаагчийн албан үүргээ биелүүлэх баталгаа нь агуулга, зарчмын хувьд хүний эрхтэй шууд холбоотой гэж хэлж болно.

Өнөөдөр Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 90 гаруй хуулийн 166 гаруй зүйл, хэсгээр цагдаагийн алба, алба хаагчийн үйл ажиллагаа, хөдөлмөрлөхтэй холбоотой харилцааг зохицуулж байна.⁹⁶ Цагдаагийн алба хаагчийн нийгмийн хамгааллын тогтолцоог дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Цалин хөлс
- Тэтгэвэр
- Тэтгэмж
- Тусламж
- Нөхөх олговор
- Бусад арга хэмжээ багтана.

Монгол улсын Төрийн албаны тухай хуульд⁹⁷ “Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин, хөлс авна” гэжээ.

Мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.3-т: “тусгай албан тушаал эрхэлдэг албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалин нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн тусгай алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, эрдмийн зураг цолны, мэргэшлийн зэргийн нэмэгдлээс бүрдэнэ” гэж заасан байна. Энэхүү заалттай холбоотойгоор Монгол улсын Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоол⁹⁸, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/124 дүгээр тушаалаар баталсан “Нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоох” журмаар цагдаагийн алба хаагчдад албан тушаалын цалин, төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл, онцгой нөхцөлийн нэмэгдэл, цолны нэмэгдэл, мэргэшлийн зэргийн нэмэгдэл, эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл олгох харилцааг зохицуулж байна.

Тэтгэвэр нь хуульд заасан тохиолдол болсон үед иргэнд болон түүний асрамжид байсан хүмүүст төрөөс болон нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгө гэж ойлгож болно. Цагдаагийн алба хаагчийн тэтгэвэртэй холбогдсон харилцааг цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулиар зохицуулах ба уг хууль нь цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааг хангах эрх зүйн тогтолцоонд голлох байр суурийг эзэлдэг. Хуульд зааснаар⁹⁹ тэтгэвэр нь цэргийн алба хаасны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны гэсэн төрлүүдтэй байна. Эндээс цэргийн алба хаасны тэтгэврийг онцлон авч үзье. Цагдаагийн албанд 25-аас доошгүй жил ажилласан эрэгтэй, 20-оос доошгүй жил ажилласан

⁹⁶ Нямдаваа, Л. “Цагдаагийн алба хаагчийн албан үүргээ биелүүлэх хууль зүйн баталгаа, түүний зохицуулалтын зарим асуудал” судалгааны ажил. Уб., 2016. 23 дахь тал

⁹⁷ Төрийн албаны тухай хууль //Төрийн мэдээлэл. Уб., 2018. №01 11 дугаар зүйлийн 11.1 дэх хэсэг

⁹⁸ Монгол Улсын Засгийн газрын тогтоол. “Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” Уб., 2014. №99

⁹⁹ Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль. //Төрийн мэдээлэл. Уб., 1994. №08. 3 дугаар зүйл

эмэгтэй алба хаагч нас харгалзахгүйгээр цэргийн алба хаасны бүрэн тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй байна.¹⁰⁰ Үүнээс гадна дээрх хугацааг хангаагүй боловч дараах нөхцөлөөр тэтгэвэр, тэтгэмж авч болохыг хуульчилсан. Үүнд:

- Орон тоо зохион байгуулалтын өөрчлөлтөөр
- Биеийн эрүүл мэндээр
- Цэргийн алба хаах нас хэтэрч чөлөөлөгдсөн тохиолдолд цэргийн алба хаасны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй байна.¹⁰¹

Уг хуулийн заалтыг Монгол Улсын Дээд шүүхээс “Тухайн албыг хаах насны дээд хязгаарт хүрснээс бусад тохиолдолд цэргийн алба хаагч өөрийн санаачилгаар тэтгэвэр тогтоолгох бүрэн боломжтой гэж ойлгоно” гэж тайлбарлажээ.¹⁰² Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгаанд хамаарах онцлог асуудал нь түүний настай холбоотойгоор цагдаагийн албаар дамжуулан төрийг төлөөлсөн эрх зүйн харилцаанд оролцох эрх үүсэх, эсхүл дуусгавар болох тухай явдал болж байна.

Цэргийн алба хаасны тэтгэвэр авах гол үндэслэл нь хуульд заасан насанд хүрсэн байх явдал бөгөөд энэ тухай хуульд¹⁰³:

- Иргэн ахлагчийн албыг 47 нас хүртэл хаана.
- Офицерын албыг дунд офицер 47 нас хүртэл
- Ахлах офицер 52 нас хүртэл
- Дээд офицер 57 нас хүртэл
- Эмэгтэйчүүд офицерын албыг цэргийн цол харгалзахгүйгээр 47 нас хүртэл хаана гэж заасан бол Цагдаагийн албаны тухай хуульд¹⁰⁴ цагдаагийн алба хаагч тэтгэвэр тогтоолгож, тэтгэмж авах эрхтэй бөгөөд алба хаах насны дээд хязгаар нь:

- Цагдаагийн бага цолтой алба хаагч 47 нас
- Цагдаагийн дунд цолтой алба хаагч 52 нас
- Цагдаагийн ахлах цолтой алба хаагч 55 нас
- Цагдаагийн дээд цолтой алба хаагч 57 нас
- Цагдаагийн бага цолтойгоос бусад эмэгтэй алба хаагчийн алба хаах насны дээд хязгаар нь 47 нас байна гэж заасан нь цагдаагийн дунд болон ахлах цолтой алба

хаагчийн алба хаах насны хязгаарын хувьд ялгаатай байна. Энэ нь цагдаагийн албаны хуулиар хүлээсэн чиг үүрэг, үйл ажиллагааны цар хүрээ, алба хаагчдын тооноос хамааралтай байж болох юм.

Тэтгэмж нь биеийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан тодорхой хугацаанд албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд эмнэлгийн хуудсыг үндэслэн мөнгөн хэлбэрээр олгох нийгмийн хамгааллын арга хэмжээний нэг төрөл бөгөөд цагдаагийн алба хаагчид олгох тэтгэмж нь түүнд олгох тэтгэврээс олгогдох үндэслэл, хэмжээ, хугацаагаар ялгагдах ойлголт юм. Цагдаагийн алба хаагчид олгох тэтгэмж нь хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсэн болон амаржсаны, нэг удаагийн гэсэн төрөлтэй байх ба хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжээс ялгагдах онцлог нь цагдаагийн алба хаагчийн хувьд хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад хөдөлмөрийн чадвараа түр алдсан, ердийн өвчин, ахуйн ослоор хөдөлмөрийн чадвар түр алдсан байх эсэхээс шалтгаалан тэтгэмжийн хэмжээ ялгамжтай байхад оршино.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хөдөлмөрийн чадвар алдсан үеэс нь эхлэн сэргээгдэх хүртэл эсхүл тахир дутуу болсон нь тогтоогдох хүртэл хугацаанд олгох

¹⁰⁰ Мөн тэнд. 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг

¹⁰¹ Мөн тэнд. 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг

¹⁰² Монгол Улсын Дээд шүүхийн тайлбар. УБ., 2009. №78. 3 дахь хэсэг

¹⁰³ Цэргийн албаны тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2016. №36 10-11 дүгээр зүйл

¹⁰⁴ Цагдаагийн албаны тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2017. № 08 91 дүгээр зүйл

боловч олгох хугацааны дээд хязгаар нь 13 долоо хоног, хорт хавдар, болон сүрьеэгээр анх өвчлөхөд 26 долоо хоног байхаар, албан үүргээ гүйцэтгэх явцад хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол түүний сүүлчийн бүтэн ажилласан 6 сарын цалин хөлсний сарын дундажтай тэнцүү хэмжээгээр, албан үүрэг гүйцэтгэхтэй холбоогүйгээр хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд сүүлчийн бүтэн 4 сарын цалин хөлсний сарын дунджаас ажилласан жилийг харгалзан 5 хүртэл жил 50%-иар, 5-14 жил 60%-иар, 15 ба түүнээс дээш жил 80 %-иар бодож олгохоор тус тус хуульчилжээ¹⁰⁵.

Цагдаагийн алба хаагч нь албан үүрэг гүйцэтгэхтэй холбоотойгоор болон холбоогүйгээр хөдөлмөрийн чадвар түр алдсан нөхцөлд хуульд заасан хугацаа, хувь хэмжээгээр тэтгэмж авах нийгмийн баталгаагаар хангагдахын зэрэгцээ хөдөлмөрийн чадварыг бүрмөсөн алдах эсхүл амь нас нь хохирсон тохиолдолд нөхөх олговор, тусламж авах баталгаагаар хангагдана. Энэхүү баталгааг эдлэх урьдчилсан нөхцөл нь зөвхөн албан үүргээ гүйцэтгэх явц байх бөгөөд хөдөлмөрийн чадвараа алдсан байдал нь эрүүл мэндийн хувьд эргэн сэргэхгүйгээр хохирсон байх шинжээрээ тэтгэмжээс ялгагдаж байна.

Цагдаагийн алба хаагчийн нийгмийн хамгааллын энэхүү баталгааг цагдаагийн албаны тухай хуулиар зохицуулсан бөгөөд уг хуульд: “цагдаагийн алба хаагч өөрийн цол, албан тушаал, хариуцсан нутаг дэвсгэр, чиг үүргээс үл хамааран хүний амь нас, эрүүл мэндэд бодит аюул учирч тусламж хүссэн, эсхүл энэ тухай өөрөө олж мэдсэн бол хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, учирч болзошгүй аюулыг зайлуулах, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг баривчлах, гэмт хэрэг, зөрчлийн үл мөрийг хамгаалах арга хэмжээг даруй авч, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад мэдэгдэх үүрэгтэй” гэж мөн “Цагдаагийн алба хаагч ажлын бус цагаар хууль ёсны үйл ажиллагаа явуулсан, түүнчлэн ажилдаа ирэх, буцах замд явсныг албан үүргээ гүйцэтгэж байгаатай адилтган тооцно.” гэж тус тус заажээ.¹⁰⁶ Үүнээс гадна цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд хөдөлмөр алдалтын хувь хэмжээнээс хамааран хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нөхөх олговрыг давтамжийн хувьд нэг удаа олгох, амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг амь насаа алдсан алба хаагчийн гэр бүлд нэг удаа олгох, хөдөлмөр чадвар алдсаны тэтгэвэр болон цалингийн нэмэгдлийн зөрүүг тооцож олгох зэрэг хуулийн заалтууд хэрэгжиж байна.

Дүгнэлт. Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдалтай холбогдох дараагийн асуудал нь хариуцлагын тухай юм. Цагдаагийн албаны тухай хуульд цагдаагийн алба хаагчид сахилгын хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байх ба сахилгын хариуцлага дараах төрөлтэй байдаг. Үүнд :

- сануулах;
- албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;
- албан тушаал бууруулах;
- цагдаагийн цолыг бууруулах;
- цагдаагийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах гэсэн

төрлүүдтэй¹⁰⁷ байгааг өнөөдрийн хууль, эрх зүйн баримт бичгүүдэд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай. Тухайлбал, цагдаагийн цол бууруулах сахилгын хариуцлага нь тухайн алдаа дутагдал гаргасан алба хаагчид хэрхэн нөлөөлөх вэ? Цагдаагийн хошууч цолтой алба хаагчид сахилгын хариуцлага тооцож цагдаагийн цолыг нэг шатаар бууруулан цагдаагийн

¹⁰⁵ Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль. //Төрийн мэдээлэл. Уб., 1994. №08. 16-17 дугаар зүйл

¹⁰⁶ Цагдаагийн албаны тухай хууль. //Төрийн мэдээлэл. Уб., 2017. № 08 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 85 дугаар зүйлийн 85.5 дахь хэсэг

¹⁰⁷ Цагдаагийн албаны тухай хууль. //Төрийн мэдээлэл. Уб., 2017. № 08 81 дүгээр зүйлийн 81.4 дэх хэсэг

ахмад болгосон тохиолдолд цагдаагийн алба хаагчид олгож байгаа албан тушаалын цалин, цолны нэмэгдэлд ямарваа нэгэн өөрчлөлт гарахгүй тул энэхүү сахилгын хариуцлагын төрлийн үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх үүднээс цагдаагийн цолны нэмэгдлийн шатлалыг ялгамжтай болгох шаардлагатай гэж дүгнэж байна.

**ЦЕГ-ЫН НХЖХОНАБХА-НЫ ХАРЬЯА ДҮН ШИНЖИЛГЭЭ, ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН НЭГЖЭЭС ЯВУУЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

**ACTIVITIES FROM THE RELATIVE ANALYSIS AND SUPERVISION
UNIT OF THE REGULATORY ENFORCEMENT OFFICE OF THE
GENERAL POLICE DEPARTMENT CURRENT SITUATION**

О.Батням
ДХИС-ийн магистрант,
цагдаагийн ахмад
O.Batnyam – Graduate student,
University of Law Enforcement,
Police captain

Хураангуй. Цагдаагийн алба хаагчдаас гаргаж буй сахилга, ёс зүйн зөрчил буурахгүй, албан үүрэг гүйцэтгэх явцдаа алдаа гаргах явдал гарсаар байгаа нь тулгамдсан асуудал болоод байна.

Энэхүү илтгэлд ЦЕГ-ын харьяа Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Дүн шинжилгээ, хяналт, шалгалтын хэлтсийн явуулж буй үйл ажиллагааны өнөөгийн байдал болон алба хаагчдаас гаргаж буй сахилга, ёс зүйн зөрчлийн өнөөгийн төлөв байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар товч авч үзсэн болно.

Summary. Disciplinary and ethical violations by police officers do not decrease, and it is a pressing problem that they continue to make mistakes in the course of their official duties.

In this report, the current state of operations of the Analysis, Control, and Inspection Department of the Office for Public Order Protection and Public Safety under the Central Intelligence Agency, the current state of disciplinary and ethical violations committed by officers, and the factors affecting it will be briefly discussed.

Түлхүүр үг: хэв журмын алба хаагч, сахилгын зөрчил, ёс зүйн зөрчил, дүн шинжилгээ, хяналт шалгалт, эрх зүйн зохицуулалт

Keywords: law enforcement officer, disciplinary violation, ethical violation, analysis, inspection, legal regulation

Оршил хэсэг. Хяналт шалгалт гэдэг нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, зарим үйл ажиллагааг дүрэм, журмын дагуу явуулж байгаа эсэхийг нягтлах, хянан

шалгаж дүгнэхэд чиглэсэн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас явуулж буй арга хэмжээнүүдийн нийлбэр цогц юм.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 31.1.1."хяналт шалгалт" гэж иргэн, хуулийн этгээдийн явуулж байгаа үйл ажиллагаа /үйлдэл, эс үйлдэхүй/, түүнчлэн үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэсэн хянан шалгах арга хэмжээний цогцолборыг”¹⁰⁸ хэмээн тодорхойлжээ.

Дотоод хяналт шалгалт нь зохион байгуулалт, үйл ажиллагаа, хамрах хүрээний хувьд хууль дээдлэх, бие даасан, хараат бус, ил тод, шударга байх, хяналт шалгалтын дүнг бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид үнэн зөв тайлагнах зарчимд тулгуурлана.

Дотоод хяналт шалгалтыг явуулсаны дараа үнэлгээ хийнэ. Үнэлгээ нь хэрэгжиж буй болон хэрэгжсэн төсөл, хөтөлбөр эсвэл бодлого, түүний загвар, хэрэгжилт, үр дүнг системтэй, бодитой үнэлж дүгнэх үйл ажиллагаа юм. Үнэлгээний зорилго нь төсөл, хөтөлбөр, бодлогын зорилгын уялдаа холбоо, хэрэгжилт, хөгжлийн үр ашиг, үр дүнтэй байдал үр нөлөө болон цаашид тогтвортой байх эсэхийг тодорхойлох явдал билээ.¹⁰⁹

Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хуульд заасан үндэслэл, журмын дагуу хяналт шалгалтыг хийх бөгөөд хяналт шалгалтыг төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн гэж ангилна.

ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Дүн шинжилгээ, хяналт, шалгалтын хэлтэс нь албаны хэмжээнд хяналт шалгалтыг хариуцан зохион байгуулж явуулж байна. Гэхдээ хяналт шалгалтыг Төрийн хяналт, шалгалтын тухай хуульд заасан арга, хэлбэрээр явуулж байна.

Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 31.1.2."хяналт шалгалтын арга, хэлбэр" гэж тухайн хяналт шалгалтад хамаарах баримт бичгийг хянан үзэх, шалгуулагч этгээдийн үйл ажиллагаагаа явуулдаг нутаг дэвсгэр, байр, барилга байгууламж, өрөө тасалгаа, тоног төхөөрөмж, бусад объект, тээврийн хэрэгсэл, ачаа бараанд үзлэг хийх, бүтээгдэхүүн болон тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны орчноос дээж авч шинжлэх, турших, учирсан хор хохирол болон гаргасан зөрчлийн хоорондох уялдаа холбоог тогтоох зорилгоор шинжилгээ явуулах зэрэг хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллагын албан тушаалтан, түүнчлэн хууль тогтоомжид заасан журмын дагуу хяналт шалгалтад татагдан оролцож байгаа шинжээч, шинжилгээний байгууллагын үйл ажиллагааг¹¹⁰ хэлдэг байна.

Хяналт шалгалт явуулсан тухай бүрт хяналт шалгалтын бүртгэл хийлгэнэ. Хяналт шалгалтын бүртгэл гэж хийсэн хяналт шалгалт бүрийг зохих журмын дагуу мэдээллийн нэгдсэн санд бүртгэхийг хэлнэ.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/13 дугаарын тушаалаар тус албаны бүтцэд Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтсийг шинээр байгуулан үйл ажиллагаагаа явуулж иржээ Тус хэлтэс 2021 онд алба хаагчидтай холбоотой иргэд, байгууллагаас ирүүлсэн 41 гомдол мэдээллийг хүлээн авч, 29 гомдолд албаны шалгалт явуулж, харьяа нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас ирүүлсэн 9 албаны шалгалтын материалыг хянаж, Албаны болон Цагдаагийн төв байгууллагын удирдлагад танилцуулж шийдвэрлүүлжээ.

ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Дүн шинжилгээ, хяналт, шалгалтын хэлтэс нь дараах эрх зүйн актыг үндэслэн, үйл

¹⁰⁸ Төрийн мэдээлэл. 2003. №2 Төрийн хяналт шалгалтын тухай хууль

¹⁰⁹ <https://prezi.com/bj9nwmhbskmn/presentation/>

¹¹⁰ Төрийн мэдээлэл. 2003. №2 Төрийн хяналт шалгалтын тухай хууль

ажиллагааныхаа чиглэлээ тодорхойлж, ажил, арга хэмжээгээ авч хэрэгжүүлж байна. Тухайлбал:

- Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгавар;
- 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоол;
- Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн “Төрийн албанд ёс зүй, сахилга, хариуцлагыг сайжруулах тухай 02 дугаар зөвлөмж;
- Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 2/396 дугаартай ажлын чиглэл;
- Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 3/25 дугаартай мэдээлэл, ажлын чиглэл;
- Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 5/45 дугаар үүрэг, ажлын чиглэл, уриалга.


ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Дүн шинжилгээ, хяналт, шалгалтын хэлтэс нь тус албаны төв, орон нутаг дахь харьяа нэгжийн нийт алба хаагчдаас гаргасан сахилга, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийхэд 2021 онд нийтдээ 309 зөрчилд 312 алба хаагч холбогдсон байна.

Албаны харьяа цагдаагийн алба хаагчдаас гаргасан 2020 онд 253 сахилгын зөрчил гаргаж байсан бол 2021 онд 309 болж өмнөх оноос 56 нэгж буюу 22.1%-аар өссөн байна. Дээрхи тоо мэдээг графикт оруулан авч үзвэл:

График №1





График №2



Сахилгын зөрчил гаргасан алба хаагчдын 144 буюу 46.1% нь офицер, 168 буюу 53.8% нь ахлагч бүрэлдэхүүн байна. Түүнчлэн сахилгын зөрчил гаргасан алба хаагчдын нутаг дэвсгэрийн харьяаллыг авч үзвэл 2021 онд 127 буюу 41% нь нийслэлд, 142 буюу 45.9% нь орон нутаг, 10 буюу 1.3% нь албаны харьяа нэгжийн алба хаагчид хамаарч байна. Үүнийг график, хүснэгтэд оруулан авч үзвэл:

График №3

Хүснэгт №1




Сахилгын арга хэмжээ авагдсан 312 алба хаагчийн албан тушаал, нас, хүйсийн байдлыг авч үзвэл хэлтсийн дарга 4 буюу 1.3%, тасгийн дарга 21 буюу 6.7%, ахлах байцаагч 15 буюу 4.8%, офицер 100 буюу 32%, цагдаа 172 буюу 55.1%-ийг тус тус эзэлж байна. Хүйсийн байдлын хувьд 300 буюу 96.1% нь эрэгтэй, 12 буюу 3.8% нь эмэгтэй алба хаагчид эзэлж байна.

Сахилгын зөрчил гаргасан алба хаагчдын гаргасан зөрчлийн хэлбэрийг нь авч үзвэл 144 буюу 47% нь “ажлын хариуцлага алдсан”, 18 буюу 6% нь “ажил тасалсан”, 94 буюу 30% нь “архидан согтуурсан”, 53 буюу 17% нь “бусад” зөрчлүүдийг гаргасан байна.

График №4

Нийт бүртгэгдсэн сахилгын зөрчлийг хэлбэрээр нь авч үзвэл /бүртгэгдсэн 309 зөрчлөөс/



Сахилгын зөрчил гаргасан 312 алба хаагчдын 77 буюу 24.6%-д нь “сануулах”, 137 буюу 44%-д нь “албан тушаалын үндсэн цалингийн хэмжээг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэлх хувиар бууруулах”, 31 буюу 9.9%-д нь “албан тушаал, цол бууруулах”, 67 буюу 21.5%-д нь “албанаас халах” шийтгэл ногдуулсан байна.

Цагдаагийн алба хаагчдын гаргасан сахилгын зөрчлийг илрүүлсэн аргыг нь авч үзвэл 40 буюу 13%-ийг “иргэд, байгууллагын гомдол, мэдээллээр”, 201 буюу 65%-ийг “байгууллагын дотоод хяналт шалгалтаар”, 45 буюу 14.2%-ийг “ёс журмын хяналтаар”, 13 буюу 4.2%-ийг “ЦЕГ-ын Аюулгүй байдлын хэлтэс, ХШДАХ-ээс шилжүүлэн ирүүлсэн мэдээ, мэдээлэл, 10 буюу 3.2%-ийг бусад /гэмт хэрэг, зөрчил шалгах ажиллагаа болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл/ аргаар илрүүлсэн байна.

Ёс зүйн зөрчил, харилцааны асуудлын анхдагч шалтгаан нь бухимдал (стресс), түүнд нөлөөлж буй хүчин зүйлүүд нь ажлын ачаалал их, цалин бага, төлөвлөгдөөгүй гэнэтийн ажилд байнга дайчлагддаг, гэр орны ахуй нөхцөл хүнд, иргэд цагдааг буруугаар ойлгодог, цагдаагийн нэр хүнд унасан, дарга нарын зүй бус харилцаа, шударга бус, ил тод биш байдал, ирээдүйд үл итгэх эргэлзээтэй байдал, ажил хийх хүсэл эрмэлзэлгүй, сонирхолгүй, тодорхой зорилгогүй, өөрийгөө илэрхийлэх, тайлагнах, нөхцөл байдлыг зөв үнэлж дүгнэх чадвар сул, буулт хийх чадваргүй зэргээс шалтгаалж ёс зүйн зөрчил, харилцаа, хандлагатай холбоотой асуудал үүсдэг байна.

Цагдаагийн алба хаагчдын дунд “дээрэлхүү, бүдүүлэг харилцаатай, бусдыг чирэгдүүлж, танил тал хардаг, архидаг согтуурдаг гэх мэт ёс зүй, харилцааны асуудал байна.

Үр дагавар нь цагдаагийн алба хаагч дээрх асуудлаар зөрчил гаргасан учир арга хэмжээ авахуулсан, цалингаа хасуулсан, зарим нь ажлаас халагдсан нь түр зуурын арга юм гэж үзэж байна.


Судалгааны явцад зөрчил гаргасан алба хаагч нартай ярилцлага хийж үзэхэд зөрчил гаргахад нөлөөлсөн хүчин зүйлсийг дараах байдлаар илэрхийлж байна. Үүнд:

1. Бухимдал (стресс)
2. Ажлын ачаалал их,
3. Цалин бага,
4. Төлөвлөгдөөгүй гэнэтийн ажилд байнга дайчлагддаг,
5. Гэр орны ахуй нөхцөл хүнд,
6. Иргэд цагдааг буруугаар ойлгодог, цагдаагийн нэр хүнд унасан,
7. Дарга нарын зүй бус харилцаа, шударга бус, ил тод биш байдал,
8. Ирээдүйд үл итгэх эргэлзээтэй байдал,
9. Ажил хийх хүсэл эрмэлзэлгүй, сонирхолгүй,
10. Зорилго тодорхойгүй, өөрийгөө илэрхийлэх, тайлагнах,
11. Нөхцөл байдлыг зөв үнэлж дүгнэх чадвар сул,
12. Буулт хийх чадваргүй зэрэг хүчин зүйл нөлөөлжээ.

ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны харьяа бүтцийн нэгжүүд болох газар, хэлтсийн 40 алба хаагчдаас гаргасан сахилга, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийхэд өмнөх оны мөн үеэс 15%-аар өссөн байна. Үүнийг графикт оруулан авч үзвэл:


График №5

Харьцуулалт: Сахилгын зөрчил 6 буюу 17.6 хувиар өссөн.



Дээрхи графикаас үзвэл офицерүүдийн гаргасан зөрчил өмнөх оноос 2.3 дахин өссөн нь анхаарал татсан асуудал болж байна. Зөрчил гаргасан алба хаагчдын бүтцийн нэгжийн харьяаллыг графикаар үзүүлбэл:

График №6



Дээрхи графикаас үзвэл Эргүүл хамгаалалтын газрын харьяа нэгжийн алба хаагчдаас илүүтэй зөрчил гаргаж байгаа нь ахлагч бүрэлдэхүүн ихээр үүрэг гүйцэтгэж байгаатай салшгүй холбоотой юм.

Гаргасан зөрчлүүдийн хэлбэрийг авч үзвэл 22 буюу 55% нь “ажлын хариуцлага алдсан”, 14 буюу 35% нь “архидан согтуурсан”, 1 буюу 2% нь “ажил тасалсан”, 3 буюу 8% нь “бусад” зөрчлүүдийг гаргасан байна. Харин алба хаагчдаас гаргасан зөрчилд шийтгэл

оногдуулсан байдлыг авч үзвэл 9 буюу 22%-д нь “сануулах”, 16 буюу 40%-д нь “цалин хасах”, 3 буюу 7%-д нь “цол бууруулах”, 4 буюу 10%-д нь “1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах”, 5 буюу 13%-д “албанаас халах”, 3 буюу 8%-д нь “албан тушаал бууруулах” шийтгэлийг тус тус ногдуулсан байна. Эдгээрийг графикаар үзүүлбэл:

График №7


Хүснэгт №8



Сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагчдын албан тушаал, цолоор нарийвчлан авч үзвэл газрын дарга – 1 буюу 4%, хэлтсийн дарга 2 буюу 8%, тасгийн дарга 4 буюу 10%, ахлах офицер 4, буюу 10%, офицер 10 буюу 25, цагдаа 19 буюу 48% тус тус эзэлж байна.

Зөрчил гаргасан алба хаагчдын цолны байдлыг авч үзвэл 21 буюу 53%-ийг офицер цолтой, 19 буюу 47%-ийг ахлагч бүрэлдэхүүн гаргасан байна. Үүнийг нарийвчлан графикаар оруулж авч үзвэл:

График №9



Нийслэл дэх харьяа нэгжийн алба хаагчдаас 2021 онд гаргасан сахилга, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийхэд Нийслэлийн цагдаагийн удирдах газар болон дүүргүүд дэх цагдаагийн хэлтэс, Төмөр зам дахь цагдаагийн газар, Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг бүхий алба хаагчдаас нийт 127 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 21 буюу 19.8 хувиар өссөн байна.

Сахилгын зөрчилд 71 офицер холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үеэс 14 буюу 24.5 хувиар, 56 ахлагч холбогдсон нь 7 буюу 14.3 хувиар тус тус өссөн байна. Зөрчил гаргасан алба хаагчдыг харьяаллаар нь нарийвчлан авч үзвэл:

Хүснэгт №2

№	Нийслэлийн дүүргүүд	2020 он	2021 он	Өсөлт, бууралт
1	НЦГ	1	3	+2 буюу 2 дахин өссөн
2	БГДЦХ-1	13	6	-7 буюу 53.8 хувиар буурсан
3	БГДЦХ-2	7	7	0
4	БЗДЦХ-1	9	16	+7 буюу 77.7 хувиар өссөн
5	БЗДЦХ-2	8	8	0
6	БЗДЦХ-3	5	9	+4 буюу 80 хувиар өссөн
7	СБДЦХ-1	1	3	+2 буюу 2 дахин өссөн
8	СБДЦХ-2	0	5	5 дахин өссөн
9	СХДЦХ-1	8	3	-5 буюу 62.5 хувиар буурсан
10	СХДЦХ-2	2	5	+3 буюу 1.5 дахин өссөн
11	СХДЦХ-3	10	12	+2 буюу 20 хувиар өссөн
12	ХУДЦХ-1	6	14	+8 буюу 1.3 дахин өссөн
13	ХУДЦХ-2	8	6	-2 буюу 25 хувиар буурсан
14	ЧДЦХ-1	6	6	0
15	ЧДЦХ-2	3	3	0
16	БНДЦХ	7	8	+1 буюу 14.3 хувиар өссөн
17	НДЦХ	11	3	-8 буюу 72.7 хувиар буурсан
18	БХДЦТ	0	0	0
19	Төмөр зам	1	10	+9 буюу 9 дахин өссөн
Нийт		106	127	Нийт 21 буюу 19.8 хувиар өссөн.

Гаргасан нийт 127 зөрчлүүдийн хэлбэрийг авч үзвэл 51 буюу 40% нь “ажлын хариуцлага алдсан”, 39 буюу 31% нь “архидан согтуурсан”, 9 буюу 7% нь “ажил тасалсан”, 28 буюу 22% нь “бусад” зөрчлүүдийг гаргасан байна. Харин алба хаагчдаас гаргасан зөрчилд шийтгэл оногдуулсан байдлыг авч үзвэл 31 буюу 24%-д нь “сануулах”, 54 буюу 34%-д нь “цалин хасах”, 11 буюу 9%-д нь “цол бууруулах”, 31 буюу 24%-д нь “1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах”, 11 буюу 9%-д нь “цол бууруулах” шийтгэлийг тус тус ногдуулсан байна.



Зөрчил гаргасан алба хаагч нарт хүлээлгэсэн сахилгын шийтгэл нь бусад алба хаагч нарт хэрхэн нөлөөлж байгаад судалгаа хийж үзэхгүй, зөвхөн арга хэмжээ авснаар бусад алба хаагч нар үүнд хэрхэн хандаж байгаад анхаарах шаардлагатай байна.

Түүнчлэн алба хаагч нарын гаргасан зөрчлийг үнэн бодитой шалгаж тогтоосон талаар зөрчил гаргасан алба хаагч нараас судалгаа авч үзвэл дотоод хяналт шалгалтын чанар тодорхойлогдох боломжтой гэж үзэж байна. Дээрхи судалгааг графикаар үзүүлбэл:

График №10

Хүснэгт №11

ЗӨРЧЛИЙН ХЭЛБЭР-127



Орон нутаг дахь харьяа нэгжийн алба хаагчдаас гаргасан сахилга, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийхэд нийт 142 зөрчилд 145 алба хаагч холбогдож, хариуцлага хүлээсэн байна. Зөрчил гаргасан тоо мэдээг өмнөх онтой харьцуулан графикаар авч үзвэл:

График №12




График №13



Орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн хэв журмын алба хаагчдын гаргасан зөрчлийг төрлөөр нь авч үзвэл 19 буюу 13% нь “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм зөрчсөн”, 41 буюу 28% нь “Ажлын хариуцлага алдсан”, 42 буюу 29% нь “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм зөрчсөн”, 43 буюу 30% нь “архидан согтуурсан” гэсэн зөрчлүүд байна.


График №14



Гаргасан зөрчлүүдийн хэлбэрийг авч үзвэл 22 буюу 55% нь “ажлын хариуцлага алдсан”, 14 буюу 35% нь “архидан согтуурсан”, 1 буюу 2% нь “ажил тасалсан”, 3 буюу 8% нь “бусад” зөрчлүүдийг гаргасан байна.

Харин алба хаагчдаас гаргасан зөрчилд шийтгэл оногдуулсан байдлыг авч үзвэл 37 буюу 26%-д нь “сануулах”, 16 буюу 40%-д нь “цалин хасах”, 3 буюу 7%-д нь “цол бууруулах”, 4 буюу 10%-д нь “1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах”, 5 буюу 13%-д “албанаас халах”, 3 буюу 8%-д нь “албан тушаал бууруулах” шийтгэлийг тус тус ногдуулсан байна. Эдгээрийг графикаар үзүүлбэл:

График №15



Сахилгын зөрчил гаргасан офицер, ахлагч нарыг өмнөх онтой нь харьцуулан авч үзвэл офицер 11 буюу 26.8%-аар, ахлагч 21 буюу 29.1%-аар тус тус өссөн байна.

График №16



Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий алба хаагчдаас 2021 онд нийт 309 сахилгын зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 56 буюу 22.1 хувиар өссөн.

Үүнээс орон нутагт Хэнтий, Ховд, Дархан-Уул, Дундговь, Архангай, Завхан, Булган, Сүхбаатар, Увс аймгууд 1.5-4.3 дахин, нийслэлд Төмөр зам, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Сонгинохайрхан дүүрэг дэх

цагдаагийн 2 дугаар хэлтэс, Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтэс, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 1, 3 дугаар хэлтсүүд 77.7 хувиас-9 дахин тус тус өсчээ.

Харин Багахангай дүүрэг дэх цагдаагийн хэлтэст сахилга ёс зүйн зөрчил бүртгэгдээгүй, Баянгол дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтэс, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтэс, Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүд 53.8-72.7 хувиар, орон нутагт Орхон, Хөвсгөл, Сэлэнгэ, Дорнод, Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газрууд 33.3-75.0 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байгааг сайшааж байна.

Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагыг дээшлүүлэхийн тулд уламжлалт сургалтын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр дээрх асуудлууд шийдвэрлэгдэхгүй.

Асуудал бүр, өөрөөр хэлбэл ёс зүйн зөрчил, тааламжгүй харилцаа, зохимжгүй үйлдэл болгон усны эх, модны үндэс лугаа дор бүрдээ учир шалтгаантай. Асуудлын шалтгааныг олж илрүүлээд шалтгаанд суурилсан мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх цогц сургалтын хөтөлбөрийг оролцооны аргаар хэрэгжүүлснээр цагдаагийн алба хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагыг дээшлүүлэх боломжтой юм.

Дүгнэлт. Дээрх судалгаан дээр үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдал, үйлдэгдэж буй гэмт хэрэг-зөрчил, ажиллаж байгаа хүн хүчний тоон мэдээ, ажлын ачаалал ойролцоо боловч алба хаагчдын сахилга, ёс зүйн зөрчил, шийтгэлийн тоо харилцан адилгүй байгаа нь шат, шатны удирдах албан тушаалтнууд /газар, хэлтэс, тасаг, хэсгийн дарга, ахлахууд/-ын ажлын арга барил, ажилдаа хандах хандлага, удирдлага-зохион байгуулалт, манлайлал, хяналт шаардлага сул байгаагаар шууд холбоотой гэж үзэж байна.

2. 2021 онд нийт зөрчлийн 8.0 хувь буюу 25 удирдах албан тушаалтан сахилгын шийтгэл хүлээж, тэдний хариуцсан нэгжийн алба хаагчдаас архидан согтуурсан зөрчил 96 буюу өнгөрсөн оноос 35.2 хувиар, ажлын хариуцлага алдсан зөрчил 144 буюу 71.4 хувиар өссөн байгаа нь бие бүрэлдэхүүний ажлын хариуцлага, сахилга-ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр Цагдаагийн төв байгууллагын болон Албаны удирдлагаас удаа дараа хүргүүлж буй үүрэг, ажлын чиглэл, зөвлөмжийг алба хаагч нарт танилцуулж гарын үсэг зуруулах төдийхнөөр хязгаарлаж байгаа нь анхаарал татсан асуудал болжээ.

3. Хэв журмын алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд тавих хяналт шаардлага, хөдөлмөр зохион байгуулалт, алба хаагч нэг бүртэй тулж ажиллах, зааж зааварчлах ажил хангалтгүй явагдаж байна.

4. Ахмад алба хаагчид залгамж үеэ бэлтгэн хүмүүжүүлэх үйл ажиллагаа дутмаг байна.

5. Хяналт шалгалт хийх эрх бүхий албан тушаалтнууд алба хаагчдын зөрчил гаргаад байгаа шалтгаан нөхцөл, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар шалгалтын эцэст дүгнэж бичихгүй, арга хэмжээ авах байдлаар дуусгаж байгаад анхаарлаа хандуулмаар байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Албаны харьяанд явуулж байгаа дотоод, хяналт шалгалтын нэгдсэн цахим бүртгэлийн сантай болох;

2. Жил бүр зөрчил гаргасан алба хаагч нарын шалтгаан нөхцөл, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийг судалж, дараа жилийн зохион байгуулах ажил, арга хэмжээний чиглэлийг тодорхойлж байх;

3. Албаны харьяа нэгжүүд улирал бүр сахилгын хурлыг хийж, гарч болзошгүй хэрэг, зөрчлийн талаар урьдчилан сэргийлэх заавар, зөвлөмж өгч, шадар дарга нарын тавих хяналтыг нэмэгдүүлэх;

4. Албаны харьяаны нэгжийн дарга нар алба хаагч нартай “зөрчил гаргахгүй байх” итгэлийн гэрээ байгуулж, үр дүнг тооцож ажиллах зэрэг саналыг дэвшүүлж байна.

Ашигласан материал

Монгол Улсын хууль:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Төрийн хяналт шалгалтын тухай хууль

Сэтгүүл:

3. Төрийн мэдээлэл. 1992. №1
4. Төрийн мэдээлэл. 2003. №2

Тайлан мэдээ:

5. ЦЕГ-ын НХЖХОНАБХА-ны 2020, 2021 оны тайлан, статистик мэдээ

Цахим эх сурвалж:

6. <https://prezi.com/bj9nwmhbskmn/presentation/>

ЦАГДААГИЙН ЭРГҮҮЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ POLICE PATROL ACTIVITIES AND LEGAL REGULATIONS

Бат-Очирын Сүхбат
ДХИС-ийн АШБС-ийн
магистрант, цагдаагийн ахмад
Svkhbat Bat-Ochir
Graduate student at the University of
Internal Affairs, police captain

Товч агуулга. Монгол Улс ардчилсан зах зээлийн харилцаанд шилжсэн сүүлийн 30 жилд нийгэм, эдийн засаг, улс төр, оюун санаа, хууль эрх зүйн хувьд нэлээд өөрчлөлтүүд

гарсан. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого, чиглэл тодорхой хэмжээгээр өөрчлөгдөж, цагдаагийн байгууллагын зүгээс түүний хэрэгжилт тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, эргүүл, харуулын үйл ажилгааг оновчтой зохион байгуулах арга замыг тодорхойлох, эрдэмтэн судлаачдын үзэл баримтлалыг харьцуулан судалж, холбогдох нэр томъёо, түүний агуулгыг энэхүү өгүүлэлээр авч үзсэн юм.

Abstract: Social, economic, political, spiritual and legal changes have occurred last 30 years in the mongolia. The policy and direction of crime prevention has changed to some extent, and the problem of its implementation has been determined by the police. to improve the way of optimal organization of patrols and guards, to compare the concepts of academics, and to discuss related terminology issues.

Түлхүүр үг: Эргүүл, эрх зүйн үндэс, үйл ажиллагаа, нийгмийн хэв журам, эргүүл, хөдөлгөөнт эргүүл.

Key word: Patrol, legal basis, operations, social order. patrol, car patrol.

Үндсэн хэсэг. Цагдаа гэдэг нь төрөөс хариуцуулсан хууль, нутаг дэвсгэрт хуулийг сахиулах, нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, энэ зорилгоор хүч хэрэглэх эрх хуулиар олгогдсон төрийн төлөөлөгч гэсэн ерөнхий ойлголт байдаг. Үүнийг “*constabulary, gendarmerie, police force, police department, police service, law enforcement agency*” гэх зэргээр янз бүрээр нэрлэж ажилтнуудыг нь “*police officers, troops, sheriffs, constables, rangers, peace officers*” гэх зэргээр нэрлэдэг. Үүнээс “*Police service*” гэдгийг сүүлийн үед манайд хэрэглэж байгаа, “*service*” гэдэг үг нь элдэв янзийн үйлчилгээний утга агуулах боловч үндсэн утга нь засгийн газраас олон нийтийн төлөө бий болгосон тогтолцоог хэлдэг.

Гадаад орнуудын цагдааг ихэвчлэн “*Police service*” гэх зэргээр нэрлэж байгааг хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах алба гэж ойлгох нь зөв болов уу¹¹¹

Хууль зүйн ухааны доктор Д.Таванжин эргүүлийн үйл ажиллагааны талаар нарийвчлан авч үзээгүй боловч нийгмийн дэг журам, нийгмийн хэв журмын ойлголт, олон нийтийн аюулгүй байдлын тухай ойлголт, нийтийн аюулгүй байдлын тухай ойлголт нийгмийн хэв журам хамгаалах салбарыг удирдах удирдлагын ойлголт мөн замын цагдаагийн албаны үйл ажилгаагч гэсэн оруулан авч үзсэн байна.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор Ж.Долгурсүрэн эргүүлийн үйл ажиллагааны талаар авч үзэхдээ нийгмийн хэв журам хамгаалах салбарыг удирдах удирдлагын субъект талаас нь тусгажээ. Үүнээс үзэхэд цагдаагийн эрх зүйн салбарын судлаачид эргүүлийн үйл ажиллагаатай холбоотой тодорхойлолт нарийн гаргаагүй боловч нийгмийн хэв журам хамгаалах зорилгоор эрүүгийн үйл ажиллагааг удирдан, зохион байгуулдаг болох нь ажиглагдаж байна.

Түүнчлэн эргүүл, түүний үйл ажиллагааны төрөл хэлбэрийн талаар Профессор Т.Батсүх “Цагдан сэргийлэхийн сэргийлэн хамгаалах алба” номондоо “Эргүүл гэдэг нь хэв журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх цагдан сэргийлэхийн харуулын үндсэн төрөл юм гэж тодорхойлсон байна.

Хууль зүйн ухааны доктор Г.Ганбаатар “Эргүүлийн үйл ажиллагааг зохион байгуулж байгаа төрлөөс хамаарч дараах ерөнхий байдлаар ангилан авч үзсэн байна. Үүнд:

-Хууль сахиулах байгууллагын эргүүл

-Иргэдийн оролцоот эргүүл

¹¹¹ Хурандаа Д.Эрдэнэбаатарын Өдрийн сонинд өгсөн ярилцлага.

-Аж ахуй нэгж байгууллагын эргүүл

Гудамж талбай олон нийтийн газарт хэв журам сахиулах үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлийн талаарх дуудлага мэдээлэлд шуурхай очих, цагдаагийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүртээмжтэй хүргэх гэмт хэрэг үйлдсэн этгээдийг халуун мөрөөр нь илрүүлэх, таслан зогсоох, баривчлах, хэрэг учралын газрыг хамгаалах зөрчлийг шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг бөгөөд үүнийг цагдаагийн эргүүл гэж нэрлэж болохоор байна.

Цагдаагийн эргүүл, харуулын дүрэмд дараах 4 эргүүлийн нэр томъёоны тодорхойлолтыг тусгасан байна. Үүнд:

-“Цагдаагийн эргүүл” – гудамж, талбай, үйлчилгээний цэг зэрэг олон нийтийн газарт гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам сахиулах зорилгоор ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчийг;

-“Нийтийн хэв журмын эргүүл” Эргүүлийн чиглэлд ажиллах үүрэгтэй эргүүлийг;

-“Хөдөлгөөнт эргүүл” Эргүүлийн хоёр ба түүнээс дээш чиглэлийн хооронд явж ажиллах эргүүлийг;

-“Явуулын эргүүл” Тээврийн хэрэгслээр болон явган аялагчдыг дагаж ажиллах эргүүлийг хэлнэ¹¹²; гэж тодорхойлсон нь үндэстэй байна.

Цагдаагийн эрүүгүүлийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын талаар Монгол улсад Их Монгол улс байгуулагдсан 1189 оноос эхлээд торгон цэрэг, хэвтүүл, харчин турхаг, цагдах цэрэг, “хан хэнтий уулын” “Ойн цагдаа” “Авын цагдаа” “Харчин өртөөний цагдаа” олон хошуудын хилийг харгалзсан тйган буюу цагдаа, Хилийн цагдаа харуул, Олон хошуудын цагдаа, нутгийн цагдаа, савын цагдаа, Тайган, Арван таваны цагдаа гэх мэт нэршилтэйгээр ажиллаж байгаад 1916 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Нийслэл хүрээний тойрон газруудын цагдан сэргийлэх дүрэм хэмжээ”-нд эргүүлийн үйл ажиллагааны талаар тусгахдаа “Манаж сэргийлэх” гэсэн нэр томъёог хэрэглэж эхэлсэн байна. 1920 оны 6 дугаар сард “Хүрээний цагдан цээрлүүлэх хорооны тухай хуульд манаж сэргийлэгч гэсэн утга илэрхийллийг “цагдагч” гэсэн нэр томъёогоор сольсон байна.

1923 онд 6 дугаар сарын 26-ны өдрийн “Нийслэл хүрээний цагдан сэргийлэх хорооны дүрэм хэмжээ” цагдагч гэсэн нэршилийг “цагдан сэргийлэх” болгон өөрчилж цагдан сэргийлэх гэсэн нэршилтэйгээр эргүүлийн үйл ажиллагаа явуулдаг байсан байна. Мөн 1926 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн “БНМАУ-ын Цагдан сэргийлэх газрын дүрэм” 1928 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн “Цагдан сэргийлэх газрын дүрэм” 1934 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “БНМАУ-ын Цагдан сэргийлэх тухай дүрэм” 1942 оны 4 дүгээр сарын Дотоод явдлын яамны харъяа улсын цагдан сэргийлэх газрын дүрэм, 1955 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн “БНМАУ-ын Дотоод явдлын яамны харъяа Улсын цагдан сэргийлэх байгууллагын дүрэм” 1963 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн “БНМАУ-ын цагдан сэргийлэх байгууллагын дүрэм” 1985 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн “БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын дүрэмд тус тус “Цагдан сэргийлэх” гэдэг атга агуулагаар яву байгаад 1993 оны Цагдаагийн байгууллагын тухай хуулиаар “Цагдаа” гэсэн нэршилээр хэв журам сахиулж эхэлсэн бол 2014 оноос хууль сахиулагч гэсэн нэрээр нэрлэгдэх болсон ч 2017 оны Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулж, цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлыг шинэчлэн тогтоож эрх зүйн шинэчлэл хийсэн.¹¹³

¹¹² Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 01 сарын 22-ны өдрийн 34 дүгээр тушаалаар батлагдсан эргүүл харуулын дүрэм.

¹¹³ Д.Таванжин Монгол улсын цагдаагийн эрх зүй. Уб., 2007. 85 дахь тал

Цагдаагийн эргүүлийн үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь Монгол Улсын Үндсэн хуулиас эхтэй ба Монгол Улсын Үндсэн хуулийн 11-р зүйлд “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”¹¹⁴ 38 дугаар зүйлд “Засгийн газар нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ” гэж заажээ. Өөрөөр хэлбэл Монгол Улсын төр иргэдийнхээ өмнө гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг хүлээж байгаа юм.

Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-т “Гудамж талбай болон нийтийн эзэмшлийн бусад газарт эргүүл хийх” гэж заасан. Харин “Цагдаагийн эргүүл, харуулын дүрэм”-д Цагдаагийн алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх нийгмийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэнэ гэжээ.

Цагдаагийн эргүүл харуулын дүрмийн 1-р зүйл “Цагдаагийн алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэхдээ холбогдсон харилцааг энэхүү дүрмээр зохицуулна гэж заажээ.

Цагдаагийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйл “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн” гэж тодорхойлсон нь эргүүлийн үйл ажилгааны гүйцэтгэх үүргийн эрх зүйн эх сурвалжийг тодорхойлж байна.¹¹⁵

Цагдаагийн албаны тухай тухай хуулийн дараах зүйл заалтууд нь эргүүл үүрэг гүйцэтгэх алба хаагчийн гүйцэтгэх үүргийг тодорхойлж байна. Тухайлбал: 10 дугаар зүйл /Гэмт хэрэгтэй тэмцэх/-ийн 10.1.1, 10.1.2, 10.1.3, 10.1.7, 10.1.8, 10.1.9% 11 дүгээр зүйл /Нийтийн хэв журам хамгаалах/-ийн 12.1.3, 12.1.5 зэрэг нийт 3 зүйл, 13 заалт нь эргүүлийн гүйцэтгэх үүргийг тодорхойлж байна.

Цагдаагийн албаны тухай хуульд заасан цагдаагийн эргүүлийн офицерийн гүйцэтгэх үүргүүдийг агуулгаар нь багцлан авч үзье. Үүнд:

- Зөрчлийн талаархи гомдол мэдээллийг хүлээн авах, бүртгэх хуулиар харъяалуулсан зөрчлийг шалгаж шийдвэрлэх, байгууллага, алба хаагчийг мэдээллээр хангах.

- Гудамж талбай олон нийтийн эзэмшлийн бусад газарт эргүүл хийх, байнгын болон түр ажиллагаатай хянаж-нэвтрүүлэх цаг ажиллуулах дууны, дүрсний бичлэг, бусад арга техник хэрэгсэл ашиглан хяналт тавих.

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах.

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах

- Гэрээт харуулын болон хувийн хамгаалалтын үйл ажилгаанд хяналт тавих, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах.

- Хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад илэрсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулах, тэдгээрийг гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн , хуулийн этгээдэд шаардлага, сэрэмжлүүлэг өгөх, биелэлтийг нь хангуулах.

- Олон нийтийн цагдаа нартай хамтран ажиллах, мэргэжил, арга зүйгээр хангах.

- Гэмт хэрэг, зөрчлийн талаарх шаардлагатай мэдээ, мэдээллийг төлбөртэй авах.

- Нөхцөл байдал хүндэрсэн үед дэг журам сахиулах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх бүх талын арга хэмжээ авах.

- Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагааг гүйцэтгэх.

¹¹⁴ Монгол Улсын үндсэн хууль. УБ., 1992 он

¹¹⁵ Цагдаагийн албаны тухай хууль.УБ., 2017 он

- Гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон аюул үүссэн үед хорио цээрийн дэглэмийг сахиулах, амь нас, эрүүл мэнд нь онц аюултай нөхцөлд байгаа хүнд тусламж үзүүлэх.

- Шаардлагатай тохиолдолд улсын онц чухал болон хүний амь нас, эрүүл мэнд, байгаль, экологийн тэнцвэрт байдалд шууд хохирол учруулах эрсдэлтэй болон гэмт халдлагад өртөж болзошгүй бусад объект, ачаа тээшийг түр хугацаагаар хамгаалах.

- Нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал, цуглааны үеийн хамгаалалт хийх.¹¹⁶ ЦЕГ-ын газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/264 дүгээр тушаалаар батлагдсан “Эргүүлийн үүрэг гүйцэтгэх журам” (код 401) дээр эргүүлийн үүрэг гүйцэтгэх алба хаагчид үүрэг гүйцэтгэхээр зохицуулсан агуулгыг авч үзье. Үүнд:

— Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилсан сэргийлэх, тэслэн зогсоох, илрүүлэх, хэв журам сахиулах.

— Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын талаар биечилсэн судалгаа хийж, эргүүлийн чиглэлийн орчинд хяналт тавьж ажиллах.

— Гэмт хэрэг, зөрчлийн талаар иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авч, шуурхай арга хэмжээ авах.

— Иргэнд тусламж, туслалцаа үзүүлэх.

— Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг саатуулах, баривчлах.

— Зөрчил шалган шийдвэрлэх, хойшлуулшгүй ажиллагаа явуулах.

— Үүрэг гүйцэтгэхдээ дүрэм журам баримтлах.

— Шаардлагатай тохиолдолд албадлага хэрэглэх.

— Хийсэн ажлаа холбогдох албан тушаалтанд танилцуулах, бүртгэл, тооцоо, хийх.

ЦЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/264 дүгээр тушаалаар батлагдсан “Авто эргүүл ажиллах журам” /код 402/ дээр машинтайгаар хөдөлгөөнт эргүүлийн үүрэг гүйцэтгэх үйл ажиллагааны талаар зохицуулсан бөгөөд үүрэг гүйцэтгэх алба хаагчдад тогтоосон чиглэлийг зөвшөөрөлгүй, дур мэдэн орхих, жолоогоо бусдад шилжүүлэх, галт зэвсгийг задлах, сумлах, зэргээр оролдох зэрэг 9 зүйлийг хориглсон байна¹¹⁷.

Дээрх журмаар эргүүлийн офицерийн гүйцэтгэх нийтлэг үүргээс гадна автомашинтай харьцахтай холбоотой онцлог үүргүүдийг нэмж тусгасан байна.

“Морь эргүүлийн үүрэг гүйцэтгэх журам” /код 403/-ийн 403.7-1 Цагдаагийн алба хаагч нь морьт эргүүлийн үүрэг гүйцэтгэхэд дараах үүрэг хүлээнэ гэж заасан байна. Тухайлбал:

— Өөрийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, албаны морь унаж гэмт этгээдийг баривчлах, эрэн сурвалжлах, гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хэргийн газрын хамгаалалт хийх зэрэг арга зүйд суралцах.

— Албан үүргээ гүйцэтгэж байх үедээ санаачилгатай, тэвчээртэй, хатуужилтай байх.

— Морины зуршил, зан авирыг судалж мэдсэн байх, түүнийг арчлах мэдлэг эзэмшсэн байх.

— Морины тоног хэрэгслийг шалгах, эмээллэж, хазаарлаж сурсан байх.

— Цаг агаарын болон газар орны ямар ч нөхцөлд морь унаж, хэрэглэх чадвар эзэмшсэн байх.

¹¹⁶ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам

¹¹⁷ ЦЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/264 дүгээр тушаалаар батлагдсан “Авто эргүүл ажиллах журам”

- Мориор байгалийн болон бий болсон бартаа саадыг туулж чаддаг байх, морины чадлыг тооцож, гамнаж байх.
- Морьтой харьцахдаа аюулгүй байдлыг сахих.
- Адууны өвчний шинж тэмдгийг мэдэх, шаардлагатай үед анхны тусламж үзүүлэх чадвартай байх.
- Тоног хэрэгслийг цэвэрлэж, арьсан болон төмөр хэсгийг цаг тухайд нь тосолж хуурайшилтаас сэргийлэх, жижиг засварыг хийж байх.
- Үүрэг гүйцэтгэх үед албаны мориор бусдыг гэмтээхээс сэргийлэх гэх мэтээр тусгасан байна.¹¹⁸

Эргүүлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар

Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээ-2017 судалгааны тайлангаас үзвэл Мөн судалгаанд оролцогчидын 56.3 хувь нь эргүүлийн үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдаар үйлчлүүлж тухай бүр асуудлаа шийдвэрлүүлж тусламж авах хүсэлтэй байдаг нь ажиглагдаж байна. Иймд эргүүлийн үйлчилгээг хүртээмжтэй түргэн шуурхай хүргэх, оновчтой зөв зохион байгуулах шаардлага гарч байна.

Мөн хөдөлгөөнт эргүүлийг нэг цэгт зогсоох, дуудлага гараагүй үед сул зогсох нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх түүний үр дүнг бууруулах хүчин зүйл болж байна. Түүнчлэн гудамж талбайд эргүүл хийж сэжигтэй хүн, объектыг хяналтандаа авах ажил хийгдэхгүй байгаагаас шалтгаалж гэмт этгээд, гэмт хэрэг зөрчилд холбогдож болзошгүй этгээдүүдэд хяналт тавьж тэднийг хяналтандаа байлгаж чадахгүй байна гэж бид үзлээ.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 54 хувь нь эргүүлийн үйл ажиллагаа доголдолтой, хоцрогдолтой, ажил үйлчилгээг нь сайжруулах ёстой гэж дүгнэсэн нь эргүүлийн үйл ажиллагаа хараахан иргэдийн сэтгэлд хүрч чадаагүй байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2016 оны 2-р сарын 19 дүгээр тогтоолоор Монгол Улсын Тогтвортой хөгжлийн бодлогын баримт бичгийг баталсан бөгөөд уг Бодлогын баримт бичгийн 7 дугаар зорилтод: «мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөх, орон нутагт өндөр хурдны сүлжээг нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх ...» -ээр заасан байна. Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5-р сарын 13-ний өдрийн 52 дугаар тогтоолоор Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталсан бөгөөд уг Бодлогын баримт бичгийн 7.4.2-д «салбарын үйл ажиллагаанд шинжлэх ухааны өндөр түвшний технологийг нэвтрүүлэх бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож, судалгаа, шинжилгээний баазыг бэхжүүлэх, эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем болон оюуны өмчийн эрхийн хамгаалалтын системд хиймэл оюун ухаанд суурилсан технологи нэвтэрсэн байна» хэмээн заасан нь эргүүлийн үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт амжилтанд тулгуурлан хөгжүүлэх эрх зүйн үндэс болсон юм.

Үүний үр дүнд гудамж талбайд үйлдэгдэж буй гэмт хэргийн нөхцөл байдлыг тодорхойлоход ArcMap, ArcGIS газарзүйн программ, ASAP, TPS мэдээллийг ашиглах, цагдаагийн байгууллагын system.police.gov цахим сүлжээнд мэдээлэл байршуулах, солилцох, мэдээлэл, холбоо, технологийн үйлчилгээг цагдаагийн алба хаагчид түүний дотор авто эргүүлийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн нь Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологи нэвтрүүлж ашиглах бодлогыг хэрэгжүүлж буй хэлбэр юм.

¹¹⁸ ЦЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/264 дүгээр тушаалаар батлагдсан “Морь эргүүлийн үүрэг гүйцэтгэх журам”

Түүнчлэн нийслэл хотын хэмжээнд ашиглагдаж байгаа камеруудын хэвийн үйл ажиллагааг хангаж, гэмт хэргийн хяналтын цогц системтэй уялдуулан камерын хяналтын үйл ажиллагааг боловсронгуй болгож, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, гудамж талбайг хянах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналтын камерын удирдлагын нэгдсэн төв байгуулах, цахим эргүүлийн үйл ажиллагааг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлагыг бид орхигдуулж болохгүй.

Мөн цагдаагийн байгууллагын уламжлалт эргүүлийн нэг хэлбэр морьт эргүүлийн үйл ажиллагааг тогтмолжуулж морьдыг шаардлагатай тохиолдолд хотын захаас авчирдаг байдлыг зогсоож, явган болон машинт эргүүл ажиллахад хүндрэлтэй гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг Туул, Сэлбэ голын ай саваар болон шаардлагатай газар байршлуудад байнгын ажиллуулах шаардлагатай.

Цагдаагийн эргүүлийг батлагдсан чиглэлд урт хугацаагаар, байнгын давтамжтайгаар ажиллуулах, нийтийг хамарсан арга хэмжээний үеэр зохион байгуулагдах хамгаалалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд цагдаагийн эргүүлийн алба хаагчдын хүрэлцээ муу байгааг харгалзан үзэж, цагдаагийн орон тооны асуудлыг тодорхой хэмжээгээр шийдвэрлэх нь зүйтэй болов уу?

Түүнчлэн хөдөлгөөнт эргүүлийн (машинт эргүүлийн) хариуцан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ нь 6-8 км байхаар эргүүл харуулын дүрэмд зааж өгсөн байдаг ч өнөөдөр нэг машинт эргүүл зарим чиглэлд 10 км түүнээс ч илүү газар нутаг хариуцан үүр гүйцэтгэж байгааг анхаарч бүх чиглэлд машинт эргүүлийн газар нутгийн хэмжээг гэмт хэрэг, зөрчлийн байдлыг харгалзан адил хэмжээтэй тогтоож ачаалалыг тэнцвэржүүлэх хэрэгтэй байна.

Эргүүлийн нэгдсэн байршилтыг тухайн цагдаагийн газар хэлтсийн дарга жилд хоёр удаа батлаж байгаа нь эргүүлийн нэгдсэн байшилт нь өвлийн болон зуны улирлын гэсэн хоёр хэлбэртэй байгаа нь цаг үеэсээ хоцорсон, нөхцөл байдалд тохирохгүй байгааг өөрчлөх, машинт эргүүлд хариуцуулан өгөх эргүүлийн чиглэлийг гудамж тайлбайн гүнд оруулах, эргүүлийн чиглэлийг километр газар бус радиус газар болгон өөрчлөх, машинт эргүүлийг нэг цэгт зогсоох бус хариуцсан нутаг дэвсгэртээ байгууллага, аж ахуйн нэгж, иргэд хууль тогтоомжийг хэрхэн сахин биелүүлж байгаад хяналт тавьж хөдөлгөөнтэйгээр явж эргүүлийн үүрэг гүйцэтгэдэг олон улсын жишигт нийцүүлэх шаардлагатай байгааг анхаарах хэрэгтэй.

Дүгнэлт. Дээр дурдсан хууль тогтоомж, эрх зүйн бусад актаас үзвэл цагдаагийн байгууллагаас эргүүлийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэс тодорхой хэмжээнд хуульчлагдсан гэж дүгнэж болохоор байна.

Эргүүлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох нь цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээг иргэдэд ойртуулах нэг чухал нөхцлийн нэг бөгөөд гудамж талбайд эргүүл хийж ажилласнаар тухайн дүүрэг хороонд үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчлийн дуудлаганд түргэн шуурхай очих, улмаар гэмт үйлдлийг таслан зогсоох, гэмт этгээдийг мөрдөн хөөж баривчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг халуун мөрөөр нь илрүүлэх, гэмт хэрэг зөрчил үйлдэж болзошгүй сэжигтэй этгээдүүдийг хянах, гудамж талбайг хяналтандаа авах зэрэг ач холбогдолтой гэж дүгнэж болох юм.

Санал. Дээрх дүгнэлтийг үндэслэн судлаач бид дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтыг орчин цагийн нөхцөл байдалд тохируулан шинэчлэх;
2. Цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагаанд иргэд, олон нийтийг татан оролцуулж, гарах үр дүн, хүртээмжийг нэмэгдүүлэх;

3. Эргүүлийн үйл ажиллагаанд орчин үеийн техникийн дэвшилтэт технологийг өргөнөөр нэвтрүүлэх;
4. Эргүүлийн үйл ажиллагааг нөхцөл байдалд тохируулан төрөлжүүлэх, эргүүлийн чиглэлийг нэмэгдүүлэх;
5. Авто эргүүлийн машин, орчин үеийн тусгай хэрэгсэл, техник, технологиор эргүүлийн үйл ажиллагааг хангах;
6. Гадаад улс орнуудын цагдаагийн байгууллагуудад өргөнөөр ашиглагддаг ArcGIS газар зүйн мэдээллийн системд суурилсан «Гэмт хэргийн цахим зураглал»-ыг эргүүлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх зэрэг санал дэвшүүлж байна.

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992.
2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. 2019.
3. Монгол Улсын Байгууллагын нууцын тухай хууль. 1995.
4. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль. 2021.
5. Цагдаагийн албаны тухай хууль. 2017.
6. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь.-Уб., 2013 он
7. А.Алтангэрэл. Англи-Монгол толь бичиг. Уб.-2005 он
8. Д.Таванжин. Монгол улсын цагдаагийн эрх зүй. Уб.- 2007 он
9. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. 2018
10. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 01 сарын 22-ны өдрийн 34 дүгээр тушаалаар батлагдсан эргүүл харуулын дүрэм.

Цахим эх сурвалж

1. <https://en.wikipedia.org>
2. <https://police.gov.mn/a/2735>
3. <https://www.slideshare.net/ELPCOEastLibertyPark/june-2017-slc-pd-compstat-report>
4. https://www1.nyc.gov/assets/nypd/downloads/pdf/crime_statistics/cs-en-us-city.pdf
5. <https://www1.nyc.gov/site/nypd/stats/crime-statistics/citywide-crime-stats.page>
6. <https://www.ojp.gov/ncjrs/virtual-library/abstracts/compstat-process-managing->

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛД ЯВГАН ЗОРЧИГЧ ӨРТӨЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА ОЛОН НИЙТИЙН ХАНДЛАГА A PEDESTRIAN IS INJURED IN A ROAD VEHICLE ACCIDENT CURRENT SITUATION AND PUBLIC ATTITUDES

Г.Бат-Эрдэнэ
ДХИС-ийн магистрант,
цагдаагийн ахлах дэслэгч
G.Bat-erdene - student,
University of Law Enforcement,
police chief lieutenant

Хураангуй. Цагдаагийн байгууллагаас замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослыг бууруулах чиглэлээр Засгийн газрын 128 дугаар тогтоолоор батлагдсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн гаргасан төлөвлөгөө, Монгол улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанаас гаргасан төлөвлөгөөг удирдлага болгон төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоотойгоор ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулж байна. Гэвч зам тээврийн осолд явган зорчигч өртөх явдал буурахгүй байгаа нь тулгамдсан асуудал болоод байна.

Энэхүү өгүүлэлд замын хөдөлгөөнд оролцогч явган зорчигчийн зам тээврийн осол, зөрчилд хэрхэн өртөж байгаа байдалд олон нийтийн зүгээс хэрхэн хандаж байгаа, учир шалтгааныг юу гэж үзэж байгаа болон урьдчилан сэргийлэх арга замын талаар гаргаж буй санаа бодлын талаар товч авч үзсэн болно.

No summary. The plan issued by the National Road Safety Council approved by Government Resolution No. 128 in order to ensure road safety by the police and reduce road traffic accidents, and the plan issued by the Office of the Council for the Coordination of Crime Prevention in Mongolia are managed by governmental and non-governmental organizations and organizations. The works are being organized in stages with the participation of enterprises and citizens. However, the fact that pedestrians are affected by traffic accidents is not decreasing, which is a pressing problem.

This article briefly discusses how the public reacts to the road traffic accidents and violations of pedestrians participating in the traffic, what they believe to be the cause, and the ideas put forth about preventive measures.

Түлхүүр үг. Замын хөдөлгөөн, явган зорчигч, зам тээврийн осол, гарц, дохио, явган хүний зам, тээврийн хэрэгсэл, автомашин

Key word. Traffic, Pedestrians, Traffic Accidents, Crossings, Signals, Footpaths, Vehicles, Cars

Оршил. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан судалгаагаар жил бүр 1.2 сая хүн зам тээврийн ослоор нас барж, 50 сая хүн хөгжлийн бэрхшээлтэй болох төлөвтэй байна гэсэн үр дүн гарсан байна.

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн ослын 88.5 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Нийт явган зорчигчийн буруутай үйлдлээс бүртгэгдсэн ослын 32.9 хувийг явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцсоны улмаас, мөн сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүй замын хөдөлгөөнд оролцуулсанаас болсон осол 7.3 хувийг эзэлж байна.

Явган зорчигчийн буруутай үйлдлээс гарах осол дараах шалтгаантай байдаг. Үүнд:

- Явган хүний гарцын шугам, гарамгүй газраар зам хөндлөн гарах,
- Гэрлэн дохио зөрчиж зам хөндлөн гарах,
- Ойртон ирж яваа тээврийн хэрэгслийн урдуур зам хөндлөн гүйх
- Зогсож буй автомашины урдуур буюу автобуснаас буугаад урдуур нь замын зорчих хэсэгт орох,
- Замын зорчих хэсэг дээр буюу зорчих хэсгийн захаар дагаж явах,

- Согтууруулах ундааны зүйл хэрэглэж биеэ авч явах чадваргүй үедээ замын зорчих хэсгээр явах, хэвтэх,
- Замын голоор тавьсан тусгаарлах хайс, хашлага дээгүүр давах, доогуур нь шургах,
- Замын хөдөлгөөнд оролцохдоо анхаарал болгоомжгүй оролцох /зам хөндлөн гарахдаа гар утсаар ярих, захиа бичих, чихэвчний хөгжим сонсох/,
- Сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулах /Эцэг, эх, асран хамгаалагчийн буруугаас/ зэргээс автомашинд дайрагдах, мөргөгдөх¹¹⁹ зэрэг болно.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 3.1.11-д “явган зорчигч” гэж замаар явган яваа /зам дээр ажил үүрэг гүйцэтгэж яваагаас бусад/ хүн, жагсаалаар яваа болон хөгжлийн бэрхшээлтэй хүний тэргэнцэртэй, түүнчлэн тэрэг түрж, чарга чирж, мотоцикл, мопед, унадаг дугуйг хөтөлж замаар яваа хүнийг. Харин замын хөдөлгөөнд оролцогч, 3.1.7-л “замын хөдөлгөөнд оролцогч” гэж замаар явж байгаа жолооч, тээврийн хэрэгслээр зорчигч, явган зорчигчийг”¹²⁰ ойлгохоор тус тус заажээ.

Замын нөхцлөөс гарах ослын голлох шалтгааныг дараах байдлаас үүдэлтэй гэж үздэг байна. Үүнд:

- Замын гадаргуу, нөхцөл;
- Замын гэрэлтүүлэг;
- Замын тэмдэг, тэмдэглэгээ ойлгомжгүй байх.

Замын нөхцлөөс шалтгаалан гарсан ослын 59.1 хувь нь Улаанбаатар хотод, 40.9 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна. Замын эвдрэл, гэмтэл нь Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж, зам тээврийн осол гарах шалтгаан нөхцлүүдийн нэг болдог байна.

Түүнчлэн урин дулааны цаг эхэлсэнтэй холбогдуулаад бага насны хүүхэд зам тээврийн осолд их өртдөг. Энэ нь цаг агаар дулаарч, эцэг эхчүүд хүүхдээ хараа хяналтгүй гадаа талбайд гаргаснаас үүдэлтэй бөгөөд орон сууц болон гэр хороолол дундах зам талбайд хүүхдүүд хөөцөлдөж тоглоон гэмтэж, бэртэх нь ихэсдэг.

Мөн өсвөр насны хүүхдүүд цахилгаан скүүтэр, унадаг дугуйтай төв зам дээр хөдөлгөөнд оролцож явган зорчигч мөргөх, тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх зэрэг зөрчлүүд гаргаж байна. Цахилгаан скүүтэрийг 14 хүртэлх насны хүүхэд унаж замын хөдөлгөөнд оролцож болохгүй, 14-өөс дээш насныхан цахилгаан скүүтэртэй зориулалтын замаар буюу унадаг дугуйн замаар зорчих явдал бөгөөд энэ төрлийн осол бүртгэгдэх гол шалтгаан нь цахилгаан скүүтэртэй автомашины зам руу орсноос үүдэлтэй байна.¹²¹

Явган зорчигч зам тээврийн осолд өртөж, амь нас, эрүүл мэнд, эд материалаараа хохирох явдал буурахгүй байгаад шинжилгээ хийх зорилгоор түүврийн аргаар 153 иргэнээс анкет асуулгын аргаар судалгаа авч дүн шинжилгээ хийхийг чармайлаа.


Судалгаанд хамрагдсан иргэдийн 13 буюу 8.5% нь 18-24 насны, 16 буюу 10,5% нь 25-29 насны, 58 буюу 37.9 хувь нь 30-34 насны, 19 буюу 12.4% нь 35-39 насны, 23 буюу 15% нь 40-45 насны, 15 буюу 9.8% нь 45-49 насны, 8 буюу 5.2% нь 50-54 насны, 1 буюу 0.7% нь 55-аас дээш насны иргэд байна. Судалгаанд оролцсон иргэдийн хүйсийн байдлыг графикаар авч үзвэл:

График №1

¹¹⁹ Зам тээврийн ослын өнөөгийн байдал. УБ. 2017. 8 дахь тал

¹²⁰ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2015 он, №28. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль


¹²¹ <https://mpress.mn/p/7874>



Боловсролын байдлыг нь авч үзвэл 87 буюу 56.9% нь “дээд”, 49 буюу 32% нь “бүрэн дунд”, 9 буюу 5.9% нь “тусгай дунд”, 7 буюу 4.6% нь “бүрэн бус дунд”, 1 буюу 0.7% нь “бага” боловсролтой иргэд байна.

Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл 42 буюу 27% нь “төрийн байгууллага”, 13 буюу 8% нь “төрийн бус байгууллага”, 20 буюу 13% нь “хувийн аж ахуйн нэгж”, 70 буюу 46% нь “хувьцаат компани”, 4 буюу 3% нь “хувиараа хөдөлмөр эрхэлдэг”, 4 буюу 3% нь “ажилгүй” иргэд эзэлж байна. Үүнийг графикаар үзүүлбэл:

График №2



Судалгаанд оролцогчдоос хувийн автомашин байгаа эсэхийг тодруулахад 55 буюу 35.9% нь “байгаа”, 98 буу 64.1% нь “байхгүй” гэсэн хариултыг тус тус өгсөн байна.

Судалгаанд оролцогчдоос “Улаанбаатар хотод явган зорчигч замын хөдөлгөөнд оролцох боломж хэр бүрдсэн гэж та үздэг вэ ?” гэсэн асуултад 10 буюу 6% нь “бүрдсэн”, 61 буюу 40% “бүрдээгүй”, 82 буюу 54% нь “тодорхой хэсэг нь бүрдсэн” хэмээн хариулт өгсөн байна. Хариултыг графикт оруулан авч үзвэл:

График №3



“Та явганаар замын хөдөлгөөнд өдөр бүр оролцдог уу ?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 114 буюу 74.5% нь “тийм”, 39 буюу 25.5% нь “үгүй” гэсэн хариултыг тус тус өгсөн байна.

Энэ нь нийслэл хотын замын түгжрэл их байгаатай холбогдуулан иргэд ойрхон, машингүй явчих боломжтой газруудад явганаар явж, замын хөдөлгөөнд оролцож байгаатай холбон үзэж болохоор байна.

Судалгаанд оролцогчдоос “Явганаар та замын хөдөлгөөнд оролцохдоо зам тээврийн осол, зөрчилд өртөж байсан уу?” гэсэн асуултад 21 буюу 13.7% нь “тийм, осолд өртөж байсан”, 132 буюу 86.3% нь “үгүй” гэсэн хариултыг өгчээ.


Судалгаанд оролцогчдоос “Явган зорчигч замын хөдөлгөөнд оролцохдоо осол, зөрчилд өртөхөд юу нөлөөлдөг гэж та үзэж байна вэ?” гэсэн асуултад 22 буюу 18.5% нь “замын түгжрэл их байгаа”, 38 буюу 31.9% нь “Явган зорчигч хөдөлгөөнд оролцох орчин нөхцөл бүрдээгүй”, 57 буюу 47.9% нь “Жолооч нар хөдөлгөөнд оролцохдоо Замын хөдөлгөөний дүрэм баримталдаггүй, соёлгүй оролцдог”, 61 буюу 51.3% нь “Явган зорчигчид замын хөдөлгөөний дүрэм баримталж хөдөлгөөнд оролцдоггүй”, 28 буюу 23.5% нь “Явган зорчигчийн хууль, эрх зүйн мэдлэг дутмаг”, 29 буюу 24.4% нь “Явган зорчигчийн суурь хүмүүжил, ёс суртахуунгүй байдал,” 34 буюу 28.6% нь “Явган зорчигчийн замын хөдөлгөөнд оролцохдоо “амжина” гэж хөнгөмсөгөөр найддаг хайхрамжгүй байдал”, 7 буюу 5.9% нь “Явган зорчигч хөдөлгөөнд оролцох хууль эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй байдал”, 20 буюу 16.8% нь “Улаанбаатар хотын автомашины нягтаршил их болсон”, 20 буюу 16.8% “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого оновчгүй байгаа” , 18 буюу 15.1% нь “Замын хөдөлгөөн зохицуулалтын төлөвлөлт шаардлага хангахгүй байгаа” гэсэн хариултыг тус тус өгчээ. Энэхүү судалгаанд 1 оролцогч 3 хүртэлх хариултыг сонгон авч бөглөж болохоор тохируулж авсан болно.

Судалгаанд оролцогчдын өгсөн хариултыг графикаар оруулан харуулбал:

График №4

Явган зорчигч замын хөдөлгөөнд оролцохдоо осол, зөрчилд өртөхөд юу нөлөөлдөг гэж та үзэж байна вэ?

119 responses



Судалгаанд оролцогч иргэд “Явган зорчигч замын хөдөлгөөний осол, зөрчил өртөхөд хувь иргэний суурь хүмүүжил нөлөөлдөг гэж та үздэг үү? гэсэн асуултад 70 буюу 45.8% нь “тийм”, 14 буюу 9.2% нь “үгүй”, 69 буюу 45.1% нь “зарим тохиолдолд” гэсэн хариултуудыг өгсөн байна.

Эндээс харахад замын хөдөлгөөнд явганаар оролцож байгаа иргэдийн суурь хүмүүжил, сахилга, ёс зүйн байдал осол өртөхөд ихээхэн нөлөөлсөн гэж үзэхэд хүргэж байна.

“Явган зорчигчоос шалтгаалсан зам тээврийн осол, зөрчлийг бууруулахад ямар арга хэмжээ авбал оновчтой гэж та үзэж байна вэ? гэсэн асуултыг судалгаанд оролцогчдод тавихад 76 буюу 63.9% нь “Явган зорчигчдод зориулсан замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай эрх зүйн мэдлэг олгох сургалтыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан үе шаттай цуврал болгон явуулах”, 21 буюу 17.6% нь “Явган зорчигчоос шалтгаалсан зам тээврийн осол, зөрчил гаргах болсон шалтгааны судалж, арилгах арга хэмжээ авах”, 36 буюу 30.3% нь “Явган зорчигчоос шалтгаалсан зам тээврийн осол, зөрчилд хүлээлгэх хариуцлагыг чангатгах”, 23 буюу 19.3% нь “Замын хөдөлгөөнд явган зорчигчийн оролцох хэсэг бүрт камерын хяналт тавих”, 17 буюу 14.3% нь “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, түгжрэл, нягтралыг бууруулах чиглэлээр төрийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх”, 16 буюу 13.4% нь “Замын хөдөлгөөнд оролцогчдод тавих камерын хяналтыг сайжруулах”, 16 буюу 13.4% нь “Замын хөдөлгөөний осол, зөрчил гаргасан жолооч нарт ёс зүйн хандлагыг өөрчлөх сургалтад хамруулах”, 17 буюу 14.3% “Явган зорчигчоос шалтгаалсан зам тээврийн осол, зөрчлийг бууруулах аян зохион байгуулах”, 31 буюу 26.1% нь “Явган зорчигчоос шалтгаалсан зам тээврийн осол, зөрчлийг бууруулах чиглэлээр гадаадын зарим оронд амжилттай хэрэгжсэн туршлагуудыг судалж, өөрийн оронд нэвтрүүлэх” гэсэн хариултуудыг өгсөн байна. Харин нээлттэй саналыг тус бүр 1 хүн бичиж ирүүлсэн байна. Тухайлбал:


- Явган зорчигчдод зориулсан гарцыг нэмэх
- Явган зорчигчдын ухамсарыг нэмэгдүүлэх ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Гүүрэн гарц, нүхэн гарц нэмж байгуулах
- Замын хөдөлгөөнд оролцогчдод зориулсан цахим сургалтыг зохион байгуулах зэрэг болно.

График №5

Явган зорчигчоос шалтгаалсан зам тээврийн осол, зөрчлийг бууруулахад ямар арга хэмжээ авбал оновчтой гэж та үзэж байна вэ?



119 responses



Дээрхи графикт тусгагдсан хариултыг 3 хүртэлх давхардуулан сонгож болох зохицуулалтыг хийж авсан болохоор хариулт харьцангуй өндөр гарч байна.

Судалгаанд оролцогчдын дийлэнхи иргэд нь явган зорчигчдоод зориулсан замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай эрх зүйн мэдлэг олгох сургалтыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан үе шаттай цуврал болгон явуулах гэсэн хариултыг сонгосон байна. Энэ нь замын хөдөлгөөнд явганаар оролцогч иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлсэнээр зам тээврийн осолд өртөх явдал буурах боломжтой юм гэж иргэд үзэж байгаатай салшгүй холбоотой юм.


“Та явган зорчигчоос шалтгаалсан зам тээврийн осол, зөрчлийг бууруулахад ямар байгууллагын үүрэг оролцоо чухал гэж та үзэж байна вэ ?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 66 буюу 55.5% нь “иргэн, хувь хүн”, 46 буюу 38.7% нь “Засгийн газар”, “олон нийтийн телевиз”, 42 буюу 35.3% нь “олон нийтийн цахим сүлжээ”, 32 буюу 26.9% нь “сонин сэтгүүл”, 31 буюу 26.1% нь “цагдаагийн байгууллага”, 33 буюу 27.7% нь “замын цагдаагийн газар”, 21 буюу 17.6% нь “төрийн бус байгууллага”, “аж ахуйн нэгж байгууллага”, 29 буюу 24.4% нь “төрийн байгууллага” хэмээн үзсэн байна.

Дээрхи хариултаас үзвэл судалгаанд оролцогчдын дийлэнхи хэсэг нь явган зорчигчоос шалтгаалсан зам тээврийн осол, зөрчлийг бууруулахад хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтийн цахим сүлжээ чухал үүрэг оролцоотой гэж үзсэн байна.

График №6

Та явган зорчигчоос шалтгаалсан зам тээврийн осол, зөрчлийг бууруулахад ямар байгууллагын үүрэг оролцоо чухал гэж та үзэж байна вэ?

119 responses



Судалгаанд оролцогчдоос явган зорчигчоос шалтгаалсан зам тээврийн осол зөрчлийг бууруулах чиглэлээр ямар ажил, арга хэмжээ авбал зохих талаар таны санал бодлыг асуухад дараах хариултыг нээлттэй байдлаар хариулсан байна. Үүнд:

- Бүх шатанд сургалт зохион байгуулах;
- Иргэдэд гарцаараа гаргах ач холбогдлыг ухамсарт нь суулгах;
- Хүн бүр замын хөдөлгөөний дүрмийг баримтлуулж сургах;
- Явган хүний гарцыг ойр ойрхон байгуулах;
- Явган хүний нүхэн гарц, гүүрийг олноор нь байгуулах;
- Замын түгжрэлийг бууруулах чиглэлээр дорвитой ажил хийх;
- Замын хашаа, хаалтыг янзлах;
- Замын тэмдэг, тэмдэглэгээг тод жолооч болон явган зорчигчдод харагдахуйцаар байрлуулах;
- Явган болон дугуйн замыг ихээр барьж ашиглалтад оруулах;
- Бага ангиас нь эхлэн замын хөдөлгөөнд оролцох соёлыг зааж өгөх;
- Аажуу явбал аяндаа хүрнэ гэдэг шиг цахим аяныг сайн зохион байгуулах;
- Жолооч бэлтгэн гаргаж байгаа жолооны курс дамжаануудад явган зорчигч замын хөдөлгөөнд хэрхэн оролцох, тэдний эрх, үүргийг нарийвчлан зааж сургах;
- Жолооны курсын сургалтын хугацааг нэмж, замын хөдөлгөөний дүрмийг сайн судлуулах;
- Замын хөдөлгөөнд утсаар ярьж оролцох, мессеж бичих, бичлэг үзэх зэргээр саад учруулах, улмаар осол гаргах боломжийг нэмэгдүүлж байгаа нь тогтоогдсон тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх;
- Явган хүний гарцийг гэрэлтүүлгээр хангаж, үзэгдэх орчныг сайжруулах;
- Явган хүний гарцийн дээгүүр гэрэлт анхааруулгы байрлуулах;
- Осол гарч, хүний амь нас, эрүүл мэнд хохирсон бичлэг, мэдээллийг цахим сүлжээгээр дамжуулан хүргэж, урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг зохион байгуулах;
- Явган хүний гарцыг автоматжуулах гадаад орны туршлагыг нэвтрүүлэх зэрэг саналуудыг дэвшүүлсэн байна.

Дээрхи хийсэн судалгааны гарсан дүнг нэгтгэн авч үзвэл явган зорчигчоос шалтгаалсан зам тээврийн осол, зөрчил нь дараах хүчин зүйлсээс хамааралтай байна гэж үзэж байна. Тухайлбал:

- Явган зорчигч иргэдийн замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг хангалтгүй, хөдөлгөөнд хайхрамжгүй, хэнэггүй, хөнгөмсөгөөр найдаж оролцдог;
- замын хөдөлгөөн ихтэй газар нүхэн гарц, явган гүүр бага;
- явган хүний гарц хол зайтай байрладаг, замын тэмдэг, тэмдэглэгээний талаар иргэдийн мэдлэг хангалтгүй;
- бага насны хүүхдүүд эцэг эхийн хараа хяналтгүй замын хөдөлгөөнд оролцох явдал буурахгүй байгаа;
- замын хөдөлгөөний нягтрал ихтэй газруудад явган хүний гарц дээр камерын хяналт байхгүй байгаа;
- жолооч-иргэд замын хөдөлгөөнд соёлгүй оролцдог;
- хөдөлгөөнд жолооч нар бие биенээ хүндэлдэггүй, утсаар ярих, мессеж бичих, бичлэг үзэх зэрэг хараа сарниулах зүйл хийж хөдөлгөөнд оролцох явдал түгээмэл гардаг зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг байна.

Дүгнэлт. Явган зорчигчоос шалтгаалсан зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж буй ажил, арга хэмжээний үр дүн хангалтгүй, олон нийтэд хүртээмж муутай байгаа нь ослын тоо мэдээнээс харж болохоор байна.

Явган зорчигчоос шалтгаалсан зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон нийтэд хүртээмжтэй ажил, арга хэмжээг олон нийтийн цахим сүлжээг ашиглан явуулах шаардлага тулгарч байна. Тиймээс зардал бага шаардагдах олон нийтийн цахим сүлжээ ашиглан явган зорчигчдын замын хөдөлгөөнд оролцох мэдлэгийг нэмэгдүүлэх аян зохион байгуулах замаар мэдлэгийг нэмэгдүүлэх нь ослыг бууруулахад чухал нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Ерөнхий боловсролын сургуулийн дунд бүлгээс дээш сурагчдад замын хөдөлгөөнд явганаар хэрхэн оролцох чиглэлийн хичээл сургалт орох;
2. Явган зорчигч хамгийн осолд өртсөн газарт явган хүний нүхэн гарц, гүүрийг байгуулах;
3. Явган болон дугуйн зам олныг барих;
4. Бага ангиас нь эхлэн замын хөдөлгөөнд оролцох соёлыг зааж өгөх;
5. Аажуу явбал аяндаа хүрнэ гэдэг шиг цахим аяныг сайн зохион байгуулах;
6. Жолооч бэлтгэн гаргаж байгаа жолооны курс дамжаануудад явган зорчигч замын хөдөлгөөнд хэрхэн оролцох, тэдний эрх, үүргийг нарийвчлан зааж сургах;
7. Жолооны курсын сургалтын хугацааг нэмж, замын хөдөлгөөний дүрмийг сайн судлуулах;
8. Замын хөдөлгөөнд утсаар ярьж оролцох, мессеж бичих, бичлэг үзэх нь тогтоогдсон тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгах;
9. Явган хүний гарц дээр шөнийн цагт гэрэлтүүлгээр хангаж, үзэгдэх орчныг сайжруулах;
10. Осол гарч, хүний амь нас, эрүүл мэнд хохирсон бичлэг, мэдээллийг цахим сүлжээгээр дамжуулан хүргэж, урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг зохион байгуулах;

**МАШИН АЧИЛТЫН КОМПАНИУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ОЛОН НИЙТИЙН ЗҮГЭЭС ӨГЧ БУЙ ХАНДЛАГАД ХИЙСЭН СУДАЛГАА**
IN OPERATIONS OF TRUCKING COMPANIES
A RESEARCH ON PUBLIC ATTITUDES

М.Бат-Эрдэнэ
ДХИС-ийн магистрант,
цагдаагийн ахмад
M.Bat-erdene – Graduate student,
University of Law Enforcement,
Police captain

Хураангуй. Өнөөдөр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод хамгийн их тулгамдаж байгаа асуудал бол замын хөдөлгөөний түгжрэл билээ. Энэ асуудлаар УИХ, Засгийн газар, Улаанбаатар хотын удирдлагын түвшинд олон арга замыг эрэлхийлж байгаа хэдий ч үр дүнд төдийлөн хүрч чадахгүй байсаар байна.

Энэхүү өгүүлэлд нийслэлийн авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор замын хөдөлгөөнд саад учруулж байгаа тээврийн хэрэгслийг зориулалтын ачигч, чирэгч авто машинаар зөөж шилжүүлэх үйлчилгээ үзүүлж буй компаний үйл ажиллагаанд иргэд олон нийтийн зүгээс өгч буй сэтгэл ханамж, хандлагыг судалгааны үр дүнг үндэслэн товч тусгасан болно.

Summary. Today, the biggest problem in Ulaanbaatar, the capital of Mongolia, is traffic congestion. Although the Parliament, Government, and Ulaanbaatar city administration are looking for many ways on this issue, they are still unable to achieve results.

In this article, based on the results of the research, the satisfaction and attitude of the public to the activities of the company that provides services for moving the vehicles that are obstructing the traffic with designated loaders and towing vehicles in order to reduce traffic congestion in the capital city is briefly described.

Түлхүүр үг: Замын түгжрэл, машин ачигч компани, иргэд, олон нийт, замын цагдаагийн алба хаагч

Keywords: traffic congestion, trucking companies, citizens, public, traffic police officers

Оршил хэсэг. Иргэд түгжрэлийн талаар бодохдоо хэт төвлөрөл, хангалтгүй уулзвар замууд, хөдөлгөөнд оролцох соёлгүй зан байдал нөлөөлдөг хэмээн үздэг бол мэргэжилтнүүд замын муу сүлжээ, нийтийн тээврийн муу бодлого, оновчгүй бүсчлэл хэмээн дүгнэдэг.

Улаанбаатар хотын авто замын ерөнхий сүлжээг 349,000 хүн амтай, 10,044 автомашинтай буюу хүн амын ердөө 2.9% нь автомашинтай байхаар 1975 оны ерөнхий төлөвлөгөөний дагуу барьсан бөгөөд хотын хүн амын даац дээд тал нь 400,000 – 500,000

байхаар тооцоолсон байдаг. Хятадад автомашины тоо 10 жилийн дотор 100 саяар орчмоор өссөн бол манайд 10 жилийн өмнө 161.989 аас 815009 болтлоо өссөн байна.¹²²

Түгжрэлийг багасгахад цогц бодлого хэрэгтэй, авто зам өргөтгөх шинэчлэх, бүтээн байгуулалтын ажлаас гадна төвлөрлийг сааруулах, автомашины хэрэглээг зөв зохион байгуулах, цагийн горимд оруулах, нийтийн тээврийг түлхүү ашиглах, жолооч нарын сахилгыг дээшлүүлэх, унадаг дугуйг ашиглах гээд цогц бодлого хэрэгтэй байдаг.¹²³


Бид замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах чиглэлээр ашиглаж байгаа машин ачилтын компаниудын үйл ажиллагаанд олон нийт хэрхэн хандаж байгаа тогтоох зорилгоор хийсэн судалгааныхаа үр дүнд энэхүү илтгэлдээ орууллаа.

Олон нийтийн хандлагыг тодорхойлох энэхүү судалгаанд нийтдээ 189 иргэн оролцсон бөгөөд 29 буюу 15.3% нь 18-24, 17 буюу 9% нь 25-29, 70 буюу 37% нь 30-34, 48 буюу 25.4% нь 35-39, 20 буюу 16.6% нь 40-44, 1 буюу 0.5% нь 45-49, 3 буюу 1.6% нь 50-54, 1 буюу 0.5% нь 55 ба түүнээс настай иргэд оролцсон байна.

Судалгаанд оролцогчдын хүйсийн байдлыг нь авч үзвэл 63 буюу 33.3% нь эмэгтэй, 126 буюу 66.7% нь эрэгтэй иргэд оролцсон байна.

Боловсролын байдлыг графикаар авч үзвэл:

График №1



Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл: 116 буюу 61.1% нь төрийн байгууллага, 6 буюу 3.2% нь төрийн бус байгууллага, 26 буюу 13.7% нь хувийн аж ахуйн нэгж, 5 буюу 2% нь хувьцаат компанид, 24 буюу 12.6% нь хувиараа аж ахуй эрхлэгч, 13 буюу 6.8% нь ажилгүй иргэд хамрагджээ.


Судалгаанд оролцогчдоос хувьдаа машинтай эсэхийг тодруулахад 137 буюу 72.1% нь машинтай, үлдсэн 52 буюу 27.9% нь машингүй гэсэн хариултыг өгсөн байна.

“Замын түгжрэлтэй холбоотойгоор ажиллаж байгаа машин ачилтын компаний үйл ажиллагааг та дэмждэг үү” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 66 буюу 34.6% нь “тийм”, 54 буюу 28.3% нь “үгүй”, 71 буюу 37.2% нь тодорхой хэмжээгээр дэмждэг гэсэн хариултаудыг тус тус өгсөн байна. Үүнийг графикаар үзүүлбэл:

График №2

¹²² <https://vip76.mn/content/52984>


¹²³ <https://gogo.mn/r/k748w>



Дээрхи графикаас үзвэл судалгаанд оролцогчдын 137 буюу 71.8% машин ачилтын компаниудын үйл ажиллагааг дэмждэг гэсэн судалгааны дүн гарч байна.

“Та замын хөдөлгөөнд оролцохдоо дүрэм зөрчиж, 1-р эгнээнд машинаа байрлуулж байсан уу?” гэсэн асуултад 44 буюу 23.1% нь тийм, 116 буюу 60.7% нь үгүй, 31 буюу 16.2% нь заримдаа гэсэн хариултуудыг тус тус өгчээ.


График №3



Судалгаанд оролцогчдын өгсөн график дээрхи хариултаас үзвэл 60.7% нь үгүй гэсэн хариултыг өгч байгаа нь сайн хэдий ч замын хөдөлгөөнд оролцогчдын дүрэм зөрчигч нь 39.3% байгаа анхаарал татаж байна.

Судалгаанд оролцогчдын 85 буюу 44.5% нь өөрийн автомашинаа журамлуулж байсан бол 106 буюу 55.5% нь журамлуулж байсан байна. Энэ нь замын хөдөлгөөнд оролцогч жолооч нарын дүрэм зөрчих явдал их байгаа нь харагдаж байна.

График №4




Машин ачилтын компаниудаар өөрийн тээврийн хэрэгслээ журамлуулж байгаа тоо 44.5% гэж гарч байгаа харьцангуй өндөр тоо юм.

Судалгаанд оролцогчдоос “Таны машиныг ачилтын компанийн ажилтнууд танд мэдэгдэж ачиж журамласан уу?” гэсэн асуултыг тавихад 12 буюу 6.5% нь “тийм”, 174 буюу 93.5% нь “үгүй” гэсэн хариултыг өгчээ.

Эндээс үзвэл иргэд машин ачилтын компанийн үйл ажиллагааны журмыг мэддэггүй, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тохиолдолд хэрхэн машиныг ачиж тээвэрлэх талаар эрх зүйн ямар мэдлэг, мэдээлэл байхгүй байгаа нь тулгамдсан асуудал болоод байгааг харуулж байна.

Судалгаанд оролцогчдын хариултыг графикт оруулан авч үзвэл:

График №5



Түүнчлэн судалгаанд оролцогчдоос “Таны машиныг ачилтын компанийн замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн байхад журамласан уу” гэсэн асуултад 56 буюу 30.4% нь “тийм”, 128 буюу 69.6% нь “үгүй” гэсэн хариултыг өгчээ.

График №6



Дээрхи графикаас үзвэл нэг талаасаа жолооч-иргэд замын хөдөлгөөний дүрэм зөрчсөнөө мэддэггүй, эрх зүйн мэдлэг дутмаг байгаа, нөгөө талаасаа машин ачилтын компаниудын ажилтнууд журмаа зөрчиж ачсан байх магадлалыг төрүүлж байна.

Замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, машин ачилтын компанийн үйл ажиллагаатай холбоотой дараах саналуудыг өгсөн байна. Тухайлбал:

Замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах чиглэлээр:

- Хотын бүсийг тэлэх
- Замуудыг өргөн болгох
- Томоохон захуудыг нүүлгэн шилжүүлэх
- Чадваргүй жолооч нар ихэссэнийг анхаарч жолооны курсын сургалтыг сайжруулах
- Метротой болох
- Улаанбаатар хотоос их дээд сургуулийг эхний ээлжинд гаргах өөр газар төвлөрүүлэх.
- Төрийн байгууллагуудыг хотын захруу гаргах гэхдээ зөвхөн удирдлагаар хангадаг байгууллагыг нь.
- Иргэдийн ихээр очиж үйлчлүүлэх боломжтой газрыг нь олон болгох гэхдээ БЗД-ийн иргэн бол зөвхөн БЗД-ийнхээ салбараас төрийн болон төрийн бус үйлчилгээ авах ёстой.
- Оочер дараалал үүсгэхгүйн тулд хороо болгон дээр төрийн бүх үйлчилгээ байх хэрэгтэй төрийн болон төрийн бус үйлчилгээ бүгд нэг дороо хороо болгон дээр байгуулах
- Хотын төвд огт газар өгөхгүй байх.
- Одоо хотын төвд нэмж юу ч барьж болохгүй, дандаа зах руугаа чиглэсэн Улаанбаатар хотыг баруун зүүн тийш сунгах бодлого явуулах.
- Төрийн албан хаагчдыг гэрийн хаягаар нь ажиллуулах.
- Бүх жолооч нараас жолооны давтан шалгалт авах торгуулийн хэмжээг ихэсгэх
- Барилга байшин барихдаа эхлээд замын бүтээн байгуулалт, тээврийн хэрэгслийн зогсоол шийдвэрлэх
- Гадаадын орнуудад байдаг төлбөртэй тээврийн хэрэгслийн зогсоолыг их болгох.
- Шинээр баригдаж байгаа худалаа үйлчилгээний төвүүдийг зогсоолын хүртээмжтэйгээр бариулж улсын комисс хүлээж авдаг байх.
- Өөр бусад төрлийн тээврийн хэрэгслийн үйлчилгээг нэвтрүүлэх,
- бусад орны томоохон хотуудын замын төлөвлөлтийг харж судлах
- Их зогсоол шийдэх

- Замын 1 эгнээг төлбөртэй зорчуулдаг байх /жишээ нь 1 цаг 20000 юм уу гэх мэт/
- 1өрх айл нэг машинтай болох,
- Согтуу жолооч нарын эрхийг ямар хугацаагаар хасна, яг тэр хэмжээгээр нь машиныг нь хотын захад журамлан хөдөлгөөнд оролцуулахгүй байлгах
- Хотын төвд байрладаг их дээд сургуулиудыг хөдөө орон нутаг рүү нүүлгэн шилжүүлэх


- Дугуйн замтай болгох /дүүжин гүүр барих/
- Хүүхдийн сургууль цэцэрлэгийн гадаа машины түр зогсоолтой болгох
- Буруу талдаа рультай авто машиний импортыг зогсоох
- Замын гүүрүүдийг нягтрал ихтэй газруудад байгуулах
- нийтийн тээврийн үйлчилгээгээ сайжруулах
- Хотын бүсийг тэлэх
- Замын хөдөлгөөний шинэ журам гаргах
- Орон нутагт болон хотоос гадагш ажлын байрыг олноор бий болгох

Машин ачилтын компанийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр:

- Гарцаагүй түр зогссон үед л нэг дүгээр эгнээ болон уулзварын зогсоолтой уулзсан хэсэгт түр зог сож байгаа. Түүнийг нягталж тодруулсаны дараа ачдаг болох
- Ачихынхаа өмнө залгадаг зохицуулалт бий болгох.
- Зам дээр түгжрэл үүсгэж тавьсан машиныг ачих нь зөв.
- Ямар ч түгжрэл байхгүй, зогсоол ч үгүй газар ачилт хийхийг болих
- Автомашин ачих хэрэггүй, зүгээр баримтжуулаад торгуулийн хуудас бичээд шуудангаар нь явуулж байх гэсэн санал, хүсэлт, хариултуудыг өгсөн байна.

Судалгаанд оролцогчдоос “Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тээврийн хэрэгслийг машин ачилтын компани ачих жухамлах үйл ажиллагаа зохих журмын дагуу явагдаж байгаа юу?” гэсэн асуултад 83 буюу 44.4% нь “тийм”, 98 буюу 52.4% нь “үгүй”, 6 буюу 3.2% нь мэдэхгүй гэсэн хариултуудыг тус тус өгчээ.


График №7



“Танд машин ачилтын компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор ажилтнуудтай хэрэлдэх, маргалдах, зодолдох явдал гарч байсан уу” гэсэн асуултыг судалгаанд оролцогчдод

тавихад 55 буюу 29.4% нь “тийм”, 127 буюу 67.9% нь “үгүй”, 5 буюу 2.7% нь “мэдэхгүй” гэсэн хариултыг өгсөн байна. Үүнийг графикаар үзвэл:

Хүснэгт №8



Судалгаанд оролцогчдоос “машин ачилтын компанийн ажилтнууд ямар зөрчил ихэвчлэн гаргадаг вэ?” гэсэн хариултыг тавихад 81 буюу 43.5% нь “тухайн машин эзэмшигчид нь мэдэгдэхгүйгээр шууд ачдаг”, 17 буюу 9.1% нь “тухайн машин эзэмшигчийн утас руу залгаж хэлдэггүй”, 15 буюу 8.1% нь “бүдүүлэг харьцдаг”, 18 буюу 9.7% нь “машины эзэмшигч нь ирсэн ч машиныг нь өгөхгүй, шууд ачаад аваад явдаг”, 9 буюу 4.8% нь “чанга яригчаар зарладаг гэх боловч энэ нь сонсогддоггүй”, 7 буюу 3.8% нь “ачих тээврийн хэрэгсэл нь шаардлага хангадаггүй”, 9 буюу 4.8% нь “Тухайн тээврийн хэрэгслийг хаан нь ачсаныг мэдэх боломжгүй байдаг учир машинаа авахад хүндрэл үүсдэг”, 6 буюу 3.2% нь ямар хууль, дүрмийн зүйл, заалт зөрчсөн талаар машин эзэмшигчид мэдэгдэхгүй ачдаг, 7 буюу 3.8% нь машин ачилтын компанийн ажилтнууд замын цагдаагийн зөвшөөрөлгүй дур мэдэн ачдаг” гэсэн хариултуудыг тус тус өгчээ.

Асуулгад өгсөн хариултуудыг графикаар үзүүлбэл:

График №9

байна вэ” гэсэн асуултад 97 буюу 53.3% нь “Зөрчилтэй машиныг ачиж журамлахаас 10-15 минутын өмнө эзэмшигчид утсаар эсхүл мессежээр заавал мэдэгдэж, ирэхгүй бол журамлаж байх”, 37 буюу 20.3% нь “машин ачиж журамлах эрх зүйн актыг иргэдийн санал, хүсэлтийг үндэслэн боловсронгуй болгох”, 20 буюу 11% нь “машин ачилтын компанийн ажилтнуудын харилцааны болон хууль, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх тусгайлсан сургалтад хамруулсаны дараа ажилд авч байх”, 28 буюу 15.4% нь “жолооны курсуудад машин ачих журамлахтай холбоотой хууль, эрх зүйн хичээлийг нэмж оруулах” гэсэн саналуудыг дэвшүүлсэн байна.

График №11



Цаашид машин ачилтын компанийн үйл ажиллагаатай холбоотой нээлттэй өгсөн хариултыг түүвэрлэн авч үзвэл:

- Машин ачилтын төлбөр бага болгох эрх зүйн орчныг иргэдэд сурталчлах
- Иргэдийн хяналтыг нэмэгдүүлж, машин ачилтын компанийн ажилтнуудын хууль бус үйлдлийг илрүүлж, холбогдох байгууллагад мэдээлэх
- Жолооны курсийн сургалтын чанарыг дээшлүүлж жолооч нарыг чадвахжуулах
- Машин ачлагын компанийн ажилчдыг мөнгөнд улайрсан, мөнгөний хойноос биш хотын түгжрэлийг бууруулахын төлөө ажиллаж байгаа ажилтан гэдгийг анх ажилд ороход нь ойлгуулж өгөх хэрэгтэй
- Машин ачилтын ажилчид байрны дундах зогсоолуудтай л зууралдаад байдаг. Өөр бусад газар хөдөлгөөнд саад учруулж бгаа газрууддаа очиж ажилламаар байна. Тэгэхгүй бол 1 түр зогсох хориотой тэмдэг хаана ч хамаагүй зоогоод л тэндээсээ ачих гээд дайраад бдаг. Тэрийгээ өөрчилмөөр байна.
- Машин ачилтын компанийн ажилтнууд замын цагдаагийн зөвшөөрөлгүй дур мэдэн ачдаг.
- Машин ачлагын газруудын буруу гэж бодохгүй байна, маш энгийн зүйл шүү дээ. Зүгээр л зөв хүн бай. Машинаа төлбөртэй зогсоолд тавьж сур.
- машин ачнаараа замын түгжрэл буурахгүй гэдгийг л ойлгох хэрэгтэй.

- Төрийн тусгай албан тушаалтнууд зам бөглөж байгаад явдаг нь ард түмнээ дорд үзэж байгаа санагддаг. Гадаадын улсуудад ийм зүйл хараагүй.

- Нийтийн тээврийн тав тух, жолооч нарын соёлтой харилцаа, жолоодлого гэх зэргээр санаа бодлоо илэрхийлжээ.

Токио хотын нийт оршин суугчдын 90% нь метрогоор, 6 % нь автомашинаар зорчдог бол Бээжингийн иргэдийн 34% нь машин унаж, хотын төвийн түгжрэнд зогсдог. Улаанбаатарчуудын хувьд энэ тоо 69% д хүрнэ. /4 жилийн өмнөх судалгаагаар/. Түгжрэлд зогсож байхдаа ч агаар бохирдуулж, тормос гишгэх бүртээ илүү хүнд метал ялгаруулсаар. Бээжинд оргил цагаар 6 дугаар бүсээс доторх хэсэгт нэг цагт нэг тонн РМ 2.5 бохирдол үүсгэдэг гэсэн судалгаа байдаг юм байна.

Улаанбаатар хотод дундаж хөдөлгүүрийн багтаамжтай /1600 cc-ээр тооцлоо/ суудлын автомашин нэг цаг нормальдахад /түгжрэлд зогсоход/ 0.8 литр бензин зарцуулдаг ба энэ нь 1328 төгрөг болох юм. Өөрөөр хэлбэл нэг жолооч өдрийн нэг цагийн түгжирэлд 1328 төгрөгийг үргүй зарцуулдаг гэсэн үг. Тэгвэл нийслэл Улаанбаатар хотод 311.478 автомашин замын хөдөлгөөнд оролцдог, түүнээс дугаарын хязгаарлалт болон хөдөлгөөнд оролцдоггүй автомашиныг хасаад хамгийн багаар тооцоход 200 000 автомашин байнга замын хөдөлгөөнд оролцдог гэж үзвэл зам дээр 265 600 000 төгрөгийг зөвхөн нэг өдөрт үргүй урсгадаг гэсэн үг. Энэ нь нэг сард ажлын 21 хоногтой гэж үзвэл 5 577 600 000 төгрөг, жилд /түгжирэл хамгийн бага байдаг 7,8 сарыг хасаад/ 55 776 000 000 төгрөг буюу энэ нь ДНБ-ний 2.9 % -ийг эзлэж байна.¹²⁴

Гэхдээ бидэнд 8-12 сая автомашинтай том хотуудтай харьцуулахад бидэнд илүү их боломж бий. Жишээлбэл: Зөвхөн Их тойруугийн дотор гэхэд л өнөөдрийн байдлаар төрийн 286 байгууллагад 28.993 алба хаагч ажиллаж байгаа гэсэн судалгаа байна. Тэдгээрийн 11.402 нь нийтийн тээврээр, 4.698 нь явганаар, 12.893 нь хувийн автомашинаар хамгийн багадаа 3 км хол нь 10 орчим км замыг автомашинаараа туулж ажлын байрандаа ирдэг ба автомашинаа өдрийн турш зогсоол бөглөж сойдог. Энэ байдал нь нээгд замын ачааллыг нэмэгдүүлдэг хоёрт авто зогсоолын хүртээмжийг шууд бууруулдаг сөрөг талтай.

Их дээд сургуулийн тухайд 92.098 оюутан өглөө оройн цагаар сургууль гэр хоёрын хооронд явдаг ба тэдгээрийн 68.049 нь нийтийн тээврээр, 16.908 нь явганаар, 13.209 нь хувийн автомашинаар ирдэг гэсэн судалгаа байна.

Харин ЕБС-ийн тухайд байдал бас л хурцаар ажиглагдана. Их тойруугийн дотор 65 хувийн болон төрийн өмчит ЕБ сургуулийн 59879 хүүхдээс 19985 нийтийн тээврийн хэрэгслээр 23976 явганаар, 7959 хүүхэд автомашинаар хүргүүлж ирдэг гэсэн судалгаа байна. Хүүхдийн автобусаар эдгээрийн 1797 нь зорчидог юм байна. Тэгэхээр энэ тооноос харахад бидний шийдэх боломжтой асуудлыг шийдэхгүй байгаагаас ямар их ачаалал үүсэж байгааг харж болохоор байна.

Дүгнэлт. Бид машин ачилтын компаниудын үйл ажиллагаанд олон нийт хэрхэн хандаж байгааг тогтоох зорилгоор хийсэн судалгааны дүнг үндэслээд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Нийслэлийн замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулахад машин ачилтийн компанийн үүрэг оролцоо их гэдгийг иргэдийн дийлэнх хэсэг нь хүлээн зөвшөөрч байна.

2. Иргэд өөрсдөө замын хөдөлгөөний дүрэм зөрчиж, машинаа ачуулчихаад замын хөдөлгөөний ямар дүрэм, журам зөрчсөнөө мэдэхгүй байгаа нь жолооч-иргэдийн эрх зүйн мэдлэг хангалтгүй байгааг илэрхийлж байна.

¹²⁴ <https://vip76.mn/content/52984>

3. Иргэд, олон нийт машин ачилтын компаниудын машиныг ямар тохиолдолд хэрхэн ачдаг талаар мэдлэг хомс байгаа нь тулгамдсан асуудал болжээ.

4. Нийслэлийн замын хөдөлгөөний түгжрэл нь машин ачилтын компаниудын үйл ажиллагааг идэвхитэй явуулах нэг хүчин зүйл болжээ.

5. Машин ачилтын компанийн үйл ажиллагааны журмыг боловсронгуй болгох зорилгоор нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, зөрчил гаргасан автомашиныг аль журмын хашаа руу шилжүүлсэнийг утсаар мэдэгдэж байх шаардлага гарч байна.

6. Машин ачилтийн компаниудын ажилтнуудын харилцааны соёлыг дээшлүүлэх болон эрх зүй мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтыг хагас жил тутам зохион байгуулахгүй бол иргэд, олон нийтийн дунд буруугаар үнэлэгдэх магадлал өндөр байна.

7. Нийслэлийн төвийн хүн ам нягтаршилтай хэсгүүдэд төлбөртэй машины зогсоолыг олноор нь байгуулах замаар дүрэм зөрчих машины тоог бууруулах боломж байгаа харгалзан үзэх шаардлагатай болжээ.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн машин ачилтын компанийн үйл ажиллагааг сайжруулах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үүднээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Машин зөөн шилжүүлэн байрлуулсаны төлбөрийг бууруулах, бага болгох талаар нийслэлийн холбогдох байгууллагууд судалгаа хийх

2. Автомашин зөөн шилжүүлэн байрлуулахтай холбоотой хууль, эрх зүйн зохицуулалтыг олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан жолооч-иргэд болон олон нийтэд сурталчлах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах

3. Иргэдийн хяналтыг нэмэгдүүлж, машин ачилтын компанийн ажилтнуудын хууль бус үйлдлийг илрүүлж, холбоонд нь мэдэгдэж арга хэмжээ авхуулж байх

4. Жолооны курсийн сургалтын чанарыг дээшлүүлж жолооч нарын эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, машин ачилтын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэлтэй болж болгож төгсгөх

5. Машин ачлагын компанийн ачиж зөөвөрлөх тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлагыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх

6. Зөрчил гаргасан тээврийн хэрэгслийг зөөн байршуулсан тохиолдолд эзэмшигчид нь хаана очиж тээврийн хэрэгслээ авч болох талаар утсаар холбоогоор заавал мэдэгдэж байх зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

**ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ЗӨРЧИЛД
ХҮЛЭЭЛГЭЖ БУЙ ШИЙТГЭЛ, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ
VIOLATIONS AGAINST ROAD SAFETY ENHANCEMENT
OF EXPECTED PUNISHMENT AND ITS EFFECTS**

*Д. Баасансүрэн
ДХИС-ийн магистрант,
цагдаагийн ахлах дэслэгч.
D.Baasansuren - student,
University of Law Enforcement,
police chief lieutenant*

Товчлол: Энэхүү өгүүлэлд Монгол Улс дахь замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийн өнөөгийн байдлыг судалж, түүн хүлээлгэж буй хариуцлагын төрөл, хэмжээг судалж, жолоочийн зөрчил гаргахад хэрхэн нөлөөлж байгаа талаар товч тусгасан болно.

Abstract: This article examines the current state of traffic safety violations in Mongolia, examines the type and amount of liability, and briefly describes how it affects driver violations.

Түлхүүр үг: Замын хөдөлгөөний аюулгүй байдал, зөрчил, шийтгэл, жолооч, жолоочийн хариуцлага, жолоочийн оноо.

Keywords: road safety, violation, punishment, driver, driver's responsibility, driver's score.

Удиртгал. Монгол Улсад замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчилд Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар торгох, эрх хасах, баривчлах шийтгэл ногдуулж байсныг 2016 оноос Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх болсон. Зөрчлийн тухай хууль нь өмнө 220 гаруй хуульд заасан зөрчлийн шинжтэй үйлдэлд олон төрлийн хариуцлага хүлээлгэж байсныг нэгтгэж, зөрчлийн ойлголт, түүнд хүлээлгэж буй хариуцлагын нэгдсэн тогтолцоог бий болгоход чиглэсэн юм.

Зөрчлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т “энэ хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино” гэж заасан. Мөн Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д “замын хөдөлгөөний аюулгүй байдал” гэж замын хөдөлгөөнд оролцогчийг зам тээврийн осол, түүнээс үүдэн гарах хор уршгаас хамгаалсан байдлыг” хэлнэ гэж тодорхойлсон¹²⁵. Эдгээр заалтууд нь иргэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлөөс ангид байж эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хамгаалуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн болох нь харагдаж байна. Дээрх хуулиуд нь замын хөдөлгөөний зохион байгуулалт, зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн.

Зөрчлийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд буюу 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас 5.391.342 зөрчилд шийтгэл оногдуулсны 96.9 хувийг хүнд, 3.1 хувийг хуулийн этгээдэд оногдуулсан байна. Дээрх хугацаанд нийт 5.309.421 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган, торгуулийн шийтгэл оногдуулжээ.

¹²⁵ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль 2015 он, ТМ №01.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зааснаар 31 байгууллагын 216 орчим нэгжид хамаарах 10011 орчим субъект зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнээс цагдаагийн байгууллага зөрчлийн 90 дээш хувийг шалган шийдвэрлэж ирсэн бөгөөд үүнээс нийт зөрчлийн 92.4 хувь нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил эзэлж байна¹²⁶. Тиймээс энэхүү сэдвийг дараах үндэслэлээр судаллаа. Үүнд:

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийн өнөөгийн байдал, зөрчлийн өсөлт бууралт.

Хүснэгт №01. ЗХАБ-ын эсрэг зөрчлийн үзүүлэлт

Аймаг, дүүрэг	Он					
	2016	2017	2018	2019	2020	2021
Улаанбаатар	1080168	1078800	1230074	1659618	1580126	1489089
Орон нутаг	248392	245757	401922	548059	478221	432798
Улс	1328560	1324557	1631996	2207677	2058347	1921887

Улсын хэмжээнд 2016 онд 1328560 зөрчил бүртгэгдсэн бол 2020 онд 2058347, 2021 онд 1921887 зөрчил бүртгэгдсэний 1489089 буюу 77.5 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил өнгөрсөн оны үеийнхээс 136460 нэгж буюу 6.6%-иар буурсан. Гэхдээ сүүлийн 5 жилийн үзүүлэлтийн дундаж буюу 2016 оны үзүүлэлтэй харьцуулан үзэхэд өссөн байна. Үүнээс орон нутагт гарч байгаа замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийг дараах графикаар харуулая.

Зураг №01. ЗХАБ-ын эсрэг зөрчлийн сүүлийн 5 жилийн үзүүлэлт



Графикаас харахад орон нутагт 2016 онд 248392 зөрчил бүртгэгдсэн бол 2021 онд 432798 зөрчил бүртгэгдсэн нь тус оноос 46 хувиар өссөн үзүүлэлтэй бөгөөд 2019 оноос зөрчлийн үзүүлэлт буурсан нь ковид цар тахлын хорио цээрийн дэглэмтэй холбоотой буурсан байх магадлалтай юм. Гэсэн хэдий ч замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийг бууруулахад урьдчилан сэргийлэх ажил хэрхэн нөлөөлсөн, Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл үр нөлөө үзүүлж буй эсэхийг судлах хэрэгцээ шаардлага байсаар байна.

2. Монгол Улсад “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай хууль” 1996 онд анх батлагдсанаас хойш 20 жилийн дараа буюу 2015 онд 7 бүлэг, 55 зүйлтэйгээр батлагдсан бөгөөд тус хуулиар замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил, түүнд хүлээлгэх шийтгэл, жолоочийн бүртгэлийн оноо зэргийг шинэчлэн тусгаж өгсөн¹²⁷.

¹²⁶ Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга.

¹²⁷ 2017 оноос ЗХАБтХ-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан.

Жолоочийн бүртгэлийн оноо тооцох асуудал нь жолоочийн хариуцлагыг нэмэгдүүлэх, дахин зөрчил гаргахгүй байхад чиглэж, хариуцлагын үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн¹²⁸.

Монгол Улсад сүүлийн 5 жилийн тээврийн хэрэгслийн тоо болон жолоочийн тоон үзүүлэлтийг дараах хүснэгтээр үзүүллээ.

Хүснэгт №02. Тээврийн хэрэгсэл, жолоочийн тоон сүүлийн 5 жилийн үзүүлэлт¹²⁹

Он	Тээврийн хэрэгслийн тоо	Өсөлт, бууралт	Жолоочийн тоо	Өсөлт, бууралт
2020	1137208	9	1335000	5.4
2019	1043028	7.4	1265544	4.7
2018	970880	7.8	1207690	4.6
2017	900127	6.9	1153621	5
2016	841537	-	1098638	-

Дээрх хүснэгтээс харахад 2016 онд тээврийн хэрэгсэл 841537 байсан бол 2020 онд 1137208 буюу 35.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн 2016 онд жолоочийн тоо 1098638 байсан бол 2020 онд 1335000 байсан нь 21.5 хувиар өссөн байгаа нь зөрчлийн гаралтад шууд нөлөөлж байна. Тиймээс замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийг бууруулахад хуульд заасан шийтгэл нь хэрхэн нөлөөлж байгааг судлах, жолоочийн хариуцлага, эрх зүйн ухамсарт нөлөөлж байгааг судлах нь зүйтэй юм. Энэхүү өгүүллийн зорилго нь Монгол Улс дахь замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийн өнөөгийн байдлыг судалж, жолооч замын хөдөлгөөний дүрэм зөрчихөд нөлөөлж буй хүчин зүйлд дүн шинжилгээ хийж, Зөрчлийн хуульд заасан шийтгэлийн хэмжээ хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлоход чиглэсэн.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийн өнөөгийн байдал. Цагдаагийн байгууллагаас Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн зөрчилд гудамж замын хяналт, шалгалтаас гадна замын хяналтын камер болон цахим дүрс бичлэг ашиглан замын хөдөлгөөнд оролцогчийн хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг хангах, гарч болзошгүй осол, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж өдөр тутмын хяналтыг тавьж ажилладаг.

Замын хөдөлгөөнд оролцогчийн хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг хангах, гарч болзошгүй осол, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд иргэдийн оролцоо тэр тусмаа хуулиар хүлээсэн эрхээс гадна үүрэг, үүргээ биелүүлэх хариуцлага чухал төдийгүй энэ хариуцлагыг бий болгох механизмын гол хөшүүрэг нь шийтгэл оногдуулах хэлбэр буюу замын хөдөлгөөнд оролцогч иргэдийн гаргасан зөрчилд мөнгөн торгууль оногдуулах, баривчлах, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг тодорхой хугацаагаар хасах, зөрчлийн оноо тооцох асуудал юм.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр дагаж мөрдөх замын хөдөлгөөний нэгдсэн журмыг Замын хөдөлгөөний дүрмээр тогтооно гэж заасан. Тэгвэл “Замын хөдөлгөөний дүрэм”-ээр тогтоосон замын хөдөлгөөний нэгдсэн журмыг зөрчсөн зөрчил 2020 онд улсын хэмжээнд 2058347 илрүүлснээс 76.8% нь нийслэлд, 30.3% нь орон нутагт бүртгэгдсэн байна. Эдгээрээс согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 26696, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх, бичиг баримтгүй тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 13895, хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй бүрэн бус тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцсон

¹²⁸ Зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журмын төслийн танилцуулга 2015 он УБ². Жолоочийн бүртгэлийн оноо тооцох журам 2015 он УБ³.

¹²⁹ Тээврийн цагдаагийн алба. Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл. УБ., 2020 он.

226088, техникийн үлэг, оношилгоонд ороогүй, улсын дугааргүй техникийн гэрчилгээгүй 166316, хурд хэтрүүлсэн 150486, эгнээ байр буруу эзэлсэн 215659, бусад 1259207, цаашид хөдөлгөөнд оролцох боломжгүй 21378 тээврийн хэрэгслийг түр саатуулж журамласан байна. Бодит нөхцөл байдлаас харахад жил ирэх тутамд дээрх үзүүлэлт нэмэгдэж байгаа нь тээврийн хэрэгсэл, шинээр бэлтгэгдэж байгаа жолоочийн тоон үзүүлэлттэй шууд хамааралтай хэдий ч зөрчил гаргагчид оногдуулж байгаа шийтгэлийн үр нөлөө, жолоочийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, замын хөдөлгөөний дэг журмыг сахиулахад нөлөөллийн зөв хөшүүргийг бий болгох шаардлагатай байна.

Хууль зүйн сайдын 2015 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/187 дугаар тушаалаар “Жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журам” батлагдан мөн оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж ирсэн. Энэхүү журам нь механикжсан тээврийн хэрэгслийн жолоочид замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хууль, дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх, гаргасан зөрчилд оноо тооцох, зөрчил гаргаагүй тохиолдолд урамшуулах асуудлыг зохицуулах, сахилга хариуцлагыг сайжруулах зорилготой¹³⁰.

Улсын хэмжээнд 2020 оны байдлаар 1335000 жолооч бүртгэлтэй байгаагаас замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчиж 249592 жолоочийн зөрчлийн оноо хасагдаж, жолоочийн бүртгэлийн системд 4419 жолоочийн оноо тэглэгдэж тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болжээ. Жолооч замын хөдөлгөөнд оролцохдоо хамгаалах бүс, хамгаалалтын малгай хэрэглээгүй зөрчлийн улмаас оноо хасагдсан тохиолдол нийт оноо хасуулсан зөрчлийн 99387 буюу 39.8%-ийг эзэлж байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр “Өршөөл үзүүлэх тухай хууль” батлагдан гарснаар Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйл “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих”-д заасан 2.804.816 зөрчлийн 66.517.100.000 /66 тэрбум 517 сая 100 мянган/ төгрөгийн торгуулийг Өршөөл үзүүлэх тухай хуульд зааснаар энэ оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд 50 хувийг өршөөн чөлөөлсөн. Энэ хуулийн хүрээнд жолоочийн зөрчлийн бүртгэлийн онооны сангийн 526.939 жолоочийн мэдээллээс оноо хасагдаагүй буюу 10 оноотой 45.205 жолоочийн мэдээллийг үлдээж, 10-аас доош оноотой 481.734 жолоочийн мэдээллийг ялгаж, 5763 жолоочийн 10, 7953 жолоочийн 9, 11.988 жолоочийн 8, 18.233 жолоочийн 7, 26.075 жолоочийн 6, 45.449 жолоочийн 5, 36.113 жолоочийн 4, 55.240 жолоочийн 3, 113.635 жолоочийн 2, 161.285 жолоочийн 1 оноог тус тус сэргээж, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ 2017 оны 07 дугаар сарын 01-нээс 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 24 цаг 00 минутаас өмнө Зөрчлийн тухай хуулийн 14.7.3.1, 14.7.3.2, 14.7.13, 14.7.30, 14.7.32 дах заалтуудыг тус тус зөрчиж эрхээ хасуулсан 40531 жолоочийн мэдээллийг давхардаагүй тоогоор жолоочийн мэдээллийн санд “эрх хасагдсан” төлөвийг хүчинтэй төлөвт шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлаас “Өршөөл үзүүлэх тухай” хуулийг баталж гаргасан нь зөрчлийг дахин давтахгүй байх, хариуцлага, эрх үүргээ ухамсарлахад чиглэсэн нөлөөллийн томоохон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний нэг төдийгүй төр ард иргэддээ итгэл үзүүлж байгаа асуудал гэж нэг талаас харж болох юм. Харин нөгөө талдаа ард иргэд маань энэ байдалд угаас ингэх ёстой мэтээр дүгнэж өөрийн үйлдэл эс үйлдлээс хамаараан бусдын хуулиар олгогдсон эрхэд халдаж байгаагаа үл ухамсарлан, хариуцлага, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийн оронд хэн нэгнээс бурууг хайсан, өөрийн эрх үүргийг нэн тэргүүнд тавьсан байдал газар авч байна.

¹³⁰ Жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журам Хууль зүйн сайдын 2015 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/187 дугаар тушаал.

Замын хөдөлгөөний дүрэм зөрчиж холбогдох хуулийн дагуу шийтгэл оногдуулж байгаа асуудалд иргэд олон нийтийн зүгээс нэг удаа сануулж болдог уу, мөнгөн торгууль оногдууллаа, сүртэй зөрчил гаргаагүй байхад гэдэг байдлаар хандах асуудал дийлэнх тохиолдолд гарч үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг буруутгадаг.

Үүнтэй уялдаатай “Жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журам”-д Зөрчлийн бүртгэлийн оноо хасагдсанаас хойш 1 жилийн хугацаанд дахин замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчөөгүй жолоочийн хамгийн сүүлд хасагдсан оноог сэргээж, мөн зөрчил гаргалгүй 2 жил өнгөрсөн тохиолдолд зөрчлийн 10 оноог сэргээж урамшуулах заалтыг тусгасан байдаг.

“Жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журам” нь тухайн жолоочийн гаргасан зөрчилд сануулж байгаа нэг хэлбэр бөгөөд дахин зөрчил гаргасан тохиолдолд тодорхой хугацааны дараа тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болж та жолоо барихгүй шүү гэдэг нөлөөллийн тогтолцоо гэж ойлгож болох юм. Тус журамд жолоочийн зөрчлийн оноо дууссан буюу эрх хасагдсан, хуулийн дагуу оногдуулсан торгуулийг заагдсан хугацаанд сайн дураараа төлөөгүй жолоочид энэхүү журмын 3.1 дэх хэсэгт заасан урамшуулал хамаарахгүй байхаар заасан.

ЗХАБ-ын эсрэг зөрчилд хүлээлгэж буй шийтгэлд хийсэн судалгаа. Зөрчлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг нийт 57 зөрчлийг тусгасан байна. Эдгээр зөрчилд торгох, баривчлах, эрх хасах шийтгэл ногдуулахаар тусгасан бөгөөд хүнийг 10 нэгжээс 400 нэгж хүртэл төгрөгөөр торгох, 7-30 хоногийн хугацаагаар баривчлах, 3 сараас 1 жилийн хугацаатай эрх хасах шийтгэлийг ногдуулахаар тус тус заасан байна.

Зөрчлийн тухай хуульд жолооч согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн тохиолдолд хамгийн өдөр буюу жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, хүнийг 400 нэгжээр торгох шийтгэлийг ногдуулж байна. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчилд хүлээлгэж буй шийтгэлийг ангилан авч үзвэл:

Нэг. Торгох шийтгэл. Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлд заасан нийт 57 зөрчлөөс 6 зөрчилд 10 нэгжээр торгох, 1 зөрчилд 15 нэгж, 22 зөрчилд 20 нэгжээр, 7 зөрчилд 25 нэгж, 1 зөрчилд 30 нэгж, 11 зөрчилд 50 нэгж, 7 зөрчилд 100 (1 зөрчилд хуулийн этгээдэд) нэгж, 6 зөрчилд 200 (5 зөрчилд хуулийн этгээдэд), 1 зөрчилд 400 нэгжээр тус тус торгож байна.

Хоёр. Баривчлах шийтгэл. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол албадан сургалтад хамруулж, 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулж байна.

Гурав. Эрх хасах шийтгэл. 2 зөрчилд 3 сар, 1 зөрчилд 6 сар, 1 жилээр эрх хасах шийтгэл ногдуулж байна.

Дөрөв. Хуулийн этгээдэд хүлээлгэж буй шийтгэл. Хээлийн этгээдэд нийт 14 зөрчилд торгох шийтгэл ногдуулж байгаа бөгөөд 100-1000 нэгж хүртэл төгрөгөөр торгохоор заасан. Үүнээс 1 зөрчилд 100 нэгж, 2 зөрчилд 250 нэгж, 5 зөрчилд 200, 500 нэгж, 1 зөрчилд 1000 нэгжээр тус тус торгож байна.

Эдгээр зөрчлүүдээс хүнийг арав болон зуун нэгжээр торгох шийтгэлийг харьцуулан авч үзье. Үүнд:

Хүснэгт №03. Зөрчилд хүлээлгэж буй шийтгэлийн харьцуулалт.

№	10 нэгжээр торгох шийтгэл	100 нэгжээр торгох шийтгэл
1	9.Жолооч Замын хөдөлгөөний дүрэмд заасан баримт бичиггүй хүнд тээврийн хэрэгслийг шилжүүлсэн бол	2.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй /жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд/, эсхүл эрх нь дуусгавар болсон хүнд тээврийн хэрэгслийн жолоог шилжүүлсэн бол
2	11.Улсын бүртгэлийн дугаар нь: 11.1.арилсан; 11.2.бүдгэрч үзэгдэх байдал нь муудсан; 11.3.танигдахгүй бохирдсон, эсхүл дугаарыг буруу байрлуулсан тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон бол	4. Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд тээврийн хэрэгслийн жолоог шилжүүлсэн бол
3	21.Мотоцикл, мопедын жолооч, эсхүл зорчигч хамгаалалтын малгай өмсөөгүй бол	16.Хуулиар хориглосон тусгай дуут болон гэрлэн дохио суурилуулсан тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон бол
4	33.Жолооч шаардлагагүй үед огцом тоормосолсон, эсхүл аюултай нөхцөл үүсгэсэн, эсхүл хүндэтгэх шалтгаангүйгээр хэт удаан явж бусдын хөдөлгөөнийг саатуулж замын хөдөлгөөнд оролцсон бол	18.Зам тээврийн осолд холбогдсон жолооч ослын газрыг орхиж зугтаасан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол
5	37.Замын хөдөлгөөний дүрэмд зааснаар жолооч энэ зүйлийн 35, 36 дахь хэсэгт зааснаас бусад байдлаар тээврийн хэрэгслийг түр, удаан зогсоох журам зөрчсөн бол	46.Замын хөдөлгөөний дүрэмд зааснаар хүнд, овор ихтэй, хортой, аюултай ачаа тээвэрлэх журам зөрчсөн бол
6	53.Явган зорчигч, эсхүл тээврийн хэрэгслээр зорчигч замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн бол	51.Жолооч замын хөдөлгөөний дүрэм зөрчиж бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол

Хүснэгтээс харахад эдгээр шийтгэлийн хэмжээ нь нэг нь нөгөөгөөс 10 дахин хэмжээтэй мөнгөн хэлбэрээр торгох шийтгэлийг ногдуулж байна. Өөрөөр хэлбэл, торгох шийтгэлийн хэмжээ их байх нь нийгэмд учруулж буй аюул, хор уршиг ихтэй үйлдэл, эс үйлдэхүй байна гэсэн үг юм. Хүснэгтийн 1 дэх хэсэгт “... баримт бичиггүй хүнд тээврийн хэрэгслийг шилжүүлсэн ...”, “...эрх нь дуусгавар болсон хүнд тээврийн хэрэгслийн жолоог шилжүүлсэн...” зөрчлүүдийн хор уршиг төдийлөн ялгаатай харагдахгүй байна. Мөн “жолооч шаардлагагүй үед огцом тоормосолсон, эсхүл аюултай нөхцөл үүсгэсэн ...”, “замын хөдөлгөөний дүрэмд зааснаар хүнд, овор ихтэй, хортой, аюултай ачаа тээвэрлэх журам зөрчсөн ...” зэрэг зөрчлүүдийг дурдаж болно.

Дээрх зөрчлүүдээс хүнд ногдуулж буй хамгийн өндөр торгох шийтгэлийг Зөрчлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7.3-д “согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон”, “согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн” бол жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж, 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан. Дараах зургаар согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийн тоон үзүүлэлтийг 2015-2021 оны байдлаар авч үзүүлээ.

Доорхи графикаас харахад 2015-2017 онд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 27.1-д “согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод

хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, жолоодох эрхийг зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хасах шийтгэл оногдуулна” гэж заасан. Зураг №02. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил.



Энэ нь одоогийн Зөрчлийн тухай хуульд заасан тус шийтгэлээс даруй 2 дахин их хэмжээний төгрөгөөр торгож, эрх хасах шийтгэл ногдуулж байжээ. Өөрөөр хэлбэл, 2015 онд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль шинэчлэгдэж батлагдаж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодоход торгох

шийтгэлийн хамт эрх хасдаг болсноор зөрчлийн үзүүлэлт буурсан ч Зөрчлийн тухай хууль батлагдаж, шийтгэлийн хэмжээ буурсан үеэс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил нэмэгдсэн гэж үзэж болохоор байна. Мөн 2020 онд тус зөрчил буурсан нь бүх нийтийн хөл хорио, цар тахалын нөхцөл байдалтай холбоотойгоор буурсан гэж үзэх үндэслэлтэй юм.

Мөн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож эрхээ хасуулсан хүмүүс дахин согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийг удаа дараа гаргаж байгаа бөгөөд жилд дунджаар 6000 орчим жолоочийг албадан сургалтад хамруулж, 7-30 хоногийн хугацаагаар баривчлах баривчлах шийтгэл ногдуулж байна. Дахин согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон нэг жишээг авч үзвэл ноцтой осол гаргасан Landcruiser маркийн УБХ улсын дугаартай тээврийн хэрэгслийг жолооч “Б” нь дөрвөн удаа жолоодох эрхээ 2014, 2016, 2017, 2022 онд тус тус согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож эрхээ хасуулсан байна. Эндээс харахад замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчилд хүлээлгэж буй хариуцлагын тогтолцоог сайжруулах, үр нөлөөг нь нэмэгдүүлэх нь зайлшгүй хэрэгцээ, шаардлагатай байна. Дээрх нөхцөл байдлаас харахад манай улсад тодорхой төрлийн зарим зөрчлүүдэд хариуцлагыг нэмэгдүүлэх, дахин тийм зөрчил гаргуулахгүй байхад чиглэсэн шийтгэлийн төрөл, хэмжээг Зөрчлийн тухай хуульд оруулах, одоогийн мөрдөгдөж байгаа “Зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журам”-ыг замын хөдөлгөөний дүрмийн заалтуудтай уялдуулан сайжруулж, ач холбогдол, нөлөөллийг нэмэгдүүлэх, олон улсын жишгийн дагуу зөрчилд оногдуулсан мөнгөн торгуулийг төлөөгүй тохиолдолд хүү торгууль тооцох, хугацаандаа төлсөн тохиолдолд 20-50 хүртэл хувийн хөнгөлөлт үзүүлдэг, хувааж төлөх боломжийг бүрдүүлэх нь зүйтэй байна.

Дүгнэлт. Зөрчилд хүлээлгэж буй шийтгэл нь хууль зүйн хариуцлагын тогтолцоонд зонхилох байр эзлэх ба зөрчил гаргасан этгээдийн тухайн үйлдэл, эс үйлдэхүйд төрийн зүгээс өгч буй хууль зүйн хариуцлага юм.

Зөрчил нь нийгэмд аюултай шинж нь байнга хувьсан өөрчлөгдөж байдаг ч Зөрчлийн тухай хуульд заасан замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил нь гэмт хэрэгтэй харьцуулахад нийгэмд аюул багатай үйлдэл, эс үйлдэхүй байдаг. Үүнийг Зөрчлийн тухай хуулийн зарим заалтаас харж болох ба эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол.... гэж заасан байдаг. Гэсэн хэдий ч Зөрчлийн тухай хуульд түүний шинж, нийгэмд учруулах хор уршгийг нарийн тодорхойлж, түүнд хүлээлгэх хариуцлагын хэмжээг зөв тодорхойлохгүй бол зөрчил дахин дахин үйлдэгдэх шалтгаан болно. Өөрөөр хэлбэл, хуульд заасан шийтгэл үр нөлөөгүй байх үндэслэл болж байна. Тиймээс Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэлийн үр

нөлөөг дээшлүүлэхэд зарим шийтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Энэ нь шийтгэл бүр зөрчлөөс урьдчилан сэргийлж, **анхааруулга, сануулга** болохын зэрэгцээ зөрчил гаргагчдад цээр зэмлэлийг төрүүлж нөлөө үзүүлнэ. Тухайлбал, торгох шийтгэл өндөр байх тусам зөрчил гаргагчийн сэтгэхүй, эд хөрөнгөнд халдахад зэмлэл цээр төрүүлэх зорилго болгоно. Энэ зорилго нь зөрчил үйлдсэн этгээдийг дахин зөрчил гаргахаас сэргийлж, хууль дээдлэх үзэл бодол, ухамсар, эрх зүйн соёлтой болоход нөлөөлнө.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Зөрчлийн тухай хуульд заасан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зарим зөрчилд хүлээлгэх шийтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх. Тухайлбал,
 - а. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчилд “тээврийн хэрэгсэл болоодох эрхийг 3-5 жилээр хасах, 1 000 000-2 000 000 төгрөгөөс дээш хэмжээгээр торгох”
 - б. Дахин согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил гаргахад баривчлах шийтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх. 1-2 сар хугацаагаар баривчлах, нийгэмд тустай ажил, хөдөлмөр хийлгэх, албадан сургалтад явуулах.
2. Зөрчлийн онооны гол үзэл баримтлалыг Зөрчлийн тухай хуульд тусгаж өгөх.
3. Жолоочид ур чадвар олгох сургалтад жолоочийн хариуцлага, хөдөлгөөний соёл эзэмшүүлэх сургалтыг бий болгох шаардлагатай байна.

Ашигласан материал

1. Монгол Улсын үндсэн хууль. Төрийн мэдээлэл. 1992 №01.
2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль. Төрийн мэдээлэл. 2015 оны №28
3. Замын хөдөлгөөнийн аюулгүй байдлын тухай хууль. Төрийн мэдээлэл. 1996 оны №7
4. Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл. 2017 оны №24
5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр /2019-2023/. Төрийн мэдээлэл. 2019 оны №34
6. Ган-Эрдэнэ.Г. Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх онол, практикийн зарим асуудал. Магистрын зэрэг горилсон бүтээл. УБ, 2016,
7. Даш.Т, Гончигсайхан.Ч, Баттулга.Б. Замын цагдаагийн албаны түүхэн тойм. УБ. 2006
8. Доржпалам.Х “Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих гэмт хэрэгтэй тэмцэх ЭЭЗ, криминологийн асуудал. УБ.2000
9. Дүгэрээ Д, Каукен.Ж Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэс.УБ., 1992
10. Жаргалсайхан.Ч “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын төлөө” сэдэвт илтгэл. ЦЕГ. Замын цагдаагийн газар. УБ., 2000 он.
11. Жаргалсайхан.Ч. Жолоодлогын тусгай талбай ашиглан жолооч бэлтгэх сургалтыг төгөлдөржүүлэх нь. Докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2002 он.
12. Энхболд А. Замын хөдөлгөөний аюулгүй байдал.Улаанбаатар. 2007
13. Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт 2018. Тээврийн цагдаагийн алба, УБ.,2020.

ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИ БА ЦАГДАА
LEGAL PHILOSOPHY AND THE POLICE

ДХИС-ийн Цагдаагийн Сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн багш,
докторант, цагдаагийн хошууч Д.Батдаваа

Police School of the University of Internal Affairs
Teacher and doctoral student of the
Department of Police
Law, police major D. Batdavaa

Хураангуй: Философийн тухай ойлголт тэр дундаа эрх зүйн философи нь цагдаагийн байгууллагад хамаарах хамаарлыг судалгааны үндсэн дээрээс тодруулан авч үзхийг зорьсон. Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын хувьд цагдаагийн байгууллагын үндэс суурь 3000 жилийн тэрээ грект би болсон гэж үздэг бөгөөд тухайн цаг үеээс өнөөдрийг хүртэл дэлхий нийтэд цагдаагийн байгууллагын баримталж байгаа үзэл баримтлал бол философийн асуудалтай шууд холбон авч үзэж болох юм.

Summary: The concept of philosophy, including the relationship of legal philosophy to the police organization, is intended to be clarified on the basis of research. It is believed that the basis of the police organization as an organization that implements the state functions was 3000 years ago in Greece, and the attitude of the police organization in the world from that time to today can be considered directly related to philosophical issues.

Түлхүүр үг: Цагдаа, философи, үнэн, хүн, төр, нийгэм

Key words: Police, philosophy, truth, people, state, society

Үндсэн хэсэг. Философи (эртний Грекийн φιλοσοφία, үгчилбэл "мэргэн ухааныг хайрлах; мэргэн ухааныг хайрлах") нь бодит байдлын ерөнхий шинж чанар, үзэл баримтлал, зарчмуудын талаарх мэдлэгийн тусгай хэлбэр, мэдлэгийн систем (оршихуй), түүнчлэн хүн төрөлхтний тухай мэдлэг юм. Хүн ба ертөнцийн хоорондын харилцаа¹³¹.

Олон зууны туршид философийн зорилтууд нь дэлхийн болон нийгмийн хөгжлийн түгээмэл хуулиудыг судлах, танин мэдэхүй, сэтгэлгээний үйл явцыг судлах, түүнчлэн ёс суртахууны категори, үнэт зүйлийг судалж байв. Философийн асуултуудын дунд жишээлбэл: "Бид ертөнцийг таньж чадах уу?", "Бурхан байдаг уу?", "Үнэн гэж юу вэ?", "Сайн гэж юу вэ?", "Хүн гэж юу вэ?", "Анхдагч зүйл юу вэ - матери эсвэл ухамсар?", "Амьдралын утга учир юу вэ?" болон олон асуултыг өөртөө багтаасан байдаг¹³².

Философи нь бие биенээхээ үзэл бодлыг эсэргүүцэж, нөхөж чадах янз бүрийн чиглэл хэлбэрээр оршдог¹³³. Сүүлийн үед философид метафизик, эпистемологи, ёс зүй, гоо зүй, улс

1. ¹³¹ D. Bob Gowin, Marino C. Alvarez. The Art of Educating with V Diagrams. — Cambridge University Press, 2005. — С. 52. — 231 с. — ISBN 052184343X.

¹³² Brooke Noel Moore, Kenneth Bruder. [Philosophy. The Power of Ideas](#). — 6th edition. — Mc Graw Hill, 2005. — 600 с. — [ISBN 0-07-287603-4](#).

¹³³ Ойзерман Т. И. Философия как история философии. — СПб.: Алетейя, 1999. — [ISBN 5-89329-067-4](#)

төрийн философи болон шинжлэх ухааны философи, дизайны философи гэх мэтээр салбарлан хөгжиж байна.

Хэрэгжүүлэх боломжтой арга зүйн парадигмыг боловсруулах мэдлэгийн салбарыг философиосийн шинжлэх ухааны салбарт судлан авч үздэг Жишээлбэл: физик, биологи, сэтгэл судлал нь эртний гүн ухаанаас үүссэн гэж үздэг¹³⁴.

XVII- XVIII зууны үеийн их сэтгэгч Ш.Л.Монтескье эрх мэдлийг хуваах онолыг үндэслэсэн Энэхүү онол ёсоор засаглалыг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх, гэсэн 3 салаа мөчирт хувааж энэ гурван эрх мэдэл нэг гарт төвлөрсөн нийгэм боолчлолд орно гэдгийг анхааруулжээ. Тэрээр үзэхдээ хууль тогтоох гүйцэтгэх засаглал нэг газарт байвал тогтоосон хуулийн хэрэгжилт алдарч дур зоргоороо авирлах явдал газар авна. Хууль тогтоох засаглал, шүүх засаглалтай хамт байвал хуулиуд гарсан хойноо шүүх засаглалын үйл ажиллагаанд хутгалдан ороход хүрнэ хэмээн үзжээ.

Эрх зүйн философийн талаар Германы хуульч Г.Гуго нь өөрийн бүтээл болох “эрх зүйн онолын философийн хэсэг”-т дараах байдлаар авч үзжээ.

- Эрх зүйн номнол
- Позитив эрх зүйн философи
- Эрх зүйн түүх гэсэн гурван хэсэгт хуваан авч үзсэн байна.¹³⁵ Эрх зүйн философиог хууль зүйн шинжлэх ухаан болох талаар тусгасан авч үзсэн.

Германы их сэтгэгч Гегелийн 1820 оны Эрх зүйн философи” зохиолдоо “Төрөлх эрх зүй ба Төр улсын тухай” эрдэм шинжилгээний өгүүлэл нийлүүлж байжээ. Мөн эрх зүйн философийн үндэс нэртэй бүтээлээ анхлан гарж байжээ. Эдгээр бүтээлүүд нь нийгэм, эрх зүй, улс төрийн хүрээнд сэтгэлгээг өөрчлөх томоохон алхам болсон гэж хэлж болох юм.

Эрх зүйн шинжилэх ухааны нэг салбар болох захиргааны эрх зүйн шинжилэх ухааны институтийн нэгэн салбарыг цагдаагийн эрх зүйг шинжлэх ухаан мөн гэж шинжлэх ухааны доктор Ж.Долгорсүрэн “Цагдаагийн эрх зүй нь эрх зүйн дэд салбар болохын хувьд захиргааны эрх зүйн тогтолцоонд үндэслэнэ”¹³⁶ гэж авч үзсэн байна.

Эрх зүйн философи нь хууль зүйн шинжлэх ухаан нэг салбар гэж эрдэмтэн, судлаачид авч үзсэнээс харахад хууль зүйн шинжлэх ухааны салбар судлагдахуун болгон өөрийн гэсэн философитой байж болно гэсэн дүгнэлт урган гарч ирж байна.

Цагдаа хэзээнээс би болсон бэ? , Цагдаа юу хийдэг бэ?, Цагдаа хүн мөн үү аль эсвэл төрийн төлөөл хууль сахиулах чиг үүрэгтэй субъект мөн үү? гэсэн асуултыг багтааж байна.

Цагдаа гэдэг үг нь " протополис" хот гэсэн утгатай грек хэлнээс гаралтай бөгөөд хязгаарлагдмал хэмжээгээр тодорхой биет байдлаар оршин тогтнож байсныг харуулж байна.

МЭӨ 3000 онд Египетэд цагдаагийн байгууллага байгуулагдсан байна¹³⁷. Цагдаагийн үйл ажиллагаа нь гурван үндсэн шинжтэй байв.

Нэгдүгээрт: Цагдаагийн байгууллага эвлэрүүлэн зуучлах, зөрчилдөөнийг шийдвэрлэх.

Хоёрдугаарт: Цагдаагийн үүрэг хариуцлагыг хуулиар хүлээсэн хүмүүс биелүүлдэг байжээ.

¹³⁴ Edward Craig. [Philosophy](#) // Nigel Warburton Philosophy. Basic Readings.. — Routledge, 2005. — С. 5—10. — ISBN 0-203-50642-1.

¹³⁵ Hugo. G.Beitrage zur civilistischen Bucherkenntnis.Bd.I, Berlin, 1929.S.372.

¹³⁶ Долгорсүрэн Ж. Цагдаагийн эрх зүйн курс. УБ., 2014. 6 дахь тал

¹³⁷ <https://www.britannica.com/topic/police>

Цагдаагийн эрх мэдэлтнүүд ерөнхийдөө нийгмийн элитэд харьяалагддаг байсан ч тэдний ажилд авсан хүмүүс нийгмийн янз бүрийн давхаргын гарал байсан тул цагдаагийн ажил эрхэлдэг хүмүүсийг нийгмийн доогуур давхаргын ажил гэж тооцогддог байв.

Гуравдугаарт: Цагдаа нар хог хаях, гал түймэр унтраах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх болон өөрийн ажил үүрэгт хамааралгүй олон төрлийн ажил үүргийг гүйцэтгэдэг байжээ.

Норманы байлдан дагуулалтаас өмнөх 1066 онд Английн цагдаагийн тогтолцоо нь олон нийтэд түшиглэсэн хариуцлагыг илэрхийлдэг байв. “Saxon frankpledge”-д заасан гэрээ гэж хэлж болох насанд хүрсэн бүх эрэгтэйчүүд бие биенээ хамгаалах болон тосгоны оршино суугчийг хамгаалахын тулд нэгдэхийг шаарддаг байв. Энэ үүргийг албан ёсны болгохын тулд арван хүнийг ахлуулсан аравтын тогтолцоог бий болгосон. Аравт бүрийг зуугаар бүлэглэсэн бөгөөд түүнийг захирагч, шүүгчийн аль нэг нь толгойлдог байв. Зуут тус бүрийг нэг болгон нэгтгэсэн бөгөөд үүнийг /ширээ-реве/ удирддаг байв. Шире-рийвийн үүрэг эцэстээ Англи болон АНУ-д тойргийн шерифийн орчин үеийн алба болж хөгжсөн. Парисийн хаан XIV Людовик анх 1666 онд орчин үеийн, үр ашигтай цагдаагийн тогтолцоог бүтээжээ.

АНУ-ын цагдаагийн байгууллага нь хууль сахиулах байгууллагад хамаарах бөгөөд эрүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх шүүхийн байгууллагаас өгсөн даалгаврыг биелүүлэх ажлыг хийж гүйцэтгэдэг байна. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, мөрдөн шалгах ажиллагаанд цагдаагийн байгууллагын бие даасан ажиллагааны нэг төрөл юм.

Цагдаагийн байгууллага нь засгийн газрын шууд удирдлагад үүрэг гүйцэтгэдэг.¹³⁸ Эдгээр агентлагуудын хууль сахиулах зорилго нь гэмт хэргийн үйлдлийг мөрдөн шалгах, шүүхийн мөрдөн байцаалтад шилжүүлэх, шүүхээс сэжиглэгдэж буй гэмт хэрэгтнийг түр саатуулах явдал юм. Цагдаагийн байгууллага нь засгийн газрын үүргийг хэрэгжүүлэхдээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлэхэд чиглэсэн үүрэгтэй байдаг.

Европын Цагдаагийн байгууллага нь хууль сахиулах агентлаг бөгөөд Европын Холбооны гишүүн орнуудад хууль сахиулах байгууллагууд нь Европын аюулгүй байдлыг хангахад туслах зорилготой юм. Европын аюулгүй байдлын хангах төв байгууллагын нэг нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа бөгөөд дараах үйл ажиллагааг явуулдаг байна. Үүнд:

- Хууль сахиулах үйл ажиллагааг гүйцэтгэх;¹³⁹
- Эрүүгийн гэмт хэргийн талаарх тоон мэдээллийг нэгтгэх тэдгээртэй тэмцэх;
- Үндэсний агентлагуудын мөрдөн байцаалтыг сайжруулахад чиглэсэн сүүлийн үеийн техник хэрэгслийг ашиглах;

Европын холбооны улсын дунд эрүүгийн гэмт хэргийн болон терроризмын нөхцөл байдалд тогтмол дүн шинжилгээ хийх.

ОХУ-ын Дотоод хэргийн яамны төвлөрсөн системийн салшгүй хэсэг юм. ОХУ-ын Дотоод хэргийн яамны журмын 14 дүгээр зүйл ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар ОХУ-ын Дотоод хэргийн яамны 248 тоот 248 тоот тушаалаар батлагдсан.

Цагдаа нь ОХУ-ын иргэний амьдрал, эрүүл мэнд, эрх, эрх чөлөөг хамгаалах, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хамгаалах зорилготой. гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, өмч хөрөнгийг хамгаалах, нийгмийн аюулгүй байдлыг хангахад оршино.

¹³⁸ https://en.wikipedia.org/wiki/Law_enforcement_in_the_United_States

¹³⁹ <https://translate.google.mn/?hl=mn#en/mn/The%20European%20Police>

Түүний бүрэн эрхийн хүрээнд ОХУ-ын Ерөнхийлөгч цагдаагийн байгууллага шууд буюу Дотоод хэргийн сайд, Дотоод хэргийн яамны харьяа нутаг дэвсгэрийн дарга нар, цагдаагийн газрын дарга нартай шууд манлайлан ажилладаг.¹⁴⁰ Удирдлагаас ирсэн шийдвэрийг цагдаагийн албан хаагчид биелүүлэх үүрэгтэй.

БНХАУ-ын олон нийтийн аюулгүй байдлын яам (БНХАУ нь цагдаагийн үүрэг гүйцэтгэх, нийгмийн дэг журам сахиулах, улс төрийн болон төрийн системийг хамгаалах, төрийн дээд манлайлал, төрийн чухал байгууламжуудыг хамгаалах үүрэгтэй. БНХАУ-ын гүйцэтгэх эрх мэдэл юм) , хэт даврагсдын эсрэг терроризмтай тэмцэх, Хятадад салан тусгаарлах үзлийн эсрэг тэмцэл. Дотоод хэргийн яам (МИНГ) нь бусад орнуудад адил үүрэг гүйцэтгэдэг.

Доктор Д.Таванжин Монголын цагдаагийн түүхийг авч үзэхдээ 1189-1640 он Их бага хаадын үеийн цагдаагийн алба, 1640-1864 он Манжийн үеийн цагдаа, 1864-1911 он Арван тавны цагдаагийн алба, 1911-1921 он Богд хаант засгийн үеийн цагдаагийн алба, 1921-1990 он Ардын хувьсгал, социалист тогтолцооны цагдаагийн алба, 1990 оноос Ардчилалын үеийн цагдаагийн алба¹⁴¹ гэж ангилж үзжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 7 дэх хэсэгт “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журам бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;”¹⁴² Засгийн газрын хэрэгжүүлэх чиг үүрэгт оруулж өгсөн байгаагаас харахад цагдаагийн байгууллага гүйцэтгэх эрх мэдэлд шууд хамааралтай байхаар зааж өгсөн байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн дөрөвдүгээр зүйлд “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн.” гэж хуульчилж өгсөн байна.

- ❖ Гэмт хэрэгтэй тэмцэх
- ❖ Нийтийн хэв журам хамгаалах
- ❖ Олон нийтийн аюулгүй байдлыг хангах
- ❖ Захиргааны чиг үүргийг дурдаж болно.

Эдгээр хэрэгжүүлж байгаагаар үйл ажиллагаанаас авч үзэхэд цагдаагийн байгууллага нь нийгмийн харилцааг зохицуулж байгаа төрийг төлөөлөх идвэхтэй субъект мөн.

Хариултын хувьд авч үзвэл нийгмийн харилцааны тэр дундаа эрх зүйн харилцааны субъект мөн бөгөөд “ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, нийтийн аюулгүй байдлыг хангах, хуулийн хяналт тавих олон талт үйл ажиллагааг зохион байгуулагч” гэсэн тодорхойлолтыг өгч болно.

Цагдаа үйл ажиллагаатай холбоотой философийн нэгдсэн ямар нэгэн судалгаа хийгдээгүй байна. Цагдаагийн философийн асуудлаар дагнан бичсэн ном, эрдэм шинжилгээний бүтээл одоогоор бараг алга. Иймд Цагдаагийн байгууллагын философийн талаарх мэдлэг, судалгаа шинжилгээг бий болгох “Эрх зүйн философийн судлагдахуун салбар судлагдахуун Цагдаагийн философийн үзэл баримтлал онол, арга зүйг ” тодорхойлохыг судлаачийн нарын зүгээс тусгайлан авч үзэхийг зорьсон билээ.

Доктор (Ph.D) Передерий, Анна Владимировна “Нийгмийн яриа хэлэлцээ нь цагдаагийн алба хаагчийн сэтгэлгээний соёлыг төлөвшүүлэх механизм.”¹⁴³, Философийн

¹⁴¹ Таванжин Д. “Цагдаа судлалыг анхаарах цаг болжээ” (Гэмт явдалтай тэмцэх асуудалд №03 Уб., 2003.

¹⁴² Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль

¹⁴³ Анна Владимировна “Нийгмийн яриа хэлэлцээ нь цагдаагийн алба хаагчийн сэтгэлгээний соёлыг төлөвшүүлэх механизм юм.” диссертаци., Краснодар 2014.,

ухааны доктор Вобликов, Андрей Борисович “Улс төрийн эрх мэдлийн механизм дахь дотоод хэргийн байгууллагууд: философи ба улс төрийн шинжилгээ”¹⁴⁴, Доктор (Ph.D) Лыков Эдуард Николаевич “Европын соёл дахь цагдаагийн практик: Философи ба антропологийн шинжилгээ”¹⁴⁵, Хууль зүйн ухааны доктор Павловский, Валерий Валерьевич “Хууль, дэг журмыг хангахад нийгэм, цагдаа (цэрэг) хоорондын харилцан үйлчлэл: онолын болон түүх-эрх зүйн шинжилгээ”, Философийн ухааны доктор Michael Mathura “Цагдаагийн албан хаагчдын олон нийтийн ойлголт”¹⁴⁶, Философийн ухааны доктор Kalamazoo, Michigan “Олон нийтийн цагдаагийн байгууллагын талаарх цагдаагийн ойлголтын шинжилгээ болон эмэгтэй албан хаагчид”¹⁴⁷ зэрэг эрдэмтэд тал бүрээс нь судалж авч үзсэн байна.

Цагдаа судлалын онол, практикийн асуудлыг цогц судлах, тэдгээрт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр Монгол Улсад Цагдаа судлалыг онол, арга зүйн үндсийг тодорхойлж, боловсронгуй болгох, практик байгууллага, ажилтнуудад зөвлөмж боловсруулахад оршино.

Дүгнэлт. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг анх үүсэн 3000 жилийн тэртээгээс өнөөдрийг хүртэл хийж гүйцэтгэж байгаа үйл ажиллагааг авч үзэхийг зорьсон. Цагдаагийн байгууллага бий болсон цаг үеээсээ төрийн системийн нэг салбар байсаар ирсэн нь судалгаанаас харагдаж байна.

Тэгвэл тухайн алба юу хийж ирсэнийг нэгтгэн авч үзвэл. Судалгаанд хамрагдсан улс орнуудын нөхцөл байдлаас дүгнэн үзэхэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, захиргааны хяналтын чиг үүргүүдийг хэрэгжүүлж байна.

Иймд цагдаагийн байгууллага үйл ажиллагаагаа гүйцэтгэхдээ өөрийн гэсэн философитой байгаа бөгөөд цаашид түүнийгээ хэрэгжүүлэх бодлого боловсруулах нь технологи, хиймэл оюун ухааны эрэн үед чухлаар тавигдаж байна. Цагдаа судлалын судалж авч үзэх нэг томоохон салбар бол Цагдаагийн философитой холбоотой үйл ажиллагаа гэж дүгнэн үзэж байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Философийн хүрээнд судалсан эрдэмтэн судлаачдын бүтээлийг ашиглаж судалгааг өргөжүүлэх.
2. Гадаад орнуудад судлагдсан мэдлэгийг ашиглаж анализ хийх,
3. Технологи, хиймэл оюун ухааны эрэн үед хэрхэн ажиллах цагдаагийн үйл ажиллагааг тодорхойлоход цагдаагийн философиин мэдлэгийг хөгжүүлэн ашиглах.

Ашигласан материал:

Монгол Улсын хууль:

1. Монгол улсын үндсэн хууль.
2. Цагдаагийн байгууллагын тухай хууль
3. Цагдаагийн албаны тухай хууль

Ном бүтээл:

¹⁴⁴ Вобликов, Андрей Борисович “Улс төрийн эрх мэдлийн механизм дахь дотоод хэргийн байгууллагууд: философи ба улс төрийн шинжилгээ” диссертаци., Специальность ВАК РФ 2000.,

¹⁴⁵ Лыков Эдуард Николаевич “Европын соёл дахь цагдаагийн практик: Философи ба антропологийн шинжилгээ” диссертаци Специальность ВАК РФ 2021

¹⁴⁶ Michael Mathura “Цагдаагийн албан хаагчдын олон нийтийн ойлголт” диссертаци Де Монфортын их сургууль, Лестер, Их Британи. 2019.,

¹⁴⁷ Kalamazoo, Michigan “Олон нийтийн цагдаагийн байгууллагын талаарх цагдаагийн ойлголтын шинжилгээ болон эмэгтэй албан хаагчид” диссертаци Баруун Мичиганы их сургууль.1997.,

4. Ж.Долгорсүрэн. Цагдаагийн эрх зүйн курс. УБ. 2014
5. Т.Хүрэлбаатар, Д.Чулуунбат. Монгол цагдаагийн байгууллагын түүхийн зарим баримт бичгүүд. УБ. 2011

Гадаад эх сурвалж:

6. D. Bob Gowin, Marino C. Alvarez. The Art of Educating with V Diagrams. — Cambridge University Press, 2005. — С. 52. — 231 с. — [ISBN 052184343X](#).
7. Brooke Noel Moore, Kenneth Bruder. Philosophy. The Power of Ideas. — 6th edition. — Mc Graw Hill, 2005. — 600 с. — [ISBN 0-07-287603-4](#).
8. Ойзерман Т. И. Философия как история философии. — СПб.: Алетейя, 1999. — [ISBN 5-89329-067-4](#)
9. Edward Craig. Philosophy // Nigel Warburton Philosophy. Basic Readings.. — Routledge, 2005. — С. 5—10. — [ISBN 0-203-50642-1](#).

Судалгааны ажил:

10. Анна Владимировна “Нийгмийн яриа хэлэлцээ нь цагдаагийн алба хаагчийн сэтгэлгээний соёлыг төлөвшүүлэх механизм юм.” диссертаци., Краснодар 2014.,
11. Вобликов, Андрей Борисович “Улс төрийн эрх мэдлийн механизм дахь дотоод хэргийн байгууллагууд: философи ба улс төрийн шинжилгээ” диссертаци., Специальность ВАК РФ 2000.,
12. Лыков Эдуард Николаевич “Европын соёл дахь цагдаагийн практик: Философи ба антропологийн шинжилгээ” диссертаци Специальность ВАК РФ 2021
13. Michael Mathura “Цагдаагийн албан хаагчдын олон нийтийн ойлголт” диссертаци Де Монфортын их сургууль, Лестер, Их Британи. 2019.,
14. Kalamazoo, Michigan “Олон нийтийн цагдаагийн байгууллагын талаарх цагдаагийн ойлголтын шинжилгээ болон эмэгтэй албан хаагчид” диссертаци Баруун Мичиганы их сургууль.1997.

Цахим эх сурвалж:

15. <https://www.britannica.com>
16. <https://en.wikipedia.org>
17. <https://translate.google.mn>